

ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР

ХОЙД МОГОЙН ГОЛ – ТЭЭЛИЙН ОРОН НУТГИЙН
ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН ЖИШЭЭН ДЭЭР



ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР

ХОЙД МОГОЙН ГОЛ – ТЭЭЛИЙН ОРОН НУТГИЙН
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ЖИШЭЭН ДЭЭР

У.Тунгалаг

Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Г.Эрдэнэцолмон

Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Ш.Мягмарсүрэн

Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Ц.Мөнхзул

Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Н.Мөнхтүвшин

Хойд Могойн гол-Тээлийн Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын
Нөхөрлөлийн холбоо

©Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг

Энэхүү бүтээлд илэрхийлсэн санал дүгнэлт нь Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн албан ёсны байр суурийг илэрхийлээгүй, төлөөлөхгүй болно.

Талархал: Тус бүтээлийг санхүүжүүлсэн Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газар, “Дарвины санаачилга” санд гүн талархал илэрхийлж байна.

Хэвлүүлсэн: Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн газар

Зохиогчид: У.Тунгалаг (1-3 дугаар бүлэг)
Г.Эрдэнэцолмон (2 дугаар бүлэг)
Ш.Мягмарсүрэн (3 дугаар бүлэг)
Ц.Мөнхзул (3 дугаар бүлэг)
Н.Мөнхтүвшин (3 дугаар бүлэг)

Хянан тохиолдуулсан: Б.Оюунгэрэл
Б.Оюунтүлхүүр

Хавтасны зураг: С.Гомбобаатар, Э.Батхүү

Гэрэл зургууд: Г.Эрдэнэцолмон, С.Гомбобаатар, Г.Цогтжаргал, Н.Мөнхтүвшин

Ишлэх: У.Тунгалаг, Г.Эрдэнэцолмон, Ш.Мягмарсүрэн, Ц.Мөнхзул, Н.Мөнхтүвшин (2021) Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийн загвар: Хойд Могойн гол – Тээлийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын жишээн дээр. Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн газар, Улаанбаатар, Монгол Улс

Хуулбарлах тухайд: Энэхүү бүтээлийг боловсролын болон бусад арилжааны бус зорилгоор хуулбарлах нь эх сурвалжийг бүрэн ишилсэн тохиолдолд зохиогчийн эрх эзэмшигчээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр ашиглахыг зөвшөөрсөн.
Энэхүү бүтээлийг дахин борлуулах болон бусад арилжааны зорилгоор зохиогчийн эрх эзэмшигчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дахин хуулбарлахыг хориглоно.

Холбоо барих: Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн газар, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-47, Монре импексийн байр, 302 тоот
Утас: 976- 77111138
Э-шуудан: tungalag.ulambayar@zsl.org

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ	5
ӨМНӨХ ҮГ	6
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	7
Тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолт	7
Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал	9
Тусгай хамгаалалттай газар нутгийн засаглал	13
Сайн засаглалын зарчмууд.....	15
Засаглалд оролцогч талууд	15
Менежментийн арга хэрэгслүүд.....	16
Менежментийн хүчин чадал	17
Засаглалын түвшин	18
МОНГОЛ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	22
ТХГН-ийн түүхэн уламжлал ба өнөөгийн байдал	22
ТХГН-ийн ангилал	30
ТХГН-ийн засаглал ба зарчим.....	34
ТХГН-ийн засаглалд оролцогч талууд	36
Менежментийн арга хэрэгсэл	36
Орон нутгийн тусгай хамгаалалттай газар	39
ХОЙД МОГОЙН ГОЛ – ТЭЭЛИЙН ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР	42
Товч танилцуулга	42
Биологийн олон янз байдал, экосистемийн үнэт зүйлс	43
Монгол тарвага	44
Баданга хүдэр.....	46
Идлэг шонхор.....	47
Талын бүргэд.....	48
ОНТХГ-ын хамгааллын үйл ажиллагаа	51
Нутгийн иргэдийн амьжиргаа сайн сайхныг дэмжих.....	52
Мэдээлэл, сургалт	53
Санхүүгийн үйлчилгээний хүртээмж	52
Амьжиргаа бизнес	55
Хойд Могойн гол – Тээлийн ОНТХГ-ын засаглал ба оролцогч талууд.....	56
Хойд Могойн гол – Тээлийн ОНТХГ-ын менежментийн арга хэрэгсэл	58
Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл	61
ОНТХГ-ын засаглалын зарчмын хэрэгжилт	67
Дүгнэлт, сургамж, зөвлөмж.....	68
АШИГЛАСАН БҮТЭЭЛ	71
ХАВСРАЛТ	72

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолтыг тайлбарласан нь	8
Хүснэгт-2. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, менежментийн зорилго, онцлог шинж чанар (БХОУХ)	10
Хүснэгт-3. Тусгай хамгаалалттай газар нутгийн засаглалын хэлбэр	14
Хүснэгт-4. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд оролцогч талууд	16
Хүснэгт-5. БХОУХ-ны ТХГН-ийн ангилал, засаглалын хэлбэрийг тодорхойлох матриц	20
Хүснэгт-6. ТХГН-ийн матрицыг ашиглан ТХГН-ийн системд өөрчлөлт хийсэн Мадагаскарын жишээ	21
Хүснэгт-7. Монгол Улсын ТХГН-ийн ангилал, зорилгыг БХОУХ-ны ангилалтай харьцуулсан нь	31
Хүснэгт-8. Монгол Улсын ТХГН-ийн засаглалд оролцогч талууд	36

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг-1. ТХГН-ийн ангиллыг байгалийн онгон зэрлэг байдал, эвдрэлийн зэрэглэлээр үзүүлсэн нь	12
Зураг-2. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар (ангиллын төрлөөр нийт ТХГН-т эзлэх хувь)	25
Зураг-3. 1992 оноос хойш тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	25
Зураг-4. 1992 оноос хойш Монгол Улсын нэгдэн орсон ТХГН-т хамааралтай НҮБ-ын конвенц, гэрээ хэлэлцээр	27
Зураг-5. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн байршил тархац (2021 оны эхний байдлаар)	28
Зураг-6. 1992 оноос хойш ТХГН-ийн асуудлаарх Байгаль орчны сайдын баталсан журмууд	29
Зураг-7. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын байршил	43
Зураг-8. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын тарваганы байршил	45
Зураг-9. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын тарваганы өсөлт (нөхөрлөлийн нутгаар) ...	45
Зураг-10. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын ургамалжлын зураг	50
Зураг-11. ОНТХГ-ын малчдын сүүлийн 3 жилд хийсэн нөхөн сэргээлтийн ажил	51
Зураг-12. Экосистемийн үйлчилгээ хүний сайн сайхан амьдралд нөлөөлөх нь	52
Зураг-13. Нөхөрлөлийн гишүүн өрхийн орлогын хүрэлцээний үнэлгээ	53
Зураг-14. Малчид байгаль хамгааллын сургалтад хамрагдсан байдлын үнэлгээ	54
Зураг-15. Байгаль хамгааллын ажлын ач холбогдлыг малчид үнэлсэн байдал	54
Зураг-16. Хуримтлалын сантай болсны ач холбогдлыг малчид үнэлсэн нь	55
Зураг-17. ОНТХГ-ын малчин өрхийн сарын орлогод гарсан өөрчлөлт (орлогын бүлгээр) ...	55
Зураг-18. ОНТХГ-ын малчин өрхийн сарын орлогод гарсан өөрчлөлт (төгрөгөөр)	56
Зураг-19. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын засаглалд оролцогч талууд, хамтын ажиллагаа	58
Зураг-20. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын Нөхөрлөлийн холбооны бүтэц	59
Зураг-21. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын БНХМ-ийн нөхөрлөлийн бүтэц	61

ТОВЧИЛСОН ҮГ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БГХ	Бүх гишүүдийн хурал
БНГ	Байгалийн нөөц газар
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХМН	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл
БО	Байгаль орчин
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БОЯБ	Биологийн олон янз байдал
БОЯБК	Биологийн олон янз байдлын тухай конвенц
БХОУХ	Байгаль хамгаалах олон улсын холбоо
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГҮТББ	Гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага
ДГ	Дурсгалт газар
ДЦГ	Дархан цаазат газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИБУИНВУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ИБХ	Идэвхтэн байгаль хамгаалагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЛАСН	Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг (ZSL)
МУИС	Монгол Улсын их сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр (UNDP)
ОНТХГ	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар
ОУ	Олон улс
ОХЯИ	Олон хэмжээст ядуурлын индикатор
ТББ	Төрийн бус байгууллага
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
САЙТИС	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)
УТХГН	Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг
УЗ	Удирдах зөвлөл
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХБСХ	Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)
ХЗ	Хяналтын зөвлөл

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс нутаг дэвсгэрийнхээ 30 хувийг тусгай хамгаалалтад авах зорилгодоо ойртож өнөөгийн байдлаар 21 хувийг хамгаалаад байна. ТХГН-ийн сүлжээг цаашид тэлэхэд нутгийн иргэдийн оролцоог хангаж тэдэнтэй хамтран ажиллах боломж бүрдүүлдэг орон нутгийн тусгай хамгаалалттай газрын ангилал дэлхийд улам газар авч олон улсын байгууллагуудын анхаарлыг татах боллоо.

Манай улсад сүүлийн хорин жилд аймаг, сумын засаг захиргаа, нутгийн иргэдийн санаачилгаар нутгийнхаа үзэсгэлэнт байгаль, ховор амьтны амьдрах орчин, тархац нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад (ОНТХ) авах нь ихээхэн нэмэгдсэн бөгөөд яах аргагүй төрийн бодлого, зохицуулалтын төвд байх ёстой асуудал болсон тул нийт газар нутгийн 14 хувьд хүрч өргөжин тэлж буй хамгаалалтын энэхүү ангиллын менежментийг боловсронгуй болгож холбогдох эрх зүйн баримт бичигт тусгах нь тулгамдаж буй зорилт болж байна.

Энэ утгаараа Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг (ЛАСН)-ээс гаргаж буй энэхүү бүтээл нь ОНТХГ-ын хамгаалал, үйл ажиллагаа, ач холбогдол зэрэг олон асуудалд тодорхой хариулт өгч байгаа төдийгүй, Монгол Улсын “Тусгай хамгаалалттай газрын тухай” хуулийг шинэчлэн боловсруулах, улмаар батлуулах ажил ид өрнөж буй үед гарч байгаагаараа чухал юм.

Номын нэгдүгээр бүлэгт, Байгаль Хамгаалах Олон Улсын Холбоо (БХОУХ)-ноос тодорхойлсон ТХГН-ийн менежментийн үндсэн ойлголт, ухагдахууныг иш үндэс болгон тайлбарласан нь орчин үеийн дэлхийн чиг хандлагатай нийцсэн ТХГН-ийн менежментийг Монгол Улсад нутагшуулах болон энэ талын ойлголтыг нэгтгэж, зөрчлийг арилгахад ач холбогдолтой мэдээлэл өгчээ.

Хоёрдугаар бүлэгт, ТХГН-ийн менежментийн загвар хүрээг ашиглан манай улсын ТХГН-ийн системд байдал ямар байгааг тоймлон дүн шинжилгээ хийж, эрх

зүй, институцийн тогтолцоонд буй сул тал, орхигдлыг үзүүлсэн нь одоогийн хуулийн шинэчлэл хийх ажилд нэмэр болохуйц сайн мэдээлэл болжээ.

Гуравдугаар бүлэгт, ЛАСН-ээс Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ыг чадавхижуулан менежментийн загвар гаргаснаа тайлагнан үзүүлжээ. БХОУХ-ны менежментийн жишиг загварын дагуу тайлбарласнаас загвар болгохоор сонгосон тус ОНТХГ-т байгалийн болоод соёлын үнэ цэнийг хамгаалах институц, засаглалын үйл явц буй болсныг харж болохоор байна.

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ыг хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулсан хүний хувьд экологийн чухал ач холбогдол бүхий энэ газар ийнхүү хамгаалагдаж зэрлэг амьтны тоо толгой өсөн нэмэгдэж малчдын амьжиргаа сайжирч, хамгаалалтад авсны гол зорилго биеллээ олж байгаад маш баяртай байна.

Суут эрдэмтэн Чарльз Дарвин ажиллаж асан, мөдхөн 200 жилийн ойдоо хүрэх гэж байгаа дэлхийн байгаль хамгааллын ууган энэ байгууллага манай улсын байгаль хамгаалалд гар бие оролцож, тулгамдсан асуудлын нэг болоод байгаа ОНТХГ-ын болон ТХГН-ийн менежментийн асуудлаар байр суурь, санал зөвлөмжөө энэхүү номоор дамжуулан хуваалцаж байгаад талархаж байна. Өмнөх бүлгүүдийн дүн шинжилгээнд үндэслэн номын төгсгөлд гаргасан дүгнэлт, цаашид анхаарах шаардлагатай үйл ажиллагааны санал, зөвлөгөө нь ТХГН-ийн менежментэд оролцогч хэн бүхэнд хэрэгтэй, авууштай асуудлууд байгааг онцлон тэмдэглэж байна. Ингээд ЛАСН-ийн хамт олны байгаль хамгааллын өргөн цар хүрээтэй, өндөр зорилготой гэгээн сайхан үйлсэд нь амжилт хүсье.

Б.Оюунгэрэл

Газарзүйн шинжлэх ухааны доктор (ScD)

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Дэлхийн гадаргын 29 хувь нь хуурай газар, 71 хувь нь усан бүрхүүлтэй бол, энэхүү хуурай гадаргын 15,4 хувь, усан гадаргын 19,0 хувь нь тусгай хамгаалалтад байдаг (I. a. N. UNEP-WCMC, 2021). Сүүлийн 40 жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд тусгай хамгаалалттай нутгийн талбай Их Британийн нутаг дэвсгэрийн хэмжээнээс Өмнөд Америкийн нутаг дэвсгэртэй дүйцэхүйц хэмжээнд хүрч томорсон байна (Dudley, 2008). Дэлхийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн стандартыг тогтоодог нэр хүндтэй байгууллага болох **Байгаль хамгаалах олон улсын холбоо** (БХОУХ *англ.* IUCN)-ноос тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН)-ын удирдлагын асуудлаар олон баримт бичиг, гарын авлага боловсруулсныг Дэлхийн ТХГН-ийн Комисс (World Commission for Protected Areas)

болон Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), түүний Биологийн олон янз байдлын конвенц (БОЯБК)-ийн газар хүлээн зөвшөөрч баталсан. БХОУХ-ны эдгээр баримт бичигт тусгасан ТХГН-ийн менежментийн стандартыг дэлхий даяар хамгаалалттай газрын үйл ажиллагааг зохицуулах чиглэл болгон ашиглаж ирлээ. Энэ жишгээр Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн өнөөгийн ангилал, менежмент, засаглалын байдал болон Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол – Тээлийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгааллын менежментийн загварыг тайлбарлахдаа БХОУХ-ноос тогтоосон тодорхойлолт, ангилал, зарчим, менежментийн арга хэрэгслийн зарчмыг гол үндэслэл болгон ашиглалаа.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1933 оноос эхлэн дэлхийн олон орны эрдэмтэн мэргэд, судлаачид, менежерүүдийн оролцоотой шат дараалалтай хийсэн хэлэлцүүлэг, саналыг үндэслэн ТХГН-ийг дараах байдлаар тодорхойлжээ.

Байгалийг экосистемийн үр өгөөж, соёлын үнэ цэнийн хамт урт хугацаанд хуулиар болон бусад үр дүнтэй арга хэлбэрээр хамгаалах зорилготой, хүлээн зөвшөөрөгдсөн, тусгайлсан, удирдлага, зохион байгуулалт бүхий, хил хязгаар нь тодорхой газарзүйн орон зайг **тусгай хамгаалалттай газар нутаг** гэнэ (Dudley, 2008, p. 8).

Энэхүү тодорхойлолт нь зарчмын олон чухал утга санааг зангидан шингээсэн учир уг ухагдахуун бүрээр нь БХОУХ тайлбарласан байдгийг Хүснэгт-1-д оруулав.

Хүснэгт-1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолтыг тайлбарласан нь
(Dudley, 2008, pp. 8-9)

Тодорхойлолтод орсон ухагдахуун	Ухагдахууны тайлбар
Байгаль (<i>nature</i>)	Энэхүү тодорхойлолтод "байгаль" гэдэг нь генетикийн, зүйлийн, экосистемийн түвшний биологийн олон янз байдлыг хэлэх бөгөөд гео-олон янз байдал (газарзүйн олон янз байдал), газрын хэв шинж, байгалийн үнэ цэнийг илүү өргөн утгаар давхар илэрхийлнэ.
Экосистемийн үйлчилгээ (<i>ecosystem services</i>)	Экосистемийн үр өгөөж гэдэг нь байгаль хамгаалах зорилготой холбоотой боловч тус зорилгод харшлахгүй экосистемийн үйлчилгээ өгөөжийг хэлнэ. Эдгээрт экосистемийн үндсэн дөрвөн үр өгөөж орно: үүнд, хоол хүнс, ундны ус зэрэг хангах үйлчилгээнээс гадна үер, ган, газрын доройтол, өвчин эмгэгээс сэргийлэх зохицуулах үйлчилгээ, мөн хөрс үүсэх, идэш шим тэжээлийн мөчлөг зэрэг дэмжих үйлчилгээ; амралт зугаалга, шашин шүтлэг, ёс заншил зэрэг материаллаг бус соёлын үйлчилгээ багтана (MEA, 2005).
Соёлын үнэ цэнэ, үнэт зүйл (<i>cultural values</i>)	Соёлын үнэт зүйл гэдэг нь байгаль хамгааллын үйл ажиллагаанд саад учруулахгүй үнэт зүйлс (тусгай хамгаалалттай газар нутгийн соёлын үнэт зүйлс энэ шалгуурыг хангасан байх ёстой) юм. Үүнд: ■ байгаль хамгаалалд ач холбогдолтой, хувь нэмэр оруулахуйц үнэт зүйлс (жишээлбэл, түлхүүр зүйлүүдийг хадгалахад гол нөлөөтэй уламжлалт зан үйл, арга барил, үйл ажиллагаа); ■ устах магадлалтай, тодорхой хэмжээнд аюул заналд өртөж байгаа үнэт зүйлс мөн орно
Урт хугацааны (<i>long-term</i>)	Энэ нь тусгай хамгаалалттай газар нутагт богино хугацаагаар түр зуур менежмент хийх биш урт удаан хугацаанд өнөд зохион байгуулж удирдана гэсэн утгатай.
Хуулиар болон бусад үр дүнтэй арга хэлбэрээр (<i>legal or other effective means</i>)	Энэ нь тусгай хамгаалалттай газар нутгийг хууль эрхийн актаар болон олон улсын гэрээ конвенц, хэлэлцээрээр хуульчлан хүлээн зөвшөөрөх, эсхүл хууль ёсны биш ч ихээхэн үр дүнтэй нийтээр ёсчлон сахидаг уламжлалаар, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй ТББ-ын бодлогоор зэрэг бусад арга хэлбэрээр удирдан зохион байгуулах гэсэн үг.
Хамгаалах зорилготой (<i>to achieve conservation</i>)	Хамгаалалтад авснаар үр ашгийн тодорхой түвшинд хүрэх гэсэн санаа. Үүнийг тусгай хамгаалалттай газар нутгийн менежер, мэргэжилтнүүдийн саналаар 1994 оноос хойш шинээр дээрх тодорхойлолтод нэмж оруулсан байдаг. Ингэснээр ТХГН-ийн ангилал нь менежментийн зорилгоосоо хамаарах нь хэвээр байх боловч менежментийн үр ашгийг Дэлхийн ТХГН-ийн мэдээллийн санд нэгтгэн бүртгэж, яваандаа хамгаалах газар нутгийг тогтоох, ач холбогдлыг тодорхойлоход чухал шалгуур үзүүлэлт болгох юм.
Хүлээн зөвшөөрөгдсөн (<i>recognized</i>)	Тусгай хамгаалалт нь төр болон төрөөс хүлээн зөвшөөрсөн байгууллага, иргэдээс тогтоосон засаглалын ямар ч хэлбэртэй байж болох ч гол нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байна (жишээ нь Дэлхийн ТХГН-ийн мэдээллийн сангийн жагсаалтад орох гэх мэт).
Тусгайлсан (тусгай зориулалтын) (<i>dedicated</i>)	Байгаль хамгааллын урт хугацааны үүрэг амлалт, хариуцлагыг дараах хэлбэрээр хүлээдэг гэсэн үг. Үүнд: ■ Олон улсын конвенц, гэрээ хэлэлцээрээр ■ Улсын хууль тогтоомж, бүс нутгийн болон орон нутгийн журам дүрмээр ■ Нутгийн уламжлал ёс заншил, жаягаар ■ ТББ-ын гэрээгээр ■ Хувийн компани, итгэмжлэх сангийн журам, дүрмээр ■ Тусгай зөвшөөрөл, лиценз олгох зохицуулалтаар

Удирдлага зохион байгуулалттай (<i>managed</i>)	Тусгай хамгаалалтад авсан байгалийн үнэт зүйлийг хадгалах, хамгаалахад чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Үүнд тухайн газар дээр ямар ч үйл ажиллагаа явуулалгүй хөндөхгүй орхих нь хамгааллын хамгийн сайн арга гэж үзсэн шийдвэр ч мөн орж болно.
Хил хязгаар тодорхой (<i>clearly defined</i>)	Хил хязгаар нь тодорхой гэдэг нь зөвшилцөж хил хязгаарыг тэмдэглэж заагласан, орон зайн хувьд тодорхой газар гэсэн үг. Ингэж хил хязгаарыг тогтоохдоо цаг хугацааны хувьд хөдөлгөөнд оршдог физик шинж чанар (жишээлбэл, голын эрэг)-ийг ашиглах, эсвэл менежментийн үйл ажиллагаагаар (жишээлбэл, ан ав хориотой бүсээр) нь тодорхойлж болно.
Газарзүйн орон зай (<i>geographical space</i>)	Үүнд газар, гадаргын ус, далай ба эрэг орчмын газрууд, эсвэл эдгээрийн хослол орно. "Орон зай" нь гурван хэмжээстэй, жишээлбэл, хамгаалсан газрын дээрх агаарын орчныг бага оврын онгоц зэргээс хамгаалсан, харин далай тэнгисийн хувьд усны тодорхой гүн, эсвэл ёроолын дэвсгэр газар нь хамгаалалтын горимд хамаардаг хэр нь дээрх гадаргын ус хамгаалалтад ороогүй байх боломжтой.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН АНГИЛАЛ

ТХГН-ийн тодорхойлолт гарч дэлхий даяар нэгдсэн ойлголттой болсонтой зэрэгцэн тухайн газрын менежментийн зорилгоос нь хамааран зургаан ангилалд хуваан үзэж тус бүрийн хамгааллын зорилго, онцлог ялгааг тогтоон баталсан байдаг. Ингэж ангилах нь ТХГН-ийг шинээр байгуулах, менежмент хийх болон менежментийн төлөвлөгөө боловсруулах дэлхийн стандарт тогтоож буй хэрэг гэж үздэг (Dudley, p. 6). Ялангуяа, ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг боловсронгуй болгох, менежмент хэрхэн хийх талаар мэдээлэл өгөх, нэгдмэл нэр томьёо, ухагдахууныг дэлхий даяар мөрдөх, шаардагдах мэдээллийн сан, төрөл зүйлийг тодорхой болгох, хамгааллын стандарт үйл ажиллагааг зохицуулах, ерөнхий чиглэл өгөх үндсэн зорилготой.

БХОУХ-ноос тодорхойлсон ТХГН-ийн дараах зургаан ангилал байдаг:

I. Дархан цаазат газар:

Ia. Дархан цаазат байгалийн нөөц газар (Strict Nature Reserve)

Iб. Онгон зэрлэг газар (Wilderness Area)

II. Үндэсний парк (National Park)

III. Байгалийн дурсгалт газар (Natural Monument)

IV. Биологийн төрөл зүйл, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах газар (Habitat/ Species Management area)

V. Хамгаалалттай ландшафт (Protected Landscape)

VI. Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт бүхий хамгаалалттай газар (Protected Area with Sustainable Use of Natural Resources)

Эдгээр зургаан ангилал нь менежментийн зорилгын хувьд ялгаатай, бие биеэсээ өөр онцлог шинж чанартай учраас тус бүрийн тодорхойлолтыг Хүснэгт-2-т нарийвчлан үзүүлээ. Энэхүү хүснэгтэд БХОУХ-ны гарын авлагад буй агуулгыг эмхэтгэн оруулсан болно (Dudley, 2008, pp. 11-23).

Хүснэгт-2. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, менежментийн зорилго, онцлог шинж чанар (БХОУХ)


Анги- лал	Менежментийн үндсэн зорилго	Онцлог шинж чанар
1а. Дархан цаазат байгалийн нөөц газар	Бүс нутаг, үндэсний болон дэлхийн хэмжээний ач холбогдол бүхий экосистем, зүйлүүд болон хүнээс ангид байгалийн жамаар буй болсон ч хүний сөрөг нөлөөнд өртөмтгий газарзүйн олон янз байдал, онцлог шинж чанарыг хамгаалах зорилготой	- Экологийн ач холбогдолтой нягтшил бүхий, нутгийн унаган зүйлийн иж бүрдэлтэй байх, эсхүл байгалийн жам ёсны үйл явцаар болон богино хугацааны үйл ажиллагаагаар унаган зүйлийг тийм нягтшилд хүртэл нөхөн сэргээх чадамжтай байх, - Экологийн үйл явцын хувьд хөндөгдөөгүй, нутгийн унаган экосистемийн бүрдэлтэй байх эсхүл менежментийн арга хэмжээгээр экологийн үйл явц нь богино хугацаанд нөхөн сэргэх чадамжтай байх, - Хүний аливаа үйл ажиллагаанд өртөхгүй, хүн ирдэггүй, суурьшил хориотой тул байгаль хамгааллын зорилгоо хэрэгжүүлэх боломжтой байх, - Байгаль хамгааллын зорилгоо хэрэгжүүлэхэд далайцтай байнгын арга хэмжээ шаардахааргүй байх, - Боломжтой бол, байгаль хамгааллын зорилгод нэмэр болохуйц газар ашиглалтын хэлбэр эргэн тойронд нь зонхилох, - Хүний үйл ажиллагааны нөлөөллийг хянахад суурь үзүүлэлт болохуйц байх, - Хүний хөл хөдөлгөөн маш багатайгаар менежмент явуулах боломжтой, - Аливаа гэнэтийн цочрол, аюул гамшгийг түр тогтоон барих менежмент хийх боломжтой (ялангуяа, далай тэнгисийн орчинд)
1б. Онгон зэрлэг газар	Хүний нөлөөнд өртөөгүй, байгалийн үзэгдэл үйл явц зөвхөн ноёрхдог онгон газрын экологийн бүрэн бүтэн байдлыг өнө удаан хамгаалах замаар өнөөгийн болон ирээдүй хойч үеийнхэнд үзэсгэлэнт байгалийг үзэх аялах боломжийг тэгш хүртээх зорилготой	- Зам, шугам хоолой, цахилгаан дамжуулах шугам, үүрэн телефоны цамхаг, газрын тос/хийн тавцан, терминал, бусад суурин байгууламж, уул уурхай, усан цахилгаан станц, газрын тос, байгалийн хий зэрэг орчин үеийн дэд бүтэц, хөдөө аж ахуй (эрчимжсэн мал аж ахуй, арилжааны загас агнуур), үйлдвэрлэлийн болон олборлолтын үйл ажиллагаанаас ангид байх, - Экосистемийн унаган төрх нь харьцангуй хадгалагдан үлдсэн, амьтан болон ургамлын аймгийн бүрдэл бүрэн буюу бараг бүрэн, махчин- өвсөн тэжээлтний тэнцвэртэй системтэй эрүүл бүрэн бүтэн байдлын өндөр зэрэглэлд орох, - Экологийн үйл явц, экосистемийн өгөөжийг хадгалж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг тогтоон барьж чадах, эволюцын үйл явцыг дэмжих хэмжээнд биологийн олон янз байдлыг хамгаалахуйц томоохон хэмжээтэй байх, - Ганцаараа нам гүм орчинд тааваараа амрах гайхалтай боломжийг буй болгох, чимээ аниргүй аяллын орчныг бүрдүүлэх (өөрөөр хэлбэл, мотор хөдөлгүүргүй тээврийн хэрэгсэл ашиглах, эсвэл шаардлагатай тохиолдолд зөвхөн тусгай замаар хязгаарлагдмал байдлаар моторт тээвэр хэрэглэх зэргээр дээр дурдсан хамгааллын зорилгод нийцүүлэх), - Онгон зэрлэг байдлыг хадгалахын тулд хүний нөлөөнөөс хол, ашиглалт үгүй байлгаж менежментийн зорилгоо биелүүлэх. Энэ ангилалд оруулах гол шалгуур үзүүлэлт бол биологийн хувьд хөндөгдөөгүй байгалийн унаган төрх, аливаа дэд бүтэц, хөдөө аж ахуй, моторт тээврийн хэрэгсэл зэрэг орчин үеийн техник технологиос ангид байх явдал юм. - Зарим нэг байдлаар өөрчлөлтөд орсон ч унаган байдалдаа эргэн орж нөхөн сэргэх боломжтой газрууд, эсхүл багахан ч гэсэн тухайн хамгаалалттай газрын системдээ ихээхэн ач холбогдол бүхий цаашид өргөтгөж болохуйц газрууд орно.

II. Үндэсний парк	Биологийн олон янз байдлыг түүний үндэс суурь болох экологийн бүтэц, тэдгээрийг дэмжигч байгалийн үйл явцтай нь цогцоор нь хамгаалах, иргэдийн байгаль орчны боловсролтой болох, амралт чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх боломжоор хангах зорилготой.	Ургамал, амьтны унаган зүйлүүд, тэдгээрийн амьдрах орчин, газарзүйн олон янз байдал нь шинжлэх ухааны, боловсролын, шүтлэгийн, аялал зугаалгын болон жуулчлалын үнэ цэнэтэй, биологийн болоод байгаль орчны үзэмжээрээ экологийн гол бүсчлэлийг төлөөлөхүйц газрууд багтана. Үүнд: - Унаган зүйл, бүлгэмдлийн урт хугацаанд оршин тогтнох байдал, экосистемийн үйл явц, үүргийг менежментийн үйл ажиллагаа шаардахгүйгээр хадгалж болохуйц экологийн хувьд ач холбогдолтой, хангалттай том хэмжээний газар байх. - Биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн, бүтэц, үүрэг нь “байгалийн унаган” байдлаараа, эсхүл харь зүйл ноёрхох эрсдэл багатайгаар эхний байдалдаа эргэн орж сэргэх боломжтой газар.
III. Байгалийн дурсгалт газар	Байгалийн өвөрмөц тогтоц, орчмын биологийн олон янз байдал, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах	III ангилалд дараах газрууд орно: - Хүрхрээ, хясаа цохио, галт уулын тогоо, агуй, элсэн манхан, хөндий цайдам далайн ёроолын уулс, шүрэн бүтэц зэрэг геологийн болон геоморфологийн тогтцууд; - Агуйн оромж, эртний бичээс хадны сүг зураг зэрэг соёлын ул мөр бүхий байгалийн тогтоц; - Тахилгатай газар, булш хиргисүүр, хүрхрээ, аварга мод хад зэрэг нийгмийн тодорхой хэсэгт сүсэг бишрэлийн үнэ цэнэ бүхий байгаль-соёлын газрууд; - Тухайн экологийн тогтоцтой холбоо бүхий соёлын өвийг хамгаалахад цаана нь ихээхэн ач холбогдол бүхий биологийн зүйл давхар хамгаалагддаг газрууд, жишээ нь, тухайн байгальтай холбоотой археологийн болон түүхийн дурсгалт газар.
IV. Биологийн олон янз байдал, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах газар	Биологийн зүйлүүд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх зорилготой.	Ангилал IV-ийн ТХГН нь дараах олон янз байдал, амьдрах орчныг хамгаалах нөхөн сэргээх учиртай: 1) олон улсын, үндэсний, орон нутгийн ач холбогдолтой ургамлын зүйлүүд; 2) олон улсын, үндэсний, орон нутгийн ач холбогдолтой амьтны зүйлүүд (суурин ба нүүдлийн зүйлүүд орно), 3) тэдгээрийн амьдрах орчин ТХГН нь хэмжээний хувьд янз бүр ч энэ ангилалд голдуу бага талбайтай нь хамрагддаг. Энэ ангиллын ТХГН нь экосистемийн тодорхой хэсгийг хамрах нь түгээмэл учир бие даан оршиг тогтнох боломж хязгаарлагдмал, менежментийн байнгын идэвхтэй арга хэмжээ авч байж тухайн зүйлийг болон амьдрах орчныг хамгаалан авч үлдэх боломжтой. Үүнд дараах орно: - Аюулд өртөөд буй зүйлийг хамгаалах (жишээ нь: хамгийн сүүлийн популяци байж болно); - Амьдрах орчныг хамгаалах, ихэнх тохиолдолд тухайн экосистемийн нэг хэсгийг хадгалах, нөхөн сэргээх, - Зорилтот зүйлийг хамгаалахын тулд хиймэл амьдрах орчин (жишээ нь хиймэл шүрэн бүлгэмдэл үүсгэх) бий болгох, нэмэгдэл тэжээл өгөх зэрэг арга замаар менежментийн идэвхтэй арга хэмжээ авч зүйлийн боломжит тоо толгойг тогтоон барих, - Байгалийн онгон төрхтэй болоод онгон байдлаа харьцангуй хадгалсан экосистем, амьдрах орчин нь хэт жижиг эсхүл нэлээд өөрчлөлтөд орсны улмаас жамаараа өөрөө сэргэх боломжгүй бол тэдгээрийг хадгалахын тулд идэвхтэй менежмент хийх, - Тухайлбал өвсөн тэжээлтэн үгүй бол мал оруулах, эсвэл өвсийг гараар хадах, эсхүл усны горим өөрчлөлттэй бол хиймэл суваг шуудуу татах гэх мэт. - Тухайн биологийн олон янз байдлыг дагасан соёлын онцлогтой экосистемийн идэвхтэй менежмент хийж олон янз байдлыг хамгаалах:

V.Хамгаалалттай ландшафт	Чухал ач холбогдол бүхий ландшафт/усан мандал болон хүн байгалийн шүтэлцээгээр буй болсон уламжлал, заншилд оршдог үнэт зүйлсийг хамгаалах, үргэлжлүүлэх зорилготой.	V ангиллын ТХГН нь биотик, абиотик орчин ба хүний үйл ажиллагааны харилцан шүтэлцээнд үндэслэдэг тул дараах шинж чанартай байна: ■ Ландшафт/далайн эргийн болон арлын үзэсгэлэнтэй өвөрмөц тогтоц, амьтан ургамлын аймаг, амьдрах орчны хувьд болон соёлын онцлог бүхий газар, ■ Он цагийн шалгуурыг давсан хүн-байгалийн тэнцвэртэй харилцан шүтэлцээ, бүрэн бүтэн байдал нь хэвээрээ эсхүл тийм бүрэн бүтэн байдлыг нь эргүүлж сэргээх боломжтой, ■ Газар нутгаа ашиглах өвөрмөц уламжлалт арга барилтай, жишээлбэл, ХАА, ойн тогтвортой систем, эсхүл газарзүй, ландшафттайгаа нарийн зохицож тэнцвэртэй хөгжсөн амьдралын хэв маягтай.
VI.Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт бүхий хамгаалалттай газар	Байгалийн нөөцийг зохистой ашиглах замаар экосистемийг хамгаалах, улмаар зохистой ашиглалт, байгаль хамгааллыг зөв хослуулах зорилготой.	БХОУХ-ны ангилалд зөвхөн ангилал 6 нь байгалийн нөөцийг тогтвортой ашиглах замаар байгаль хамгаалах зорилготойгоороо онцлог. Энэ нь тухайн газрын байгальтай холбоотой соёлын үнэ цэнийг хамгаалах зорилгыг багтаадаг тул хэмжээний хувьд томоохон байх нь цөөнгүй. ■ Энэ ангиллын газарт үйлдвэрлэлийн түвшний ашиглалт их хэмжээгээр явуулахыг хориглодог. ■ БХОУХ-ноос ийм газрын тодорхой хувьд аливаа ашиглалтыг хориглохыг зөвлөмж болгодог. Тухайлбал, нийт газрын гуравны хоёрт аливаа эдийн засгийн үйл ажиллагааг хориглох гэх мэт. Ийм шийдвэрийг тухайн улс, орон нутаг, ТХГН-ийн онцлог тааруулан өөрсдөө зохицуулахаар заажээ.

ТХГН-ийн менежментийн зургаан ангиллын хооронд ямар нэг зэрэг дэв, шат дараалал байх ёсгүй гэдгийг БХОУХ-ноос онцолдог бөгөөд харин онгон зэрлэг хөндөгдөөгүй байдал (*naturalness*) болон өөрчлөлт эвдрэлд өртсөн байдлын (*environmental modification*) хувьд тэдгээр нь хэрхэн хоорондоо ялгарахыг Зураг-1-д үзүүлсэн байна.

Зураг-1. ТХГН-ийн ангиллыг байгалийн онгон зэрлэг байдал, эвдрэлийн зэрэглэлээр үзүүлсэн нь



Эх сурвалж: (Dudley, 2008, p. 24)

Зургаас үзэхэд онгон зэрлэг унаган төрхөө хадгалсан байдлаараа Ia/b ба II/III хамгийн дээгүүр орж харин IV, VI нь онгон зэрлэг байдлын хувьд нэг түвшинд байгаа ч IV нь өөрчлөлтөд илүү орсон газар байдаг

нь харагдаж байна. Харин V ангиллын хамгаалалттай ландшафт нь эдгээрийн дундаас өөрчлөлтөд хамгийн их орж онгон зэрлэг байдлаа хамгийн их алдсан газар байдаг ажээ.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ЗАСАГЛАЛ

Дэлхий даяар биологийн олон янз байдал асар хурдацтай устаж, зүйлийн популяци цөөрч байгаа өнөө үед тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол тэр чинээгээр өсөн нэмэгдэж улмаар ТХГН-ийн засаглалын асуудал илүү хурцаар тавигдах боллоо. НҮБ-ын Биологийн олон янз байдлын конвенц (БОЯБК)-ийн талуудын бага хурлуудаар засаглалын асуудлыг удаа дараа авч хэлэлцэн Талуудын 2010 оны 10 дугаар хурлаар “2011-2020 оны стратеги төлөвлөгөө” буюу “Айчигийн 20 зорилт”-ыг баталсан байдаг. Үүнд, зорилт 11, 14, 18 нь засаглалын асуудлыг онцгойлон авч үзсэн дэлхийн улс орнуудад ТХГН-ийн засаглалыг сайжруулах чиглэл болсон заалтууд юм. Түүнчлэн ТХГН-ийн засаглалыг сайжруулахад 2004 онд баталсан БОЯБК-ийн **ТХГН-ийн үйл ажиллагааны хөтөлбөр** (YAW англ. Programme of Work on Protected Areas) ихээхэн ач холбогдолтой. Иймээс энэ салбарт ажиллаж буй ажилтнуудын хувьд засаглал хэмээх ухагдахууныг зөв ойлгохоос ТХГН-т засаглалыг сайжруулах ажил эхэлнэ.

Сайн засаглалгүйгээр тухайн газар нутгийн экологийн болон соёлын үнэ цэнийг урт хугацаанд хамгаалах ТХГН-ийн зорилгыг хэрэгжүүлэх боломжгүй. Эрх мэдлийн хүрээнд хүчин төгөлдөр шийдвэр гарч талууд үйл ажиллагаа явуулж буй газар бүрд засаглал хэрэгжиж байдаг. Иймд **ямар зорилгоор, юуг, хэрхэн хийхийг, хэн** шийдэж байгаа

болон шийдвэрээ **ямар хэлбэрээр** гаргаж байгаа, хэнд **эрх мэдэл, хүчин чадал, хариуцлага** байна, хэнтэй **хариуцлага тооцож** байна гэдэг бол бүгд засаглалын асуудал юм. Харин менежмент бол тухайн зорилгод хүрэхийн тулд ямар үйл ажиллагааг ямар арга хэрэгсэл, хэлбэрээр гүйцэтгэж буй тухай асуудал болно. Иймд засаглалыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Иргэд болон бусад оролцогч талууд саналаа хэлж, шийдвэрүүд гарч, эрх мэдэл, хариуцлага хэрэгжих орчинг бүрдүүлдэг бүтэц тогтолцоо, тэдгээрт холбогдох үйл явц, тогтсон уламжлалын хоорондох харилцан үйлчлэлийг засаглал гэнэ (Borrini-Feyerabend et al., 2013).

Үүнээс үүдэн ТХГН-ийн засаглалын хоёр хэмжээс байдаг бөгөөд эхнийх нь **засаглалын хэлбэр** юм. Засаглалын хэлбэр нь гол шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлага, үүрэг хэнд байгааг тодорхойлдог. БХОУХ-ноос ТХГН-ийн засаглалын дараах дөрвөн хэлбэрийг тодорхойлсон:

- А. Төрийн байгууллагын засаглал
- Б. Хамтын засаглал
- В. Хувийн засаглал
- Г. Уугуул болон нутгийн иргэдийн засаглал

Хүснэгт-3. Тусгай хамгаалалттай газар нутгийн засаглалын хэлбэр

Засаглалын хэлбэр	Тодорхойлолт
А. Төрийн байгууллагын засаглал (<i>governance by government</i>)	Аливаа төрийн байгууллага ТХГН-ийн менежментийн эрх мэдэл, хариуцлага, үүргийг бүхэлд нь хүлээж хамгааллын зорилгыг тодорхойлон төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх бөгөөд хамрагдаж буй газар, ус, бусад нөөцийн ч эзэмшигч байдаг. Үүнд, а) холбооны эсхүл үндэсний түвшний яам, агентлаг, б) яамны бүс нутгийн салбар, газар, в) Засгийн газраас томилсон удирдлага (жишээлбэл, гэрээлсэн ТББ) орно.
Б. Хамтын засаглал (<i>shared governance</i>)	Институц, тэдгээрт явагдах үйл явцын цогц механизм бөгөөд менежментийн эрх мэдэл, хариуцлагыг төрийн болон төрийн бус төлөөлөл олон ургалч байдлаар шийдэн ажилладаг. Менежментийн үндсэн эрх мэдэл хариуцлага нэг байгууллагад төвлөрдөг ч бусад талуудтай хамтран шийдвэр гаргах үүрэг хүлээсэн, тэрхүү хамтын шийдвэрийг албажуулж батлах хэлбэрээр ТХГН-ийн засаглалыг хэрэгжүүлдэг. Хамтын менежментийн түгээмэл хэлбэр нь а) хил дамнасан менежмент, б) хамтын менежмент (олон ургалч хэлбэр), в) нэгдсэн менежмент (олон төлөөлөлтэй удирдах зөвлөл хэлбэртэй) байдаг.
В. Хувийн засаглал (<i>private governance</i>)	Байгальд хайртай өмчилсөн газартай хувь хүн, төрийн бус институц (ТББ, Их сургууль г.м.), ашгийн байгууллага (корпорацын эзэд, хоршоо г.м.) байгаль хамгааллын зорилгоо тодорхойлж, менежментийн төлөвлөгөөгөө гарган хэрэгжүүлж ажилладаг. Хамгийн түгээмэл нь ТББ-ын өмчлөл, менежменттэй ТХГН-ууд юм.
Г. Уугуул болон нутгийн иргэдийн засаглал (<i>governance by indigenous peoples and local communities</i>)	Энд уугуул эсхүл нутгийн иргэд байгуулж, менежментийг хийдэг хоёр үндсэн хэлбэр байдаг. Хил хязгаар нь тодорхой биш тоймлосон байдалтай нутгийн тогтсон ёс заншил, уламжлалт институцийн зэрэг албан бус хэлбэрээр эсхүл зүй ёсны эрхийг баталгаажуулсан албан дүрэм журмаар менежмент нь явагддаг. Тухайн газар дахь нөөцийн янз бүрийн хэлбэрийг олон талууд төрлөөр нь, байршлаар нь хуваан эзэмших зэрэг гаднаас харахад ойлгоход төвөгтэй, нутгийн хүмүүсийн мөрддөг ёс заншил дүрэм нь сүсэг бишрэлийн болоод соёлын шинж чанартай байх нь элбэг. Зарим улс оронд эдгээрийг хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн байдаг бол заримд нь хуулиар баталгаажуулаагүй ч хатуу сахин хэрэгжүүлэх нь байдаг. Аль ч тохиолдолд, ийм засаглалтай ТХГН дээр менежмент хийх институц, дүрэм журам нь тодорхой байж хамгааллын зорилгыг хэрэгжүүлэх, хариуцлага хүлээх шаардлага тавьдаг.

Эдгээр засаглалын хэлбэрүүд зарим улс оронд холимог байдлаар байдаг нь тухайн газрын байгаль экологи, нийгэм-эдийн засгийн онцлогтой уялдаж үүссэнтэй холбоотой. Иймд БХОУХ-ноос эдгээр хэлбэрүүд заавал “цэвэр” байдлаараа байхаасаа илүү тухайн газрын онцлог шинж чанарт, хамгааллын зорилгод нийцсэн байхыг зөвлөмж болгодог.

ТХГН-ийн засаглалын хоёр дахь хэмжээс бол **засаглалын чанар** юм. Засаглалын чанар гэдэг нь тогтоосон зарчмуудаа шийдвэр гаргах үйл явцдаа аль хэр мөрдөж чадаж байгаа, улмаар энэ нь менежментийн үр дүнд болон байгаль хамгааллын зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлдог. ТХГН-ийн засаглалыг “сайн” байлгах дараах зарчмуудыг БХОУХ тодорхойлсон байдаг.

САЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУД

Олон ургалч ба хууль ёсны дагуу байх (*legitimacy and voice*): хүнийг нас, хүйс, үндэс угсаа, амьдралын хэв маяг, соёлын болон бусад онцлогоор нь ялгаварлан гадуурхахгүйгээр үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх, ТХГН-ийн менежментийн зорилго, стратегийн асуудлаар хэлэлцэх, харилцан зөвшилцөх үйл явцад оролцох боломжоор хангах;

Газар дээр нь эрх мэдэл өгөх (*subsidiarity*): тухайн нөөцөд хамгийн ойр дэргэд нь байгаа (хуулиар хүлээн зөвшөөрсөн болон уламжлалт) институцид эрх мэдэл, хариуцлагыг шилжүүлэх;

Шударга байх (*fairness*): ТХГН-ийг байгуулах, менежмент хийхтэй холбоотой гарсан зардал, үр ашгийг ижил тэгш хуваах, зөрчил гарсан тохиолдолд шударга зарчмаар шүүх боломжоор хангах;

Хохироохгүй байх (*do no harm*): ТХГН-ийг байгуулж менежмент явуулахдаа ядуурал, эмзэг байдлыг ихэсгэх зэрэг нийгмийн өртөг гарз багатай байлгах;

Удирдан чиглүүлэх (*direction*): ТХГН-ийн ирээдүйн урт хугацааны алсын хараа, хамгааллын зорилгыг тодорхойлж, тууштай хэрэгжүүлэх;

Сайн гүйцэтгэл (*performance*): биологийн олон янз байдлыг үр дүнтэй хамгаалахын сацуу талуудын асуудлыг шийдвэрлэх, нөөцийг арвич хямгачаар ашиглах;

Хариуцлага (*accountability*): хариуцлагыг ойлгомжтой тодорхой хуваарилах, бүрэн тайлагнах, хариуцлагын асуудлаарх талуудын санал шүүмжлэлд зохистой хариу өгч ажиллах;

Ил тод байдал (*transparency*): бүх талуудад мэдээллийг ил тод тэгш хүртээмжтэй байлгах;

Хүний эрх (*human rights*): ТХГН-ийн засаглалыг хэрэгжүүлэхдээ хүний эрх ялангуяа, ирээдүй залуу үеийн эрхийг хүндэтгэж ажиллах.

Эдгээр хүний эрхэд-суурилсан зарчмууд бүрэн дүүрэн хэрэгжихийн хэрээр ТХГН-ийн сайн засаглал оршин тогтнож байна хэмээн үзнэ. Ийм төлөв байдалд хүрэхийн тулд юуны өмнө эдгээр зарчмууд тухайн улсын ТХГН-ийн асуудлыг зохицуулдаг хууль эрх зүйн акт, бодлогын баримт бичигт тусгай заалт болон орсон, тэдгээрийг засаглалын бүх түвшинд хэрэгжүүлдэг байх учиртай. Засаглалын чанарыг тогтоохдоо БХОУХ-ноос гаргасан арга зүйн дагуу тусгайлан үнэлгээ хийдэг.

ЗАСАГЛАЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Сайн засаглалын дээрх зарчмуудын “зүрхэнд” хамгаалж буй байгалийн нөөцтэй хамаатай хүний эрх байдаг. Иймд засаглалын үйл явцад оролцож байгаа талуудыг “давуу эрхтэй тал” (*англ. rightsholder*) болон “оролцогч тал” (*англ. stakeholder*) гэж хоёр салган авч үздэг (Borrini-Feyerabend et al., 2013, p. 15).

Давуу эрхтэй тал (*rightholders*) нь нийгмээс өгөгдсөн (хүлээн зөвшөөрдөг) газар, ус, бусад байгалийн нөөцийн хууль ёсны эсхүл хэвшмэл эрхтэй этгээд бөгөөд

голдуу тухайн асуудлыг шууд хамаардаг шат шатны төрийн байгууллагууд болон уул нутагт үеийн үед амьдарсан уугуул болон нутгийн иргэдэд хамаардаг. Харин **оролцогч тал** (*stakeholders*) гэдэг нь хуулиар болон нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрсөн тийм эрх байхгүй ч тухайн нөөцийн асуудлаар шууд болон шууд бус ашиг сонирхолтой этгээд байдаг. ТХГН-ийн засаглалд оролцогч талуудыг мөн төрийн болоод төрийн бус тал гэдгээр нь авч үзвэл дараах этгээдүүд хамаарна.

Хүснэгт-4. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд оролцогч талууд

Төрийн оролцогч	Төрийн бус талын оролцогч
ТХГН-ийн захиргаа (менежер, албан хаагчид)	Орон нутгийн газар болон нөөцийн менежерүүд (газар өмчлөгчид, нутгийн иргэдийн уламжлалт байгууллагын гишүүд)
Орон нутгийн өөрөө удирдах байгууллага	Тухайн нөөцөөс шууд болон шууд бусаар хамааралтай, ТХГН дээр болон түүний орчны бүсэд амьдарч буй иргэд
Орон нутгийн төрийн захиргааны байгууллага	ТХГН байгуулснаас үүдэн нутаггүй болж шахагдсан иргэд
ТХГН-ийн удирдлагыг хариуцсан төрийн төв байгууллага, түүний салбарууд	Газар нутгаа хамгаалах зорилготой нутгийн иргэдийн бүлэг, холбоо, хөдөлгөөнүүд
БОЯБК-н үндэсний зохицуулагч, ТХГН-ийн ҮАХ хариуцсан ажилтан	Тухайн газар аялагч зугаалагч жуулчид
Хууль тогтоох, сахиулах байгууллагын төлөөлөл	Байгаль хамгаалал, тогтвортой амьжиргаа, хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллага, бүлэг, хувь хүн
Бусад салбарын байгалийн нөөцийн асуудал хариуцагч албан тушаалтнууд (ус, ХАА, ойн аж ахуй, загас агнуур, судалгаа шинжилгээ, санхүү, худалдаа, дэд бүтэц г.м.)	Байгаль хамгаалах зорилгоор газрыг зориуд худалдан авдаг ТББ-ууд
Байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой төрийн өмчит ашгийн байгууллагууд (хүнс, хэрэглээний мод, ус г.м.)	Судалгаа, боловсрол, сургалтын зорилгоор ТХГН-т ажилладаг байгууллагууд
Холбооны болон үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн Овог аймгийн засаг захиргаад	- ТХГН байгуулахаас өмнө сүм хийд зэрэг сүсэг бишрэлийн байгууламжтай байсан, ийм үйл ажиллагаа явуулдаг газрууд - Байгаль хамгаалах сонирхолтой бизнесийн байгууллагууд (ж. нь: аялал жуулчлалын компани) эсхүл байгаль хамгаалалд нөлөөлж буй бизнесүүд (голын эхэнд бохирдол үүсгэгч, ус ашиглагчид г.м.) - ТХГН-ийн хил дотор газартай компани, корпорац - Тухайн газар оршин суудаггүй ч түүхийн, аялал жуулчлалын, төрөлх нутаг г.м. шалтгаанаар ашиг сонирхолтой, санаа зовж явдаг талууд - Байгаль хамгааллын, тогтвортой амьжиргаа, хүний эрхийн чиглэлээр явуулдаг үйл ажиллагааг дэмжигч улсын болон хувийн сангууд, хандивлагчид

МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭРЭГСЛҮҮД

Засаглалд оролцож буй ийм олон талын ашиг сонирхлыг харгалзан үзэж, тэдгээрийн хоорондын зөрчлийг шийдвэрлэж ажиллах нь ТХГН-ийн менежментийн гол сорилт байдаг. Үүнийг амжилттай давахын тулд

менежментийн дараах олон төрлийн арга хэрэгслийг дэлхий дахинд хэрэглэдэг.

- Олон улсын хууль, конвенц, стандарт, ялангуяа тухайн улс нэгдэн орсон гэрээ конвенцууд;

- Тухайн **улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, стратегийн төлөвлөгөө** (улсын үндсэн хуулиас эхлээд, ТХГН-т хамаатай салбарын хууль журам, орон нутгийн чанартай дүрэм журам хүртэл багтана);
- ТХГН-ийн тухай эрх зүйн баримт бичгүүд, менежментийн төлөвлөгөө** (тухайлбал, эн тэргүүний зорилтуудыг тодорхойлсон, бүсчлэлийг тогтоосон, нөөц ашиглах болон нээх хаах хугацааг заасан, ан агнах, мал бэлчээх г.м. аливаа үйл ажиллагааны хугацаа эсхүл техник технологи ашиглахыг зөвшөөрсөн/хориглосон зэрэг зохицуулалт хийсэн);
- Тухайн нутагт **сахиж мөрддөг уламжлалт ёс жаяг, горим** (нутгийн институцийн зохицуулдаг нөөцийг ашиглах, хязгаарлах ёс заншил г.м.);
- Мэргэжлийн зөвлөл, экспертүүд, техникийн хорооны санал зөвлөмж** (хамгийн үр нөлөөтэй, найдвартай, боломжийн, зардал багатай үйл ажиллагааны чиглэл өгөх г.м.);
- Нийгмийн **урамшууллын болон шийтгэлийн систем** (нийгмээрээ хүлээн зөвшөөрөх, талархах, шагнах, хорлонтой буруу үйлдэл хийгсдийг зэвүүцэх, жигших г.м.);
- Мөнгөн урамшуулал ба шийтгэл** (ажлын хөлс, менежментийн төлбөр, байгаль хамгаалсны төлөө татвараас чөлөөлөх, байгальд хохирол учруулсан, доройтуулсны татвар, төлбөр г.м.);
- Санхүүгийн хөрөнгө оруулалт** (төсөл хөтөлбөр, дэд бүтэц г.м.);
- Хүний нөөцийн болон цаг хугацааны хөрөнгө оруулалт** (нөхөн сэргээлтийн болон эргүүлийн ажилд сайн дураараа оролцох);
- Уулзалт хийх, хэлэлцүүлэг хийх, санал солилцоход зориулан байр, тээвэр, утсан харилцаа, компьютер зэрэг тоног төхөөрөмж, **мэдээлэл, орчноор хангах**;
- Боловсролын хөтөлбөрөөр хангах** (ерөнхий болон тусгай боловсрол, магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн курс г.м.);
- ТХГН-ийн хэрэгцээнд нийцүүлэн **цалин, материаллаг болон захиргааны дэмжлэг** үзүүлэх;
- ТХГН-ийн менежментэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, түүний шийдлийг гаргахад чиглэсэн **судалгааны болон сургалтын хөтөлбөр** хэрэгжүүлэх;
- Мониторинг, үнэлгээний ажлыг дэмжих** сайжруулах (засаглалын асуудлууд орно);
- Хуулийн **зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих**, биет саад хашаагаар хангах.

МЕНЕЖМЕНТИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Тухайн ТХГН-ийн засаглалд оролцогч тал болон давуу эрхтэй талууд эдгээр арга хэрэгслийг аль хэр бүтээлчээр ашиглаж чадах эсэх нь тэдний хүчин чадлаас (*power*) ихээхэн хамаардаг байна. Тэгвэл тэдэнд дараах хүчин чадлын ихэнх нь хосолсон байдалтай байвал зэгсэн үр нөлөөтэй менежмент явуулах боломжтой ажээ (Borrini-Feyerabend et al., 2013)

- Зохицуулах, төлөвлөх хүчин чадал** (*planning and regulatory powers*): ТХГН-ийн хууль журам, менежментийн төлөвлөгөөнд багтдаг газар, ус, байгалийн бусад нөөц ашиглах, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үр нөлөөтэй дүрэм зохицуулалт, бодит төлөвлөлт хийх чадвар;
- Төлбөр авах, зөвшөөрөл олгох, ашиглалтын татвар авах зэргээр **орлого бий болгох хүчин чадал** (*revenue-generating powers*);
- Харуул хамгаалалт хийх, хууль сахиулах, явган аяллын жим, зам, мэдээллийн төв зэрэг дэд бүтэц байгуулах, тэдгээрийн урсгал засвар хийх хэлбэрээр **зарцуулах хүчин чадал** (*spending powers*);
- ТХГН-ийн зорилгыг хэрэгжүүлэх, бусад талуудтай сайн түншлэл тогтоох зэрэгт шаардлагатай **боловсон хүчин ажилд авах хүчин чадал** (*hiring powers*);
- Дээрх дөрвөн хүчин чадлыг доод шатандаа

шилжүүлж эсхүл хуваалцаж ажиллахын тулд **хуран хэлэлцэж, гэрээ зөвшилцөлд хүрдэг хүчин чадал** (*powers to convene others and develop agreements*), үүнд, эдгээр хүчин чадал, бүрэн эрхээ хуваалцахад үйл ажиллагааны нэгдсэн ижил дүрмээр ажиллах зохицуулалт (хамтарсан удирдах зөвлөл, зөвлөлдөх хороо байгуулах г.м.) хийх, ТХГН-ын хил залгаа зэргэлдээ газрыг хариуцдаг талуудтай гэрээ хэлцэлд орохоос эхлээд шинээр ажилд орж буй ажилтны ажлын байрны нөхцөл, үүрэг хариуцлагыг зөвшилцөх хүртэлх эрх мэдэл мөн орно;

Шаардлагатай мэдээллийг олох ур чадварыг эзэмшсэн, ямар мэдлэг мэдээлэл хэрэгтэй, түүнийг хаанаас хэрхэн олж авах, ямар мэдлэг мэдээлэлд үндэслэн зарим онцгой шийдвэрийг гаргахаа мэддэг, албан ба албан бус сувгаар төлөвлөлт, судалгаа, мониторинг, үнэлгээнд хэрэгтэй мэдээллийг олдог, хүртээмжийг зохицуулдаг, шинжлэх ухааны сэтгүүл, бага хурал, интернэт, нийгмийн сүлжээ зэрэг хэлбэрээр мэдээллийг нээлттэй түгээдэг **шинийг эрэлхийлэх, мэдлэгтэй**

байх хүчин чадал (*the power of knowledge and know-how*);

Гаргасан шийдвэр, дүрэм журмыг хэрэгжүүлэхдээ янз бүрийн арга хэрэгслийг ашиглаж чаддаг **хэрэгжүүлэх хүчин чадал** (*the power to enforce*), үүнд, нийгмийн дарамт шахалт, олон нийтийн зэвүүцэл зэргийг зохистой ашиглах, эргүүл шалгалт хийх, зэвсэг хэрэглэх зэргээр хуулийн зөрчлийг биеэр таслан зогсоох болон урьдчилан сэргийлэх, гэмт үйлдлийг шуурхай шүүн шийдвэрлэх, торгууль, шийтгэл оноох чадвар орно.

Дээрх төрлийн хүчин чадлыг ихэнхдээ хослуулан эзэмшиж янз бүрийн түвшинд менежментийн зүйл бүрийн арга хэрэгсэл ашиглах замаар талууд тухайн ТХГН-т де-факто засаглал буй болгодог байна.

Де-факто ба Де-юре нь засаглалын бичвэрт түгээмэл хэрэглэгддэг бөгөөд хуулиар заасан зүйл ба бодит амьдрал дээрх зүйлийг ялгахад ашигладаг. Шууд утгаараа бол “бодит байдал дээр” ба “хуулиар бол” гэсэн үгс (Borrini-Feyerabend et al., p. 11).

ЗАСАГЛАЛЫН ТҮВШИН

Үүнээс үзвэл тухайн ТХГН дээрх засаглалын чанарт олон түвшний институт, талуудын үйл ажиллагаа нөлөөлж байдаг учир **засаглалын түвшин** гэдэг ойлголт байдаг. Үүнд, бидний ерөнхийдөө мэддэг дараах түвшнүүд багтана.

Даян дэлхий түвшин: БОЯБК, Нүүдлийн зүйлийг хамгаалах конвенц, Рамсарын ус намгархаг газрын конвенц, Дэлхийн өвийн конвенц, ЮНЕСКО-ийн Хүн ба шим мандал хөтөлбөр, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай САЙТИС конвенц зэрэг олон улсын гэрээ хэлэлцээр, конвенц нь даян дэлхийн засаглалын хэлбэр юм.

Олон-талт, үндэстэн-хоорондын, бүс нутгийн түвшин: цөөн тооны орнуудын хооронд байгуулсан Газар дундын тэнгис орчмыг хамгаалах Барселоны конвенц эсхүл Антарктидын далайн хавыг хамгаалах тухай конвенц, Европын холбооны хэмжээнд

байгаль хамгаалах горимыг хэрэгжүүлсэн НАТУРА-2000 хөтөлбөр г.м. гэрээ хэлцлүүд **Хоёр-талт түвшин:** аливаа хоёр орны хооронд хийсэн (тухайлбал, Хятад Австралийн нүүдлийн шувуудын тухай гэрээ) зөвшилцлүүд

Үндэсний түвшин: тухайн улсын хууль эрх зүйн акт, бодлогын хэлбэрээр шийдвэр гаргах, хэрэгжүүлэх

Бүс нутгийн түвшин: тухайн улсын тодорхой бүс нутаг, засаг захиргааны нэгжийн хүрээнд эсхүл тодорхой салбарын хэмжээнд хэрэгжүүлэх

ТХГН-ийн системийн түвшин: үндэсний болон бүс нутгийн хэмжээний байгууллагууд эсхүл зөвлөлийн удирдлага дор бүх ТХГН-ийг хамран хэрэгжүүлэх хэлбэр, өөрөөр хэлбэл, тухайн улсын бүх ТХГН нь нэг системийг бүрдүүлдэг.

ТХГН-ийн түвшин: нэг ба түүнээс дээш тооны ТХГН-ийн удирдлагыг давуу эрхтэй болон оролцогч талуудын удирдлагаар хэрэгжүүлэх хэлбэр, үүнд, ихэвчлэн, мэргэжлийн менежер, экспертүүд, захиргаа аж ахуйн, донор хөрөнгө оруулагчийн, орон нутгийн засаг захиргааны, нутгийн иргэдийн төлөөлөл ордог;

ТХГН-ийн салбар түвшин: экологийн, нийгмийн болон бүсчлэлийн хувьд онцлог ТХГН-ийн доторх сегмент/ландшафт эсхүл холбоос газрыг хамрах түвшин

Засаглалын эдгээр түвшин нь хоорондоо босоо болон хэвтээ удирдлагын харилцаатай байх, тэдгээр харилцаа нь албан болоод албан бус шинжтэй байх, зарим тохиолдолд хосолсон хэлбэртэй байх зэргээр тухайн нөхцөл байдлаас хамааран харилцан адилгүй байж болно. Ерөнхийдөө засаглалын түвшин өргөн хүрээтэй томоохон байхын хэрээр түүний цаана экосистемийн бүрэн бүтэн байдал, зүйлийн шилжилт хөдөлгөөнийг хангах, хууль бус үйлдэлтэй тэмцэхэд олон улс орон, газар нутгийг хамарсан том цар хүрээнд хамгааллын цогц үйл ажиллагаа явуулах зорилго хэрэгжиж байдаг.

Засаглалын дээд түвшинд гарсан шийдвэрийг орон нутагт анхан шатанд хурдан үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх нь засаглалын хэт олон түвшнийг үр нөлөөтэй байлгах чухал ач холбогдолтой байдаг. Иймд **төвлөрлийг сааруулах** (*decentralization*) хэлбэрээр энэхүү сул талыг шийддэг бөгөөд хэнд шийдвэр гаргах эрх мэдлийг өгч буйгаас хамааран нэршил өөр байдаг. Тухайлбал, төрийн байгууллагын харьяа доод шатны салбарт эрх мэдэл шилжвэл **“задлах”** (*de-concentration*), хувийн байгууллагад бол **“хувьчлал”** (*privatization*), нутгийн өөрөө удирдах ёсны иргэдэд үйлчлэх байгууллагад бол **“эрх мэдэл шилжүүлэх”** (*devolution*), хэрэгжүүлэх хүчин чадал бүхий байгалийн нөөцийн ойр дэргэд буй албан эсхүл уламжлалт институцид эрх мэдэл шилжвэл **“газар дээр нь эрх мэдэл өгөх”** (*subsidiarity*) хэмээн нэрлэдэг (Borrini-Feyerabend et al., p. 25).

Дээрх бүх тайлбар танилцуулгаас үзвэл даян дэлхийд ТХГН-ийн үр нөлөө сайтай менежмент хийхэд засаглал ихээхэн ач холбогдолтой, тухайн улс орны байгалийн

нөөцтэй харьцаж ирсэн түүх соёл өв уламжлалтай салшгүй холбоотой байдаг. Иймдээ ч үеийн үед байгальтай харьцаж ирсэн албан бус институц болох ёс заншил, албан ёсоор хуульчлагдаагүй ч эрхэмлэн сахидаг ёс заншил, дэг жаяг зэргийг хүлээн зөвшөөрч албан институцүүдтэй зэрэгцүүлэн авч үзэж ТХГН-ийн удирдлагын хэлбэрт багтаадаг байна. Энэ нь эргээд аливаа байгалийн нөөцийг ариг гамтай, зохистой ашиглахад олон жилийн туршид бүрэлдэн шигшигдэж буй болсон тухайн газрын уур амьсгал, газарзүй, амьтан ургамалдаа зохицсон хүний амьдралаа тэтгэх арга зам юм. Нөгөө талдаа техник технологи хурдацтай хөгжиж орон зай, цаг хугацааны бэрхшээлийг хялбар шийдэх болсон даяаршлын өнөө үед нэг орны дотоод нөөцийн төлөв байдалд алс холын өөр оронд буй байгууллага, хувь этгээд нөлөөлөх нь ердийн асуудал болоод байгаа тул оролцогч талуудын цар хүрээ тэр хэмжээгээр тэлж төдий чинээ өргөн хэлбэрийн засаглал, институц, үйл явц, үйл ажиллагаа шаардагдах болсон нь тод харагдлаа.

Ийм нөхцөлд оролцогч талуудын **эрх мэдэл, үүрэг, хариуцлага**, үйл ажиллагааны хүрээг тов тодорхой байлгах нь ТХГН-ийн засаглалын чухал зорилго бөгөөд үүний хүрээнд, байгаа нөөц **хүчин чадлаа** ашиглан холбогдох **түвшинд** байгаа зохистой **арга хэрэгслээр** талууд хамтран ажилласнаар засаглалын үйл явц хангагдана. Нөгөөтээгүүр засаглал нь байгаль орчны, соёлын, нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлттэй тулгарч, тэдгээрийг даван туулах шаардлага байнга гарч байдаг учир энэ нь шинээр урган гарч ирж буй хэрэгцээ шаардлагад үйл ажиллагаагаа тухай бүр нийцүүлэх, шинэ нөхцөлд дасан зохицох үйл явц ажээ.

Бидний онцлон анхаарах зүйл бол ТХГН-ийн менежмент ба засаглал нь ялгаатай, хооронд нь хольж болохгүй ойлголтууд юм. Өөрөөр хэлбэл, ТХГН-ийн ангилал нь засаглалын дурын хэлбэртэй, тэндэх нөөцийн эдэлбэрийн харилцаа нь ямар ч байдлаар байж болдог. Тиймээс тухайн улс орон ТХГН-ийн ангилалд засаглалын ямар хэлбэр зонхилж байгааг БХОУХ-ноос гаргасан **ТХГН-ийн матриц** ашиглан тодорхойлж болдог.

Энэхүү матрицыг (Хүснэгт-5) ашиглан тухайн орны ТХГН-ийн системд шинжилгээ

хийхэд ангиллын болон засаглалын хэлбэр олон янз байдлыг бүрэн ашиглаж чадсан эсэх, тухайлбал аль нэг эгнээ, багана хоосон бол яагаад манайд энэ ангилал, засаглалын

хэлбэр байхгүй байна, бий болгох хэрэгцээ, боломж байгаа эсэх зэргийг хянаж үзэх замаар төрөл зүйлийг олшруулах боломжтой.

Хүснэгт-5. БХОУХ-ны ТХГН-ийн ангилал, засаглалын хэлбэрийг тодорхойлох матриц

Засаглалын хэлбэр	Төрийн байгууллагын засаглал			Хамтын засаглал			Хувийн засаглал			Уугуул/нутгийн иргэдийн засаглал	
Менежментийн ангилал	Холбооны эсхүл үндэсний түвшний яам, агентлаг	Яамны бүс нутгийн салбар, газар, хэлтэс	Засгийн газраас томилсон удирдлага (ТББ зэрэг)	Хил дамнасан менежмент	Хамтын менежмент (олон ургальч хэлбэртэй)	Нэгдсэн менежмент (олон төлөөлөлтэй Уд. зөвлөл)	Өмчилсөн газартай хувь хүн	Төрийн бус институц (ТББ, Их сургууль г.м.)	Ашгийн төлөө байгууллага (корпорацийн эзэд, хоршоо)	Уугуул иргэд байгуулж, менежментийг хийдэг	Нутгийн иргэд байгуулж, менежментийг хийдэг
I. Дархан цаазат газар											
II. Үндэсний парк											
III. Байгалийн дурсгалт газар											
IV. Биологийн төрөл зүйл, тэдгээрийн идээшил нутгийг хамгаалах газар											
V. Хамгаалалттай ландшафт											
VI. Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт бүхий хамгаалалттай газар											

Мадагаскар улс өөрийн ТХГН-ийн системд тус матрицыг ашиглан дүн шинжилгээ хийж ангиллын хувьд болон засаглалын хэлбэрийн маш олон төрөл зүйлтэй хосолмол систем болгон баяжуулахын зэрэгцээ БХОУХ-ны Дэлхийн ТХГН-ийн 5 дугаар хурал дээр амласан хамгаалалттай газар нутгийн хэмжээг 6 сая га-д хүргэх амлалтаа биелүүлж 2003 оны түвшнээс гурав дахин нэмэгдүүлэх зорилгодоо 10 жилийн дараа хүрч чадсан байна (Хүснэгт-6).

Энэхүү бүлэг нь ТХГН-ийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтоос эхлээд ТХГН-ийг менежментийн зорилгоос хамааран тогтоосон хамгаалалттай газрын олон улсын ангилал, тэдгээрийн онцлох ялгааг тайлбарлалаа. Түүнчлэн ТХГН-ийн зорилгод хүрэхэд үндсэн ач холбогдол бүхий ТХГН-ийн засаглал гэж юу болох, түүний хэлбэрүүд, засаглалд оролцогч талууд, тэдгээрт байвал

зохих хүчин чадал, засаглалын үйл явцад баримтлах зарчмууд, сайн засаглалыг хэрэгжүүлэхэд ашигладаг арга хэрэгслүүд, засаглалын түвшин, засаглалын чанар зэрэг ТХГН-ийн үндсэн ойлголт, тогтолцоо, түлхүүр ухагдахууныг танилцууллаа. Эцэст нь ТХГН-ийн менежментийн болон засаглалын төлөв байдал, статусыг шинжилдэг БХОУХ-ноос гаргасан ТХГН-ийн матрицын тухай ойлголт өглөө. Иймд энэхүү бүлэгт тодорхойлсон ТХГН-ийн концепц нь дараагийн бүлгүүдийн дүн шинжилгээнд ашиглах үндсэн хүрээ дүн шинжилгээний хэрэгсэл болох юм.

Нөгөөтээгүүр, энэ бүлэгт сийрүүлэн тайлбарласан ойлголт ухагдахууны цогц бол дэлхийн ТХГН-ийн нэгдсэн системд менежментийн үндсэн стратеги, үйл ажиллагааны жанжин шугам стандарт болдог билээ.

Хүснэгт-6. ТХГН-ийн матрицыг ашиглан ТХГН-ийн системд өөрчлөлт хийсэн Мадагаскарын жишээ

Засаглалын хэлбэр	Төрийн байгууллагын засаглал			Хамтын засаглал			Хувийн засаглал			Уугуул/ нутгийн иргэдийн засаглал	
	Холбооны эсхүл үндэсний түвшний яам, агентлаг	Яамны бүс нутгийн салбар, газар, хэлтэс	Засгийн газраас томилсон удирдлага (ТББ зэрэг)	Хил дамнасан менежмент	Хамтын менежмент (олон ургальч хэлбэртэй)	Нэгдсэн менежмент (олон төлөөлөлтэй Уд. зөвлөл)	Өмчилсөн газартай хувь хүн	Төрийн бус институт (ТББ, Их сургууль г.м.)	Ашгийн төлөө байгууллага (корпорацийн эзэд, хоршоо)	Уугуул иргэд байгуулж, менежментийг хийдэг	Нутгийн иргэд байгуулж, менежментийг хийдэг
Менежментийн ангилал 2003											
I. Дархан цаазат газар											
II. Үндэсний парк											
III. Байгалийн дурсгалт газар											
IV. Биологийн төрөл зүйл, тэдгээрийн идээшил нутгийг хамгаалах газар											
V. Хамгаалалттай ландшафт											
VI. Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт бүхий хамгаалалттай газар											

Засаглалын хэлбэр	Төрийн байгууллагын засаглал			Хамтын засаглал			Хувийн засаглал			Уугуул/ нутгийн иргэдийн засаглал	
	Холбооны эсхүл үндэсний түвшний яам, агентлаг	Яамны бүс нутгийн салбар, газар, хэлтэс	Засгийн газраас томилсон удирдлага (ТББ зэрэг)	Хил дамнасан менежмент	Хамтын менежмент (олон ургальч хэлбэртэй)	Нэгдсэн менежмент (олон төлөөлөлтэй Уд. зөвлөл)	Өмчилсөн газартай хувь хүн	Төрийн бус институт (ТББ, Их сургууль г.м.)	Ашгийн төлөө байгууллага (корпорацийн эзэд, хоршоо)	Уугуул иргэд байгуулж, менежментийг хийдэг	Нутгийн иргэд байгуулж, менежментийг хийдэг
Менежментийн ангилал 2013											
I. Дархан цаазат газар											
II. Үндэсний парк											
III. Байгалийн дурсгалт газар											
IV. Биологийн төрөл зүйл, тэдгээрийн идээшил нутгийг хамгаалах газар											
V. Хамгаалалттай ландшафт											
VI. Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт бүхий хамгаалалттай газар											

МОНГОЛ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Энэхүү хоёрдугаар бүлэгт БХОУХ-ноос олон орны эрдэмтэн судлаачид, байгаль хамгааллын мэргэжилтнүүдтэй урт удаан хугацаанд хэлэлцэн шинжлэх ухааны охь мэдлэг, шилдэг тэргүүн туршлага, алдаа сургамжийг шингээн боловсруулж баталсан дэлхий даяар мөрдөж буй ТХГН-ийн

менежментийн стандарт Монгол Улсын ТХГН-ийн системд хэрхэн хэрэгжиж буйг нягтлан үзэж, эдгээрээс орхигдож буй зүйлсийг тодорхойлон манай орны ТХГН-ийн удирдлага менежментийг цаашид сайжруулах үйл хэрэгт хувь нэмэр оруулахуйц мэдээлэл өгөх зорилготой юм.

ТХГН-ИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монголчуудын байгаль хамгаалах өв уламжлал нь эрт үеэс гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл, шашин шүтлэг, амьдрах арга ухаан, зан үйл, ёс горим, цээр хорио зэрэгт сүлэлдэн шингэж бидний үед дамжин ирсэн байдаг. Бидний өвөг дээдсийн байгальд хандах хүндлэлийг гадаадын аялагч, жуулчид гайхширан бичдэг байсан нь тэр үедээ дэлхийн бусад газарт түгээмэл зүйл биш байсантай холбоотой буйзаа.

“Жил бүрийн гуравдугаар сараас аравдугаар сар хүртэл туулай, буга, бор гөрөөс, хар сүүлт зэргийг төрөх үржих цагт нь хан ван, эрхтэн дархтан хэн боловч агнах эрхгүй гэсэн хууль дүрэм Монголд байх юм” Марко Поло “Орчлонгийн элдэв сонин”

Чухамдаа ихэс дээдсийн мэргэн ухаан шингэж, ёс заншил болтол нь ягштал сахин мөрддөг байсан хатуу хууль цаазын ачаар өнөөгийн Монгол орны байгаль харьцангуй унаган төрхөөрөө, нөөц баялаг нь бүрэн бүтнээрээ эдүгээ бидний үед өвлөгдөн ирсэн билээ. Эдгээрийн дунд Их эзэн богд Чингис

хааны үед гарсан “Их Засаг” хууль нь байгаль хамгааллын үзэл санааг хойчийн засан тохинуулах бичиг цаазуудад албажуулан шингээж, тухайн үеийн нийгмийн бүхий л харилцааг зохицуулахад зориулагдсан суурь хууль байсныг монголын түүхчид онцолдог. Монголчуудын байгаль хамгааллын арга, хорио цээр, шийтгэл цаазыг зааж тогтоосон 13 дугаар зуунаас 20 дугаар зууны эхэн үеийн хууль цаазад “Их Юанийн нэвтэрхий хууль”, “Дөчин дөрвөн хоёрын цааз”, “Халх журам”, “Үйсэн дээр бичсэн цааз бичиг”, “Алтан хааны цаазын бичиг”, “Халх зургаа ба долоон хошууны их цааз”, “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль цаазын бичиг” зүй ёсоор ордгийг судлаачид тэмдэглэжээ (Я.Адьяа, 2007, р. 10).

Монголын хууль цаазын эдгээр бичигт байгалийн нөөц ашиглах хугацааг тогтоож (ан ав хийх, үржлийн үед болон шинэ нутагт ирсэн амьтныг агнахгүй, хээлтэй, нялх төлтэйг үргээж цочоохгүй, ногоорох үед мод огтлохгүй г.м.), байгалийг цэвэр ариун байлгах (ус гол руу бие засахгүй, малын сэг зэм цэвэрлэх, цус, сүүг асгахыг цээрлэх, нүүхдээ бууриа цэвэрлэх г.м.) бүрэн бүтэн

байлгах (газар нүхлэхгүй, түймэр тавихгүй, зулзаган мод огтлохгүй), ан амьтанд энэрэнгүй хандах (амьтны амь зорилгогүй таслахыг, егүүтгэлт арга хэрэгслийг хориглох, лам санваартан ан хийхгүй, аргаль угалзын цагаан магнай руу буудахгүй г.м.) хуульчлан зааж өгсөн ажээ. Эдгээр цаазыг зөрчсөн этгээд хэргэм дэв харгалзахгүйгээр биеийн залхаалт болоод эд хөрөнгөөр төлөх шийтгэл хүлээдэг, харин түймэр унтраах, аюулын зар эрт хүргэх, байгалийн гамшгаас аврах зэрэг ач тустай үйл хийсэн хүнд бод бог мал өгөх, торгууль татвараас чөлөөлөх зэргээр хөхүүлэн шагнадаг байжээ.

Монголчууд байгалийн үзэсгэлэн төгс нөөц баялаг бүхий газарзүйн орон зайг тусгайлан хамгаалж хориг цааз тогтоосон тухай хууч яриа байдаг ч судар бичигт тэмдэглэгдэн үлдсэн нь 12 дугаар зуунд хэрээдийн Ван хан Туулын хар шугуйд нутаглаж байхдаа Хан ууланд ан гөрөө хийх, гал хөс түлэхийг хориглож онголон тахисан тухай Монголын нууц товчоонд бичсэн явдал хэмээн үздэг (Я.Адъяа, р. 42). Сүүлд 1778 онд Хан уулыг зарлигаар цаазлан хамгаалж Богд Жавзандамба хутагтын цолыг өргөснөөр Богдхан уул хэмээн нэрийдэх болсон ажээ (Я.Адъяа, р. 43). Улмаар 1809 оноос уулын амуудыг тусгайлан хамгаалах цагдаатай болж, 1911 онд хамгаалалтын захиргаа байгуулж байжээ (Я.Адъяа, р. 42).

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Үндэсний газарзүйн нийгэмлэг (National Geographic Society)-ийн дэлхийн ууган паркийн жагсаалт (Djossa, 2018) болон дэлхийд өргөнөөр ашигладаг Википедиа цахим толь бичигт Богдхан уулыг дэлхийн анхдагч ТХГН-ийн нэг гэдгийг тэмдэглэн оруулжээ. Ялангуяа эдгээр эх сурвалжид тэмдэглэсэн дэлхийн анхны хамгаалалттай газрын он цаг нь 1810 оны Английн яруу найрагчийн шүлэгт гардаг үзэсгэлэнт Дистрикт нуураас эхэлж, 1832 онд хуулиар хамгаалсан Арканзасын Халуун булаг (Hot Springs), 1872 онд байгуулсан АНУ-ын анхны үндэсний парк болох Шар чулуут (Yellow Stone) хэмээн тэмдэглэснийг үзвэл Богд хан уулыг монголын төдийгүй дэлхийн хамгийн эртний ТХГН гэж үзэх үндэслэлтэй, гагцхүү шаардагдах түүхэн бичиг баримтыг бүрдүүлж албан ёсоор баталгаажуулах шаардлагатай юм.

Судлаач доктор Я.Адъяа тэмдэглэхдээ 1709-1795 оны “Халх журам”-д Хан Хэнтий, Отгонтэнгэр зэрэг 14 үзэсгэлэнт уулыг дархлан хамгаалахаар заасан нь эрт үеэс монголчууд ТХГН-ийн сүлжээтэй байсныг харуулж байна гэжээ (2007, р. 43)

Социалист Монгол Улсын үед (1921-1991) улсын байгалийн нөөц баялгийг тогтоох томоохон хамтарсан судалгааны ажлууд хийгдэж Шинжлэх ухааны академи, газарзүй, биологи, ботаникийн хүрээлэн зэрэг үндэсний шинжлэх ухааны байгууллагууд үүсэн буй болсон, улсын хөгжлийг дэмжих үүднээс байгалийн нөөцийн ашиглалтыг нэлээд өргөн хүрээнд хийж байжээ. Ялангуяа, Хятадтай холбосон төмөр зам барих, олон зуун худаг гаргаж онгон зэрлэг нутгийг малын бэлчээр болгох, их хэмжээний атар хээр газрыг хагалж тариа тарих, говийн задгай ус баян бүрдийг газар тариалангийн зориулалтаар ашиглах, голын татам, булаг шанд зэрэг экологийн ач холбогдол бүхий газраас малын тэжээл бэлтгэх зэргээр зэрлэг амьтны тоо толгой буурах, тэдний амьдрах орчныг талхин доройтуулах, дүрвэн дайжихад хүргэсэн олон сөрөг үр дагавар гарсан байдаг (Я.Адъяа, р. 49).

Нөгөөтээгүүр, 1956 оны 7 дугаар сард ЗХУ-аас анхны 15 жуулчин хүлээн авч Монгол Улсад аялал жуулчлалын эхлэл тавигдсан бөгөөд мөн оны 10 дугаар сард социалист орнуудын жуулчдын байгууллагын анхдугаар бага хуралд Монголын төлөөлөгчид оролцон 10 орчим улсаас жуулчин хүлээн авах гэрээг байгуулсан байдаг (Ч.Буянбадрах, 2019). Энэ мэт шалтгаанаар 1957 оноос эхлэн Батхаан, Нагалхаан зэрэг байгалийн үзэсгэлэнт газрыг шинээр тусгай хамгаалалтад авах ажил эхэлж, 1991 он гэхэд нийт 6,782,208 га талбай бүхий 11 дархан цаазат газартай (Д.Мягмарсүрэн & А.Намхай, 2012) болсон бөгөөд эдгээрийн 96 хувь нь Говийн Их дархан цаазат газарт ноогдож байв. Эдгээр ТХГН-ийг удирдлагаар хангах, аж ахуйн зориулалтаар хийж буй ашиглалтыг зохистой явуулах, хамгаалалтын горимыг тогтоох зорилгоор “БНМАУ-ын Дархан газрын дүрэм”-ийг 1975 онд Сайд нарын зөвлөл баталсан бөгөөд 1991 онд “Тусгай хамгаалалттай газрын дүрэм” болгон шинэчилсэн байна.



Энэ үед Монгол Улс НҮБ-ын хоёр конвенцод нэгдэн орсон нь 1971 оны хоёрдугаар сард соёрхон баталсан “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газрыг хамгаалах тухай” Рамсарын конвенц, 1979 оны зургаадугаар сард соёрхон баталсан “Зэрлэг амьтны нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай” Бонын конвенц юм.

Ардчилсан Монгол Улсын үе (1992-2021) нь ТХГН-ийн хууль эрх зүйн орчин, менежментэд томоохон шинэчлэлт хийж хамгааллын цар хүрээг дорвитой тэлсэн үсрэнгүй хөгжлийн үе юм. Тухайлбал, Улсын Их Хурлаас баталсан 1994 оны “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”, 1997 оны “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай” хуулиуд, Засгийн газраас 1995 онд баталсан “Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын нийтлэг болон тусгай горим”, 1998 оны “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр” нь ТХГН-ийн хууль эрх зүйн үндсэн баримт бичгүүд юм. Чухамдаа ТХГН-ийн ангилал, тэдгээрийн дэглэм, дотоод бүсчлэл, ТХГН-ийн менежмент хийх шат шатны төрийн байгууллагын эрх үүрэг, ТХГН-т судалгаа шинжилгээ хийх, газар ашиглах горимыг тодорхойлж, орчны бүсийг тогтоох, түүний менежментийн арга хэлбэр зэргийг эдгээр хууль бодлогоор өнөө хэр нь зохицуулж байгаа билээ.

Одоо хүчин төгөлдөр “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулиар ТХГН-ийн менежментийн дөрвөн ангиллыг тодорхойлсон бөгөөд үүнд, дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар багтана. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтад “Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авч болно”, мөн 28 болон 29 дүгээр зүйлд Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг дарга нь “нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоох”, “орон нутгийн хамгаалалтад авах талаар санал боловсруулж, зохих байгууллагад уламжлах” эрхтэй хэмээн хуульчилсан нь орон нутгийн тусгай хамгаалалттай газрын эрх зүйн үндэс

болж буй бөгөөд энэ талаар дэлгэрэнгүйг хойно өгүүлэх болно.


1998 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн 3.4-т “Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, **нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ**” хэмээн заасан нь Монгол Улсын урт хугацааны хэд хэдэн томоохон бодлогын баримт бичигт тусгалаа олсон байдаг. Үүнд, 2014 оны “Ногоон хөгжлийн бодлого” (3.2.1: ...цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, ТХГН-ийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувьд хүргэх), 2016 онд баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (2.3.1: ...усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах), 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Монгол Улсын Алсын хараа -2050” (2050 онд ТХГН-ийн хэмжээг нийт газар нутгийн 35 хувь, хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувийг 75 хувьд хүргэх) зүй ёсоор орно.

Мөн түүнчлэн “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого” (УИХ, 1998), “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” (УИХ, 2001), “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” (УИХ, 2008), “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (УИХ, 2010) зэрэг бодлогын баримт бичгүүд, “Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр” (ЗГ, 1996), “Ус” үндэсний хөтөлбөр (УИХ, 2010), “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр” (УИХ, 2011), “Ойн тухай үндэсний хөтөлбөр” (ЗГ, 2001, 2011), “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр (ЗГ, 2005) зэрэг үндэсний хэмжээний хөтөлбөрүүдэд ТХГН-ийн сүлжээг өргөжүүлэн түүний удирдлагын тогтолцооны оновчтой бүтцийг бий болгож, орчин үеийн шаардлага


хангасан хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах замаар усны нөөцийг хамгаалах, ТХГН-ийн

ойн менежментийг хөгжүүлэх, говь, цөлийн бүсийн баянбүрдийн байршил нутгийг улс, орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар тусгажээ.

Зураг-2. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар (ангиллын төрлөөр нийт ТХГН-т эзлэх хувь)



Зураг-3. 1992 оноос хойш тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ





ТХГН-ийн сүлжээг тэлэх эдгээр зорилгын хүрээнд 1992 оноос хойш нийт 26,137,596 га газрыг тусгай хамгаалалтад авч 2021 оны эхэнд **32,919,804** га хүрч улсын газар нутгийн **21** хувийг эзэлж байна (БОАЖЯ, 2021b). Үүнд, дархан цаазат газар 21 (нийт ТХГН-ийн 42%), байгалийн цогцолборт газар 37 (ТХГН-ийн 41%), байгалийн нөөц газар 48 (17%), дурсгалт газар 14 (0,3%) байна (Зураг-2). Ялангуяа, 1992 оноос 2000 он хүртэлх 8 жилийн хугацаанд одоогийн нийт ТХГН-ийн 51 хувийг хамгаалалтад авчээ (Зураг-3).

ТХГН-ийн тархцын хувьд Дархан цаазат газрууд ихэвчлэн хил дагуу алслагдмал (Богдхан уулын ДЦГ зэрэг цөөн газрыг эс тооцвол) байхад Байгалийн цогцолборт газрууд төвийн болон баруун бүсэд, Байгалийн нөөц газрын нэлээд нь зүүн бүсэд байршилтай байна (Зураг-4). Дархан цаазат газрууд хилийн бүсээр том хэмжээний талбайтайгаар байгуулагдсан нь Монгол Улс гаднаас түрж орж ирсэн байгалийн томоохон мужуудын шилжилтийн зааг дээр оршдогтой холбоотой юм. Аливаа бүс бүслүүрийн шилжилтийн зааг нутаг бол шинэ зүйл бий болоход амархан, байгаа зүйл устахдаа ч амархан эмзэг экосистем байдаг учраас хамгаалалтад авах гол үндэслэл болсон байна. Мөн хүн амын төвлөрлөөс зайдуу байгаль орчны зөрчилд өртөх магадлал бага байх талтай ч нүүдлийн зүйлүүдэд эрсдэлтэй, механик хаалт ихтэй шилжилт хөдөлгөөнд сөрөг нөлөөтэй байдаг.

Монгол Улсын ТХГН-ийн сүлжээ нь манай орны ойн сангийн 36,8 хувь, гол, горхи, булаг шанд, нуур, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эх, гадаргын усны 44,7 хувь, устах аюулд орсон болон устаж болзошгүй 300 гаруй амьтан, ургамлын зүйлийн үндсэн тархац нутаг, байгалийн үзэсгэлэнт газар, үндэсний түүх, соёлын үнэт өв бүхий газар нутгийн 80 хувь орчмыг тус тус хамарч байна (БОАЖЯ, 2018).

Ардчилсан Үндсэн хууль баталснаас хойших сүүлийн гучин жилийн хугацаанд Монгол Улс байгаль орчны хорь гаруй олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсны дотор НҮБ-ын суурь гурван конвенц, тэдгээрийн протокол, гэрээнүүд зүй ёсоор орох бөгөөд эдгээр нь ТХГН-ийн удирдлага,

менежментийн зорилгод шууд хамааралтай, бодлого эрх зүйн таатай орчныг бүрдүүлж байдаг (Зураг 5).

ТХГН-ийн удирдлагад хамааралтай хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн баримт бичгийн ихэнх нь Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан журмууд байна (Зураг 6). Эдгээрийн зарим нь ТХГН-т зэрлэг амьтны сүргийн бүтэц зохицуулж заазлах, чоно агнах, ойн аж ахуйн арга хэмжээ явуулах зэрэг биологийн олон янз байдлыг хамгаалах үндсэн зарчимд төдийлөн нийцэхгүй байгааг хүчингүй болгох, сүүлийн үеийн судалгаа шинжилгээ, нөөцийн тооллогын дүнд үндэслэн шинэчлэн найруулж сайжруулах шаардлага буй нь харагдаж байна.


ТХГН-ийнхуульэрхзүйбодлогынтогтолцоог бүрдүүлэх ажлыг тухайн асуудлыг төрөөс эрхэлсэн институт хариуцан хэрэгжүүлсэн байдаг. Монгол Улсын Засгийн газар 1992 онд Байгаль орчны яамыг байгуулахдаа ТХГН-ийн асуудал хариуцсан орон тоо буй болгож улмаар Дархан газар, байгалийн аялал жуулчлалын улсын алба байгуулснаар ТХГН-ийн удирдлагын **институт** албан ёсоор буй болжээ (Д.Мягмарсүрэн & А.Намхай, 2012). Үүнээс хойш албан нэр, харьяалал, орон тооны хувьд хэд хэдэн өөрчлөлт гарсан ч ТХГН-ийг тэлэх, хууль эрх зүй бодлогыг боловсронгуй болгох, тэдгээрийг хэрэгжүүлэхэд удирдлагаар хангах үндсэн чиг үүргээ гүйцэтгэсээр ирсэн байна. ТХГН-ийн институт нь дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хувьд босоо бүтэцтэй, түүний анхан шатны нэгж болох Хамгаалалтын захиргаад нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагын ТХГН-ийн удирдлагын газарт шууд тайлагнадаг. Өнөөгийн байдлаар нийт 34 Хамгаалалтын захиргаа улсын тусгай хамгаалалттай 120 газрын менежментийг хариуцаж (БОАЖЯ, 2020) буй бөгөөд зарим Хамгаалалтын захиргаад хэд хэдэн газрыг нэгтгэн хамарч ажилладаг. Мөн “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 32 дугаар зүйлийн 2-т заасны дагуу Хустайн нуруу, Их Нарт, Тост, Тосон бумба, Хар ямаатын хамгаалалттай газрын менежментийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагууд гүйцэтгэдэг.

Байгалийн нөөц газар болон дурсгалт газрын менежментийг орон нутгийн засаг захиргаа хариуцдаг.

Мөн БНГ, орон нутгийн хамгаалалттай газрыг хуулийн этгээд төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гэрээгээр хариуцах, нутгийн малчид иргэдтэй хамтран орон

нутгийн засаг захиргаа хариуцан хамгаалж буй ТХГН-ийн засаглалыг төрөлжүүлэх цөөн тооны туршлага байгаа билээ. Гэвч энэ талаарх эрх зүйн орчин дутмаг, орон нутагт мэдлэг, чадвар, туршлага бага байгаа явдал нь цаашид өргөжүүлэн тэлэх боломжийг хязгаарлаж байна.


Зураг-4. 1992 оноос хойш Монгол Улсын нэгдэн орсон ТХГН-т хамааралтай НҮБ-ын конвенц, гэрээ хэлэлцээр






Зураг-5. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн байршил тархац (2021 оны эхний байдлаар)

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ



Зураг-6. 1992 оноос хойш ТХГН-ийн асуудлаарх Байгаль орчны сайдын баталсан журмууд



Эдгээрээс үзвэл 1992 оноос хойш Монгол Улс биологийн олон янз байдлыг экосистемийн болон ландшафтын хэмжээнд бүхлээр нь тусгайлан хамгаалах зорилгыг агуулсан олон улсын долоон гэрээ хэлцэл, суурь конвенцод нэгдэн орж даян дэлхийн байгаль орчны засаглалд идэвхтэй оролцогч улс болсон байна. Улмаар олон улсад тунхагласан эдгээр үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд улсын хэмжээнд ТХГН-т холбогдох 13 хууль, дөрвөн бодлого, есөн хөтөлбөрийг боловсруулан баталж ТХГН-ийн эрх зүй бодлогын орчин бүрдүүлжээ

(Хавсралт-1). Түүнчлэн тусгай хамгаалалтад авсан нутгийн хэмжээ социалист нийгмийн үеийнхтэй (6,739,937 га) харьцуулахад дөрөв дахин томорч (26,137,596 га) энэ хирээр Хамгаалалтын захиргаадын тоо дөрвөөс 34 хүртэл нэмэгдэн **ТХГН-ийн сүлжээ** болон өргөжжээ. ТХГН-ийн ангиллын хувьд дархан цаазат газар зонхилсон системээс Монгол Улсын ТХГН-ийн бүх ангиллын ТХГН-тай болж төрөлжсөн бөгөөд ялангуяа, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газрууд ихээхэн тэлж өнөөдөр нийт ТХГН-ийн 58 хувийг эзэлж байна.

ТХГН-ИЙН АНГИЛАЛ

Энэхүү бүлэгт Монгол Улсын ТХГН-ийн ангилал нь БХОУХ-ны ангилалтай менежментийн зорилго, онцлох шинж чанарын хувьд хэрхэн уялдаж буйг хянан үзлээ Хүснэгт-7.

Дүн шинжилгээнээс үзвэл манай улсын ТХГН-ийн дөрвөн ангилал нь БХОУХ-ноос тодорхойлсон ангилалтай менежментийн зорилго, онцлох шинж чанар буюу шалгуур үзүүлэлтийн хувьд ойролцоо байгаа нь дараах байдлаар харагдаж байна: ангилал I нь дархан цаазат газар, II нь байгалийн цогцолбор газар, III нь дурсгалт газар, IV нь байгалийн нөөц газартай дөхүү байна. Хамгаалалттай газрын дэлхийн мэдээллийн сан (ХГДМС *англ.* World Database on Protected Areas)-д манай улсын ТХГН-ийг мөн дээрх ангиллаар бүртгүүлжээ (UNEP-WCMC, 2021).

Зарим шалгуур үзүүлэлт дээр (х) тэмдэг тавьсан нь тухайн үзүүлэлт байхгүй эсхүл хэрэгжихгүй байгааг илэрхийлж буй. Тухайлбал, Богд хан уул, Горхи-Тэрэлж зэрэг ТХГН-т “хүний аливаа үйл ажиллагаанаас ангид, хүн ирдэггүй, суурьшил хориотой байх” гэдэг шаардлага хэрэгжихгүй байгаагаас байгаль хамгааллын зорилгод хүрэхэд хүндрэл учирдгийг нийтээр мэддэг.

Нөгөөтээгүүр өмнөх бүлэгт гарсанчлан ТХГН-ийг шинээр байгуулахад үндэслэл болохуйц, хамгааллын менежмент хийхэд болон менежментийн төлөвлөгөө боловсруулахад стандарт тогтоохуйц чиглэл заалт дутмаг, БХОУХ-ноос тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг бодвол ихээхэн ерөнхий байгаа нь харагдлаа.

Иймэрхүү сул тал байгааг Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн “Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх” төслийн санхүүжилтээр хийсэн Монгол Улсын байгаль орчны хууль эрх зүйн баримт бичгүүдийг үнэлсэн үнэлгээний тайланд² дурдсан байдаг. Тухайлбал, ТХГН-ийн ангилал, менежментийн зүйл заалтууд нь:

- ТХГН-ийн менежмент хийх механизмыг тусгаагүй бэлгэдэл тунхагийн чанартай
- Зорилго, хүрэх үр дүн, олон нийтийн боловсрол гэх мэт чухал бүрэлдэхүүн хэсгүүд ороогүй
- Байгаль орчны тухай хуульдаа нийцүүлээгүй зэрэг сул талыг онцолжээ (Hannam, 2009)



² Тус үнэлгээг БХОУХ-ны “Байгаль орчны эрх зүйн комисс”-ын зөвлөх Ян Ханнам хийсэн.

Хүснэгт-7. Монгол Улсын ТХГН-ийн ангилал, зорилгыг БХОУХ-ны ангилалтай харьцуулсан нь

БХОУХ-ны ТХГН-н ангилал, менежментийн зорилго	БХОУХ-ноос тодорхойлсон онцлог шинж чанар, шалгуур үзүүлэлт (Dudley, 2008)	Монгол Улсын ТХГН-н нийцэж буй ангилал, зорилго (ТХГН-ийн тухай хууль 1994 он)	Монгол Улсын ТХГН-н эрх зүйн актад орсон холбогдох шалгуур	Нийцэж буй эсэх
Ia. Дархан цаазат байгалийн нөөц газар	Экологийн ач холбогдолтой нягтшил бүхий, нутгийн унаган зүйлийн иж бүрдэлтэй байх, эсхүл байгалийн жам ёсны үйл явцаар болон богино хугацааны үйл ажиллагаагаар унаган зүйлийг тийм нягтшилд хүртэл нөхөн сэргээх чадамжтай байх			✓
	Экологийн үйл явцын хувьд хөндөгдөөгүй, нутгийн унаган экосистемийн бүрэн багцтай байх эсхүл менежментийн ахархан арга хэмжээгээр экологийн үйл явц нь нөхөн сэргэх чадамжтай байх	1/ Дархан цаазат газар (ДЦГ)	1/Байгалийн бүс, бүслүүрийн онцлог хэв шинжийг төлөөлж чадах унаган тэрхөө хадгалсан байдал	✓
	Хүний аливаа үйл ажиллагаанаас ангид, хүн ирдэггүй, суурьшил хориотойн тул байгаль хамгааллын зорилгоо хэрэгжүүлэх боломжтой байх	Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган тэрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилготой.	2/ Шинжлэх ухаан, танин мэдэхүйн онцгой ач холбогдол бүхий газар нутаг.	×
	Байгаль хамгааллын зорилгоо хэрэгжүүлэхэд далайцтай байнгын арга хэмжээ шаардахааргүй байх		ТХГН-н тухай хуулийн 7-р зүйл	✓
	Байгаль хамгааллын зорилгод нэмэр болохуйц газар ашиглалтын хэлбэр эргэн тойронд нь зонхилох			×
	Хүний үйл ажиллагааны нөлөөллийг хянахад суурь үзүүлэлт болохуйц байх			✓
Iб. Онгон зэрлэг газар	Хүний хөл хөдөлгөөн маш багатайгаар менежмент явуулах боломжтой			✓
	Аливаа гэнэтийн цочроог түр тогтоон барих менежмент хийх боломжтой (ялангуяа, далай тэнгисийн орчинд).			✓
	Зам, шугам хоолой, цахилгаан дамжуулах шугам, үүрэн телефоны цамхаг, газрын тос бусад суурин байгууламж, уул уурхай, усан цахилгаан станц, газрын тос, байгалийн хий зэрэг орчин үеийн дэд бүтэц, хөдөө аж ахуй (эрчимжсэн мал аж ахуй, арилжааны загас агнуур), үйлдвэрлэлийн болон олборлолтын үйл ажиллагаанаас ангид байх			✓
	Экосистемийн унаган төрх нь анхны цар хүрээндээ бараг хадгалагдсан, амьтны болон ургамлын аймгийн бүрдэл бүрэн буюу бараг бүрэн, махчин- өвсөн тэжээлтний тэнцвэртэй системтэй эрүүл бүрэн бүтэн байдлын өндөр зэрэглэлд орох	1/ Дархан цаазат газар	1/Байгалийн бүс, бүслүүрийн онцлог хэв шинжийг төлөөлж чадах унаган тэрхөө хадгалсан байдал	✓
	Экологийн үйл явц, экосистемийн өгөөжийг хадгалж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг барьж чадах, эволюцын үйл явцыг дэмжих хэмжээнд биологийн олон янз байдлыг хамгаалахуйц томоохон хэмжээтэй байх	Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган тэрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилготой.	2/ Шинжлэх ухаан, танин мэдэхүйн онцгой ач холбогдол бүхий газар нутаг.	✓
	Мотор хөдөлгүүргүй тээврийн хэрэгсэл ашиглах, эсвэл чухал тохиолдолд зөвхөн тусгай замаар хязгаарлагдмал байдлаар моторт тээвэр хэрэглэх		ТХГН-н тухай хуулийн 7-р зүйл	✓
	Хөндөгдөөгүй унаган төрх, аливаа дэд бүтэц, хөдөө аж ахуй, моторт тээврийн хэрэгсэл зэрэг орчин үеийн техник технологиос ангид байх			✓
	Зарим нэг байдлаар өөрчлөлтөд орсон ч унаган байдалдаа эргэн орж нөхөн сэргэх боломжтой газрууд, эсхүл багахан ч гэсэн тухайн хамгаалалттай газрын системдээ ихээхэн ач холбогдол бүхий цаашид өргөтгөж болохуйц			✓

II. Үндэсний парк Биологийн олон янз байдлыг түүний үндэс болох экологийн бүтэц, тэдгээрийг дэмжигч байгалийн үйл явцтай нь цогцоор нь хамгаалах, иргэдийн байгаль орчны боловсрол олох, амралт чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх боломжоор хангах зорилготой.	Ургамал, амьтны унаган зүйлүүд, тэдгээрийн амьдрах орчин, газарзүйн олон янз байдал нь шүтлэгийн болон шинжлэх ухааны, боловсролын, аялал зугаалгын, жуулчлалын үнэ цэнэтэй, биологийн болоод байгаль орчны үзэмжээрээ экологийн гол бүсчлэлийг төлөөлөхүйц газрууд Унаган зүйл, бүлгэмдлийн урт хугацаанд оршин тогтнох байдал, экосистемийн үйл явц, функцийг менежментийн үйл ажиллагаа шаардахгүйгээр хадгалж болохуйц экологийн хувьд чанартай, хангалттай том хэмжээний газар байх. Биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн, бүтэц, функц нь “байгалийн унаган” байдлаараа, эсхүл харь зүйл ноёрхох эрсдэл багатайгаар эхний байдалдаа эргэн орж сэргэх боломжтой газар	2/Байгалийн цогцолборт газар (БЦГ) Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий газар нутаг. 1/ Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, байгалийн бүс, бүслүүр, экосистемийн төлөөлөл бүхий газар нутаг 2/ Түүх, соёлын өв, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдолтой газар нутаг. өвөрмөц тогтоц бүхий газар нутаг ТХГН-н тухай хуулийн 13-р зүйл
III. Байгалийн дурсгалт газар Байгалийн өвөрмөц тогтолцоо, тэдгээрийн орчмын биологийн олон янз байдал, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах зорилготой.	Хүрхрээ, хясаа цохио, галт уулын тогоо, агуй, элсэн манхан, хөндий цайдам далайн ёроолын уулс, шүрэн бүтэц зэрэг геологийн болон геоморфологийн тогтцууд Агуйн оромж, эртний бичээс хадны сүг зураг зэрэг соёлын ул мөр бүхий байгалийн тогтоц Тахилгатай газар, булш хиргисүүр, хүрхрээ, аварга мод хад зэрэг нийгмийн тодорхой хэсэгт сүсэг бишрэлийн үнэ цэнэ бүхий байгаль-соёлын газрууд Тухайн экологитой холбоо бүхий соёлын өвийг хамгаалахад цаана нь ихээхэн ач холбогдол бүхий биологийн зүйл давхар хамгаалагддаг газрууд, жишээ нь, тухайн байгальтай холбоотой археологийн болон түүхийн дурсгалт газар	4/ Дурсгалт газар (ДГ) Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилготой газар нутаг. 1/Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхарга зүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор,хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамааруулж болно. 2/ Түүх, соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно. ТХГН-н тухай хуулийн 23-р зүйл

IV. Биологийн төрөл зүйл, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах газар	1) олон улсын, үндэсний, орон нутгийн ач холбогдолтой ургамлын зүйлүүд; 2) олон улсын, үндэсний, орон нутгийн ач холбогдолтой амьтны зүйлүүд (суурин ба нүүдлийн зүйлүүд орно) 3) тэдгээрийн амьдрах орчин Менежментийн байнгын идэвхтэй арга хэмжээ авч байж тухайн зүйлийг болон амьдрах орчныг хамгаалан авч үлдэх боломжтой. Аюулд өртөөд буй тухайн зүйлийг хамгаалах (жишээ нь: хамгийн сүүлийн популяци байж болно) Амьдрах орчныг хамгаалах, ихэнх тохиолдолд тухайн экосистемийн нэг хэсгийг хадгалах, нөхөн сэргээх Зорилтот зүйлийг хамгаалахын тулд хиймэл амьдрах орчин (жишээ нь хиймэл шүрэн бүлгэмдэл үүсгэх) бий болгох, нэмэгдэл тэжээл өгөх зэрэг арга замаар менежментийн идэвхтэй арга хэмжээ авч зүйлийн боломжит тоо толгойг барих Байгалийн онгон төрхтэй экосистем, амьдрах орчин нь хэт жижиг эсхүл нэлээд өөрчлөлтөд орсны улмаас жамаараа өөрөө сэргэх боломжгүй бол тэдгээрийг хадгалахын тулд идэвхтэй менежмент хийх Өвсөн тэжээлтэн үгүй бол мал оруулах, эсвэл өвсийг гараар хадах, эсхүл гидрологийн өөрчлөлттэй бол хиймэл суваг шуудуу татах гэх мэт Тухайн биологийн олон янз байдлыг дагасан соёлын онцлогтой экосистемийн идэвхтэй менежмент хийж олон янз байдлыг хамгаалах	3/ Байгалийн нөөц газар (БНГ) Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой газар нутаг. 5/ Орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ) Тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилготой газар нутаг 1/ Байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар; 2/ Ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар; 3/ Эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар; 4/ Газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар; 5/ Мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар. ТХГН-н тухай хуулийн 20-р зүйл
V. Хамгаалалттай ландшафт	Чухал ач холбогдол бүхий ландшафт/усан мандал болон хүн байгалийн шүтэлцээгээр буй болсон уламжлал, заншилд оршдог үнэт зүйлсийг хамгаалах, үргэлжлүүлэх зорилготой. Энэ ангиллын ТХГН нь биотик, абиотик орчин ба хүний үйл ажиллагааны харилцан шүтэлцээнд үндэслэдэг. Ландшафт/далайн эргийн болон арлын үзэсгэлэнтэй өвөрмөц тогтоц, амьтан ургамлын аймаг, амьдрах орчны хувьд болон соёлын онцлог бүхий газар Он цагийн шалгуурыг давсан хүн-байгалийн тэнцвэртэй харилцан шүтэлцээ, бүрэн бүтэн байдал нь хэвээрээ эсхүл тийм бүрэн бүтэн байдлыг нь эргүүлж сэргээх боломжтой Газар нутгаа ашиглах өвөрмөц уламжлалт арга барилтай, жишээлбэл, ХАА, ойн тогтвортой систем, эсхүл газарзүй, ландшафттайгаа нарийн зохицож тэнцвэртэй хөгжсөн амьдралын хэв маягтай	5/ Орон нутгийн тусгай хамгаалалттай газар Тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилготой газар нутаг 1/ Хамгаалалтад авах газрын хэмжээ нь хамгаалалтын үүрэг, зорилгыг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц талбайтай байх 2/ Байгалийн өвөрмөц тогтоцтой газар нутаг /геологийн ховор илэрц, мөнх цас, мөсөн гол, агуй, хүрхрээ, хясаа, хавцал, хунх, явар, цонж, рашаан булаг, баян бүрд, элсэн манхан, солирын цар, өрх, галт уулын тогоо, эртний ургамал, амьтдын олдвор бүхий газар/ 3/ Аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын жагсаалтанд орсон газар нутаг (Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай Байгаль орчны сайдын 2000 оны 07-р тушаал)

VI. Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт бүхий хамгаалалттай газар Байгалийн нөөцийг зохистой ашиглах замаар экосистемийг хамгаалах, улмаар зохистой ашиглалт, байгаль хамгааллыг зөв хослуулах зорилготой.	Байгалийн нөөцийг тогтвортой ашиглах замаар байгаль хамгаалах зорилготой нь онцлог. Тухайн газрын байгальтай холбоотой соёлын үнэ цэнийг хамгаалах зорилгыг багтаадаг тул хэмжээний хувьд томоохон байх нь цөөнгүй.	5/ Орон нутгийн тусгай хамгаалалттай газар	1/ Байгалийн унаган төрхөө хадгалсан байдал ✓
	Үйлдвэрлэлийн түвшний ашиглалт их хэмжээгээр явуулдаггүй Аливаа ашиглалтыг хэсэгчлэн хориглохыг зөвлөмж болгодог. Тухайлбал, нийт газрын гуравны хоёрт аливаа эдийн засгийн үйл ажиллагааг хориглох гэх мэт. Ийм шийдвэрийг тухайн улс, орон нутаг тухайн ТХГН-ийн онцлогт тааруулан өөрсдөө шийдэхээр заасан.	Тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилготой газар нутаг	2/ Байгалийн нөөц баялагийг нөхөн сэргээх шаардлага 3/ Элбэг ан амьтан, ургамлын ангилалд багтах боловч тухайн аймаг, сумын хэмжээнд нөөц багатай, хязгаарлагдмал тархац бүхий амьтан, ургамлын байршил нутаг ✓ 4/ Амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой нутаг (Байгаль орчны сайдын 2000 оны 07-р тушаал)

✓ - төстэй агуулга бүхий зүйл заалт байгаа

✗ - холбогдох эрх зүйн баримт бичигт төстэй зүйл заалт байхгүй

Мөн энэхүү номын эхэнд тайлбарласан ТХГН-ийн тодорхойлолтын дагуу шинжилбэл, манай ТХГН нь эдгээрийн ихэнх шинж чанарыг агуулсан хэдий ч “удирдлага, зохион байгуулалттай” байх буюу хамгаалалтад авсан байгалийн үнэт зүйлийг хадгалах хамгаалах идэвхтэй үйл ажиллагаа явуулах шинж чанар олонх байгалийн нөөц газар болон дурсгалт газарт байхгүй байна². БХОУХ-ны эхний

дөрвөн ангилал Монгол Улсын ТХГН-ийн системд байгаа ч сүүлийн үед маш эрчимтэй түгэн дэлгэрч буй V ба VI ангилал албан ёсоор манай холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд ороогүй байна. Эдгээр ангилалд зорилго болон менежментийн субъектийн хувьд илүү таарч байгаа орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ)-ын тухай хойно өгүүлэх болно.

ТХГН-ИЙН ЗАСАГЛАЛ БА ЗАРЧИМ

Монгол Улсын ТХГН-ийн систем нь засаглалын хэлбэрийн хувьд төрийн байгууллагын удирдлага зонхилдог бөгөөд үүнд, БХОУХ-ны тодорхойлсноор гэрээгээр менежмент хийж буй төрийн бус байгууллага ч хамаарна (Хустайн нуруу, Их Нарт, Тост Тосон бумба, Хар Ямаат). Манайд хувийн засаглалын хэлбэр байхгүй, харин хамтын засаглалын шинж чанар Дагуурын болон Увс нуурын хил дамнасан хамгаалалттай газарт байна (БОАЖЯ, 2018).

Уугуул болон нутгийн иргэдийн засаглалын хэв шинж нь манай улсад нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлбэрээр ОНТХГ-т хэрэгждэг. Тухайлбал, 2012 онд шинэчилсэн “Байгаль орчныг хамгаалах

тухай” хуулийн 47-р зүйл, 1994 оны “ТХГН-ийн тухай” хуулийн 3-р зүйлийн 28, 29, “Орчны бүсийн тухай”, “Газрын тухай”, “Ойн тухай”, “Төсвийн тухай” хуулиудаар нутгийн иргэд үе уламжлан нутаглаж ирсэн газрынхаа ой, бэлчээр, ялангуяа, тэдгээрийг орон нутгийн хамгаалалтад авсан бол, эсхүл УТХГН-ийн орчны бүсэд оршин суудаг бол хамтын менежмент хийх, байгалийн нөөцтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргахад оролцох, саналаа илэрхийлэх, орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан байгалийн нөөцийг нөхөн сэргээх, зохистой ашиглах үйл ажиллагаанд оролцох эрхтэйг баталгаажуулж өгсөн байдаг.

Эдгээр засаглалын хэлбэрээс гадна засаглалын чанарыг тодорхойлох зарчмын

² ТХГН-ийн тухай хуулийн 6-р бүлгийн 27 зүйлийн 10-т Хамгаалалтын захиргаа байгуулах заалтад энэ хоёр ангилал ороогүй.

талаар өмнө тайлбарласан билээ. ТХГН-ийн засаглал сайн байх үндэс нь хүний эрхэд-суурилсан тулгуур зарчмууд бүрэн дүүрэн хэрэгжих явдал байдаг. Монгол Улсын Үндсэн хуульд байгалийн баялаг төрийн, нийтийн өмч хэмээн зааж түүнд хамаатай хүний эрхийн гол зарчмуудыг тодорхойлсон ч эдгээр нь ТХГН-ийн хууль эрх зүйн акт, бодлогын баримт бичигт нарийн шингээж тусгаагүй, заримд нь ихээхэн ерөнхий байдлаар орсон байна.

Олон ургалч ба хууль ёсны дагуу байх зарчмын хувьд хүнийг нас, хүйс, үндэс угсаа, амьдралын хэв маяг, соёлын болон бусад онцлогоор нь ялгаварлан гадуурхалгүйгээр үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх боломж олгох Монгол Улсын Үндсэн хуулийн заалт³ ТХГН-ийн менежментийн зорилго, стратегийн асуудлаар хэлэлцэх, харилцан зөвшилцөх үйл явцад оролцох боломжоор хангах хэлбэрээр ороогүй;

Газар дээр нь эрх мэдэл өгөх: тухайн нөөцөд хамгийн ойр дэргэд нь байгаа институцид эрх мэдэл, хариуцлагыг шилжүүлэх зарчим нь ДЦГ ба БЦГ-ын Хамгаалалтын захиргаа харин БНГ ба ДГ-т орон нутгийн засаг захиргаа менежмент хийх хэлбэрээр хэрэгждэг;

Шударга байх: ТХГН-ийг байгуулах, менежмент хийхтэй холбоотой гарсан зардал, үр ашгийг ижил тэгш хуваах, зөрчил гарсан тохиолдолд шударга зарчмаар шүүх боломжоор хангах зарчмыг ТХГН-ийн эрх зүйн баримт бичгүүдэд онцгойлон тусгаагүй, бодит байдал дээр төсөл хөтөлбөрийн хэлбэрээр түр зуурын байдлаар хэрэгжүүлдэг;

Хохироохгүй байх: ТХГН-ийг байгуулж менежмент явуулахдаа ядуурал, эмзэг байдлыг ихэсгэх зэрэг нийгмийн өртөг гарз багатай байлгах зарчмыг мөн л бодлогын баримт бичигт тусгаагүй учир хамгаалалтад авахаас өмнө нийгмийн үнэлгээ нарийвчлан хийдэггүй, малчид уламжлалт нутгаа алдаж нийгмийн гарз хохирол гарах нь түгээмэл байдаг;

Удирдан чиглүүлэх: ТХГН-ийн ирээдүйн урт хугацааны алсын хараа, хамгааллын зорилгыг тодорхойлж, тууштай хэрэгжүүлэх зарчим манай ТХГН-ийн системд харьцангуй сайн хэрэгждэг, үндэсний хэмжээний хөгжлийн баримт бичиг, олон улсын конвенцын хөтөлбөрүүд, Засгийн газрын мөрийн хөтөлбөр зэрэгт шат дараатай тусгаж мөрддөг;

Сайн гүйцэтгэл: биологийн олон янз байдлыг үр дүнтэй хамгаалахын сацуу талуудын асуудлыг шийдвэрлэх, нөөцийг арвич хямгачаар ашиглах зарчим мөн л сайн хуульчлагдаагүй тул талуудын оролцоо хязгаарлагдмал, нутгийн малчид зэрэг бусад талын асуудлыг Хамгаалалтын захиргааны удирдлагын үзэмжээр шийдэх тал түгээмэл;

Хариуцлага: хариуцлагыг ойлгомжтой тодорхой хуваарилах, бүрэн тайлагнах, хариуцлагын асуудлаарх талуудын санал шүүмжлэлд зохистой хариу өгч ажиллах зарчим тодорхой хэмжээнд хэрэгждэг, төрийн байгууллагын үр дүнгийн гэрээ бусад хяналт мониторингийн хэрэгслийн хүрээнд хийдэг ч хүнд суртал авлигатай холбоотой шүүмжлэл гарсаар байдаг;

Ил тод байдал: бүх талуудад мэдээллийг ил тод тэгш хүртээмжтэй байлгах зарчим ТХГН-ийн эрх зүйн баримтуудад төдийлөн сайн тусаагүй, энэ утгаараа иргэдийн мэдэх, мэдээлэл авах эрх нэлээд зөрчигдөж шүүмжлэл их гардаг;

Хүний эрх: ТХГН-ийн засаглалыг хэрэгжүүлэхдээ хүний эрх ялангуяа, ирээдүй залуу үеийн эрхийг хүндэтгэж ажиллах зарчим нь бусад зарчмыг бодвол тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай холбоотойгоор нэлээд өргөн түгсэн нийтээр хэрэгжүүлэхийг эрмэлздэг зарчим юм.

Манайд засаглалын эдгээр тулгуур зарчмууд ТХГН-ийн хууль эрх зүй, бодлогын баримт бичигт сайн тусаагүй, үүнээс үүдэн байгаль хамгааллын зорилгоо хэрэгжүүлэх засаглалын чанарт сөргөөр нөлөөлж байдаг нь харагдаж байна.

³ ТХГН-ийн тухай хуулийн 6-р бүлгийн 27 зүйлийн 10-т Хамгаалалтын захиргаа байгуулах заалтад энэ хоёр ангилал ороогүй.

ТХГН-ИЙН ЗАСАГЛАЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Манай улсын ТХГН-н засаглалд давуу эрхтэй тал нь ДЦГ ба БЦГ-ын хувьд төрийн нэрийн өмнөөс байгаль хамгааллын хууль бодлогыг эрхэлсэн төрийн төв байгууллага болох БОАЖЯ, ТХГН-ийн Захиргаад, харин БНГ, ДГ, ОНТХГ-н хувьд тухайн аймаг, сум дүүргийн засаг захиргаа болж байна. Харин оролцогч талууд нь тухайн хамгаалалттай газрын орчимд оршин суугч иргэд, малчид, тэнд үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагууд, аялал жуулчлалын компаниуд, байгаль хамгаалах төсөл хөтөлбөр хэрэгжүүлж

буй олон улсын байгууллага болон дотоод гадаадын төрийн бус байгууллагууд болж байна Хүснэгт-8.

Монгол Улсын Үндсэн хуульд байгалийн баялаг төрийн, нийтийн өмч байхаар заасан хэдий ч ТХГН-н хамгааллын эрх үүрэг, үйл ажиллагааны нягтрал төрийн байгууллагад төвлөрч байгаа нь БХОУХ-ноос чиглэл болгож буй засаглалын олон хэлбэр, олон талт хамтын ажиллагаа, олон янз байдал хязгаарлагдмал болж хамгааллын зохистой менежмент хараахан биш болоод байна.

Хүснэгт-8 Монгол Улсын ТХГН-ийн засаглалд оролцогч талууд

Төрийн оролцогч	Төрийн бус талын оролцогч
- Улсын Их Хурал - Засгийн Газар - БОАЖЯ, Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар - БОАЖЯ-ны НҮБ-ийн конвенц хариуцсан албан тушаалтнууд - БОАЖЯ-ны холбогдох газар, хэлтэс (хуулийн хэлтэс г.м.) - ТХГН-ийн 34 захиргаа (дарга, албан хаагчид, байгаль хамгаалагчид) - Аймаг, нийслэлийн ИТХ - Аймаг, нийслэлийн засаг дарга - Сум, дүүргийн ИТХ, засаг дарга - Багийн Иргэдийн нийтийн хурал - Багийн засаг дарга - Хууль сахиулах байгууллагууд (Экологийн цагдаа, гааль г.м.) - Усны сав газрын захиргаад - Ойн ангиуд - Эрдэм, шинжилгээ судалгааны байгууллагууд: ШУА-ийн хүрээлэнгүүд, Их дээд сургуулиуд)	- Нутгийн иргэн, малчин - Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, холбоо - Малчдын бүлэг, хоршоо, ТББ-ууд - ОУ-ын олон-талт ба хоёр талын хамтын ажиллагааны байгууллагууд - ОУ-ын болон үндэсний ТББ-ууд - Мэргэжлийн байгууллага - Үнэлгээний компаниуд - Аялал жуулчлалын компаниуд - ТХГН-ийн орчмын бизнес, аж ахуйн газрууд (зочид буудал, зоогийн газар, уул уурхай, газар тариалан г.м.) - Дотоод, гадаадын жуулчид - Дотоод, гадаадын хандивлагчид

Үүнээс үүдэн улсын төсөвт ихээхэн ачаалал үүсэх, боловсон хүчин, техник хэрэгсэл дутах, өргөн уудам газар нутгийг бүрэн хамгаалж чадахгүй байх зэргээс менежмент үр ашиггүй болж хамгааллын үндсэн зорилгоо хэрэгжүүлэхэд төвөгтэй болж байна.

БХОУХ-ноос зөвлөж байгаа хэдэн үеэрээ нутаглаж байсан унаган иргэд нь ТХГН-ийн давуу эрхтэй тал байх, засаглалд хэрхэн оролцох асуудал манайд мөн л хуульчлагдаагүй байдаг.

МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭРЭГСЭЛ

Нэгдүгээр бүлэгт тайлбарласан ТХГН-ийн менежментийн арга хэрэгслүүдийг манай ТХГН-ийн системд өргөн ашигладаг. Эдгээр арга хэрэгсэл нь даян дэлхийн түвшнээс орон нутгийн түвшин хүртэл босоо байдлаар болон тухайн ТХГН-т болон түүний орчимд

хэрэгжүүлэх хэвтээ хэлбэрийн зэрэг олон төрөл зүйлтэй байдаг. Тэдгээрийг манайд хэрхэн ашиглаж буйг дараах байдлаар тоймлон хүргэе.

Олон улсын хууль, конвенц, стандарт:
Манай улс олон улсын олон талт хорь гаруй

гэрээ хэлэлцээрт нэгдэн орж, тэдгээрийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх ажлыг хууль эрх зүй, бодлого хөтөлбөртөө тусган ажиллаж байгаа нь энэ арга хэрэгслийг ашиглаж байгаа хэлбэр юм. Харин БХОУХ, Дэлхийн ТХГН-ийн Комисс зэрэг энэ чиглэлийн үйл ажиллагааны стандарт тогтоодог байгууллагуудын удирдамж, чиглэлийг мөрдөж, одоо байгаа хууль эрх зүйн орчин, менежментийн арга зүйг стандартчилах явдал нухацтай сайн хийгдэж чадаагүй байгаа юм.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөө: Энэ арга хэрэгслийн төрөлд Монгол Улсын Үндсэн хуулиас эхлээд байгаль хамгааллын тулгуур хууль тогтоомж болох “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль болон нөөцийн хуулиуд (газар, ус, ой, амьтан, ургамал, хөрс) нөөц ашиглалтын хуулиуд (газрын төлбөр, хог хаягдал, аялал жуулчлалын тухай хуулиуд), мөн хууль сахиулах чиглэлийн эрүүгийн, зөрчлийн хуулиуд ч хамаарна. Мөн дээр дурдсан үндэсний таван бодлого, есөн хөтөлбөр багтана.

ТХГН-ийн тухай эрх зүйн баримт бичиг, менежментийн төлөвлөгөө: ТХГН-ийн системийн харилцааг зохицуулдаг хоёр үндсэн хууль, нэг үндэсний хөтөлбөр байгаагаас гадна ихэнхдээ нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын хэлбэрээр (Байгаль орчны сайдын тушаалаар баталдаг журмууд) зохицуулагдаж байгааг өмнө дурдсан. Энэ төрлийн арга хэрэгслийг шинэчлэх, төрөлжүүлэх шаардлага манайд байна. Харин 1998 онд баталсан ТХГН-ийн үндэсний хөтөлбөрт тусгасны дагуу ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө гаргаж ажиллах нь донорын төсөл хөтөлбөрийн хүрээнд голдуу хэрэгждэг байдал эцэс болж 2021 оны 1 дүгээр сард “Тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөлтийн аргазүйг батлах тухай” БОАЖ-ын сайдын тушаал гарч журам батлагдсан нь энэ арга хэрэгсэл албажсан чухал ач холбогдолтой ажил болсон.

Тухайн нутагт сахиж мөрддөг уламжлалт ёс жаяг: Энэхүү албан бус институцийн арга хэрэгсэл алс хөдөө нутгийн ард иргэдийн дунд үр дүнтэй ач холбогдолтой хэвээр байдаг ба түүнийг менежментийн

зорилгоор зориудаар ашиглах нь байгалийн нөөцийн хамтын менежментийг хөхүүлэн дэмжих бодлогоор хэрэгждэг (Байгаль орчин хамгаалах тухай хуулийн 8 дугаар бүлэг). Гэхдээ институцийн хувьд албан ёсоор хүлээн зөвшөөрч тусгайлсан хуулийн статус буй болоогүй байна. Тухайлбал, Намиби Улсад “Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн байгууллагын тухай” хууль байдаг.

Мэргэжлийн зөвлөл, эксперт техникийн хороод: Ийм мэргэжлийн зөвлөл, хороод нь БОАЖЯ дээрх конвенц бүрийн удирдах хороо, БОАЖ-ын сайдын дэргэд болон БОЯБ-ын томоохон төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч багийн дэргэд байгуулдаг ч шийдвэр гаргах үйл ажиллагаанд тэр бүрий оролцуулах мэргэжлийн зөвлөгөө авах нь тогтмол биш байдаг.

Нийгмийн урамшууллын болон шийтгэлийн систем: Энэ арга хэрэгсэл албан институцийн хэлбэр болох хууль тогтоомж, журмын хүрээнд төрөл бүрийн шагнал урамшууллын болон шийтгэлийн хэлбэр одон медаль цол тэмдэг өгөхөөс эхлээд шоронд хорих хүртэл олон төрөлтэй байдаг. Харин тухайн нутагт ан амьтан ховор ургамал хууль бусаар авах зэрэг буруу үйлдэл хийвэл нэгнийгээ нутаг нугаар жигшиж зэвүүцэх, “нутгийн нэр сэвтүүлээ” хэмээн дургүйцэх, ахмадууд загнах, гай зовлон тохиолдвол хийсэн үйлтэй нь холбож ярих зэрэг ёс заншил, уламжлалын хэлбэрээр албан бус институц ажилладаг.

Мөнгөн урамшуулал ба шийтгэл: Албан институцийн хүрээнд эрүүгийн, зөрчлийн хууль, бусад холбогдох хуулиар нэлээд өндөр торгууль төлж шийтгүүлдэг бол гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл өгсөн иргэнд мөнгөн урамшуулал олгох заалт байдаг. Харин албан бус институцийн хэлбэр нь байгаль хамгааллын олон нийтийн байгууллага, хувийн компани, нутгийн зөвлөл зэрэг төрийн бус талууд байгаль хамгаалсан сайн үйлстнийг мөнгөн шагналаар шагнах нь цөөн ч гэсэн байдаг.

Санхүүгийн хөрөнгө оруулалт: Энэ арга хэрэгсэл манай ТХГН-ийн сүлжээнд хамгийн өргөн хүрээнд байдаг. Улсын болон орон нутгийн төсвөөр санхүүжилт, хөрөнгө оруулалт хийхээс гадна, гадаадын хандивлагч, Дэлхийн



банк, Азийн хөгжлийн банк, Германы Сэргээн босголт зээлийн банк (KfW) зэрэг олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хөрөнгө оруулалтын байгууллагууд болон НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр зэрэг НҮБ-ийн системийн байгууллагууд, Даян дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) зэрэг нэлээд хэдэн ОУ-ын ТББ-ууд Монгол Улсын ТХГН-т хөрөнгө оруулалтын болон техникийн туслалцааны төсөл хөтөлбөрийг 1995 оноос хойш хэрэгжүүлж байна.

Хүний нөөцийн болон цаг хугацааны хөрөнгө оруулалт: Энэ арга хэрэгсэл нь манайд төдийлөн хэвшил болоогүй гэж болно. Учир нь байгаль хамгаалалд өөрийн хөдөлмөрөө цагаа сайн дураар зориулдаг сайн үйлсийн ажлыг хэлж байгаа бөгөөд гадаадын орнуудад мод тарих, харь зүйлтэй тэмцэх, байгалийн нөхөн сэргээлт хийх зэрэг маш олон ажлыг сайн дурынхны хүчээр хийдэг. Манайд түгээмэл болж байгаа хэлбэр нь ОНТХГ-т идэвхтэн байгаль хамгаалагчаар ажиллах юм.

Мэдээлэл, орчноор хангах: Энэ арга хэрэгсэл хөдөө орон нутагт нэлээд түгээмэл байдаг. Байгаль хамгааллын болон ТХГН-ийн шугамаар уулзалт хэлэлцүүлэг хийх, санал солилцоход орон нутгийн байгууллагууд мэргэжилтнээ оролцуулж, байр, утсан харилцаа, компьютер, проектор зэргээ найр тавин ашиглуулдаг. Харин төв суурин газар энэ нь түгээмэл биш байдаг.

Боловсролын хөтөлбөр: Байгаль хамгааллын боловсрол монголын ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрөөс эхэлдэг ч ТХГН-ийн сэдвээр бусад мэргэжлийн болоод дээд боловсролын байгууллагад хичээл ордоггүй. Байгаль хамгааллын дээд боловсрол олгох сургуульд ч энэ чиглэлийн сэдэвт маш цөөн цаг оногддог. Харин төсөл хөтөлбөрийн шугамаар тухайн зорилтот газрын иргэдэд богино хугацааны ур чадварын сургалт, мэдээлэл өгөх сургалт нэлээд хийдэг.

Цалин, материаллаг болон захиргааны дэмжлэг: Энэ арга хэрэгсэл нь улсын төсвөөр санхүүждэг төрийн байгууллагуудад

байхаас гадна гадаадын хандивлагчдын санхүүжилттэй төсөл хөтөлбөрийн хүрээнд материаллаг (тоног төхөөрөмж, оффисын тохижилт, тоног төхөөрөмж г.м.) болон захиргааны дэмжлэгийн (хурал семинар хэлэлцүүлэг зохион байгуулах) хэлбэртэй байдаг.

Судалгааны болон сургалтын хөтөлбөр: ТХГН-т биологийн мониторинг хийх, зэрлэг амьтан ургамал, идэш тэжээлийн зэрэг шаардлагатай судалгааг төрийн харьяа эрдэм шинжилгээний байгууллагууд хийхээс гадна хандивлагчийн санхүүжилттэй олон улсын эксперт, мэргэжилтнүүдийг оролцуулан хийх нь түгээмэл арга хэрэгсэл юм. Мөн ийм судалгааны болон сургалтын хөтөлбөр боловсруулах ажил ч ордог.

Мониторинг үнэлгээ: ТХГН-ийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тодорхойлох, тэдгээрийн дагуу явцын мониторинг хийх, эцсийн үнэлгээ хийх зэрэг арга зүйг холбогдох бичиг баримт, заавар журамд тусгах, батлах, шаардлагатай ур чадварыг олгох зэрэг ажлууд төрийн сургалтын байгууллагын шугамаар болон хандивлагчийн төсөл хөтөлбөрийн хугацаанд хийгдэж байдаг түгээмэл арга хэрэгсэл. ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээг олон улсад өргөн хэрэглэгддэг SMART, METT зэрэг оролцооны арга зүйгээр дийлэнх ТХГН-т хийдэг болсон ба зарим шалгуур үзүүлэлтийг Монголын онцлогт тохируулан өөрчилж, өөрийн арга зүйг батлан хэрэглэж байгаа давуу талтай

Зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх биет ажил: ТХГН-ийн сүлжээнд явагдаж буй бүхий л үйл ажиллагаа энэхүү зорилгод чиглэдэг ч арга хэрэгслийн хувьд хашаа барих, хаалт тавих, шуудуу татах зэргээр биет саад бий болгохыг энд хэлж буй. Өргөн уудам нутагтайгаас өртөг зардал ихтэй болон угаасаа нүүдэлчдийн хашаа саад босгодоггүй ёс заншлаас улбаалан манай ихэнх ТХГН-ууд ямар нэг биет саад бараг байдаггүй, тэр ч байтугай хамгаалалттай газрын хилийн тэмдэгжүүлэлтээ ч бүрэн хийж чадахгүй байгаа тул энэ нь төдийлөн түгээмэл биш арга хэрэгсэл гэж болно.

ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР

Хамрах хүрээ

Байгаль орчин аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны Байгаль орчны мэдээллийн сангийн 2021 оны мэдээгээр нийт 2745 аймаг нийслэл, сум дүүргийн ОНТХГ байгаа нь 68,8 сая га талбайг хамарч байна. Үүнээс гуравны хоёр нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хилийн заагтай хэсэгчилсэн болон бүрэн давхцалтай зэрэг газарзүйн зөрчилтэй, харин 33 хувь буюу 22,6 сая га талбай бүхий 1366 ОНТХГ аливаа зөрчилгүй байна (БОАЖЯ, 2021a). Эдгээр зөрчилгүй ОНТХГ-т үйл ажиллагаа явуулж буй бүртгэлтэй 89 нөхөрлөл байгаа бөгөөд үйл ажиллагааны чиглэл, зорилгоор нь авч үзвэл 60.7% нь ойн менежмент, 23.6% нь бэлчээрийн менежмент, 11.2% нь агнуурын менежмент, 4.5% нь бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн байна.

Эрх зүйн орчин

Улсын нийт нутаг дэвсгэрийн 14 хувийг эзэлж буй эдгээр ОНТХГ-ыг байгуулах, менежмент хийх эрх зүйн үндэслэл нь Үндсэн хуулийн 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч” гэсэн заалт, өмнө дурдсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт, уг хуулийн 28 дугаар зүйлийн 1.3, 29 дүгээр зүйлийн 1.2-т тус тус тусгасан аймаг, нийслэл, сум, дүүргийн тодорхой газар нутгийг ОНТХ-д авах талаар санал боловсруулж, зохих байгууллагад уламжлах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоож хэрэгжүүлэхээр хуульчилсанд оршино.

Мөн “Газрын тухай” хуулийн 10 дугаар зүйлд заасан улсын газрын нэгдмэл сангийн ангиллаар Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газрын 2017 оны А/73 тоот тушаалаар баталсан “Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, газрын кадастрын санд бүртгэх заавар”-ын дагуу мэдээллийн санд ОНТХГ-ыг бүртгэж баталгаажуулдаг.

Байгаль орчны сайдын 2000 оны 07 тоот тушаалаар баталсан “Газар нутгийг орон

нутгийн хамгаалалтад авах тухай” журмыг одоо мөрдөж байна. Тус журамд ОНТХ-д авах зорилго, шалгуур, түүний ангилал”, хамгаалалтад авах тухай санал гаргах, шийдвэрлэх”, ОНТХГ-ын санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулсан байдаг. Түүнчлэн 1998 оны “ТХГН-ийн үндэсний хөтөлбөр”-ийн 4.5.1-т заасны дагуу ОНТХГ нь менежментийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг.

Өнөөгийн байдал

Хэдийгээр ОНТХГ-ын эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрэлдэж нийт нутгийн 40 гаруй хувийг эзлэх хэмжээний (зөрчлийг эс харгалзвал) газрыг орон нутгийн хамгаалалтад авсан ч хамгааллын зорилгодоо хүрсэн сайн менежмент, засаглал бүхий ОНТХГ маш цөөн байна. НҮБХХ-өөс 2013-2018 онд хэрэгжүүлсэн “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийн дэмжлэгтэй Дорнод аймгийн Түмэнхаан-Шалз ОНТХГ (Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-уул, Хэнтий аймгийн Норовлин сумдын 374,499 га), Хэнтий аймгийн Хавтгар ОНТХГ (Батширээт сумын 104,900 га), Увс аймгийн Гулзат ОНТХГ (Сагил, Бөхмөрөн сумдын 203,316 га) байгуулсан нь загвар болохуйц хамгааллын менежмент бүхий анхны газрууд болов. Ер нь бүртгэлтэй байгаа ОНТХГ-ын менежментийн үр дүнд улсын хэмжээний эсхүл бүсчилсэн хэлбэрээр үнэлгээ хийх шаардлага байгаа хэдий ч сайн менежменттэй, хамгааллын зорилгодоо хүрч чадаж байгаа ОНТХГ нэн ховор буй нь эрх зүйн орчин бүрэн бүрэлдээгүй, ОНТХГ-ын удирдлагын чиг үүрэг бүхий институт байхгүй, эсвэл одоогийн УТХГН-ийн удирдлагын бүтцэд ордоггүй, үйл ажиллагааны санхүүжилт тодорхойгүй, байдаггүй, менежмент явуулахаар үүрэг хүлээсэн этгээдийн хүчин чадал, чадавх сул зэрэг олон хүчин зүйлтэй холбон үзэж болохоор байна (UNDP, 2018).

Энэ байдал нь УТХГН-ийн ангилалд албан ёсоор ордог байгалийн нөөц газар ба дурсгалт газрууд Хамгаалалтын захиргаа байдаггүйгээс “цаасан дээрх” хамгаалалттай газар болдогтой агаар нэг болоод байна

(Reading et al., 2016). Нөгөөтээгүүр Засгийн газраас хэрэгжүүлсэн “Алт” хөтөлбөрийн байгаль орчинд үзүүлсэн сөрөг үр дагавраас улбаалан “Ашигт малтмалын тухай” хуулиар улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон заалтыг ашиглан орон нутгийн засаг захиргаа уул уурхайн үйл ажиллагаа өөрийн нутагт явуулахаас хамгаалах зорилгоор ОНТХГ байгуулах нь түгээмэл байсныг мэргэжлийн хүмүүс мэднэ. Тухайлбал 2013-2018 оны таван жилд нийт ОНТХГ-ын 60 орчим хувийг хамгаалалтад авсан байна. (БОАЖЯ, 2021a)

Газар нутгийг ОНТХГ-т авах шат дараалал

1. ОНТХ-д авах газрыг тодорхойлох, хамгаалалтад авах санаачилга гаргах: Монгол орны экологийн бүс нутгийн үнэлгээгээр сонгогдсон экологийн хувьд онцгой ач холбогдолтой экологийн холбоос нутгийг тусгай хамгаалалтад авахыг орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн иргэд, иргэн санаачилж ажлын хэсэг байгуулж ажиллана.
2. ОНТХГ-т газар нутгийг авах үндэслэл боловсруулах: Ажлын хэсэг үндэслэл саналыг боловсруулахдаа газар нутгийг ОНТХ-д авах зайлшгүй шаардлагатайг баталсан судалгаанд үндэслэсэн байна. ОНТХГ-ын талбайн хэмжээ, хилийн зааг, байгаль-түүх соёлын дурсгал, ач холбогдол, хамгаалах шаардлага, нийгэм-эдийн засгийн байдал, нутгийн иргэдийн санал зэргийг оруулна. Газар нутгийг ОНТХ-д авах үндэслэл, холбогдох бүх мэдээллийг шийдвэр гаргах байгууллагад өргөн барьж танилцуулна.
3. Аймаг, сумын ИТХ-аар батлах: Аймаг, сумын Засаг дарга асуудлыг засаг даргын Зөвлөлөөр хэлэлцүүлж улмаар орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Иргэдийн Хуралд өргөн барина. Иргэдийн хурал асуудлыг ИХ-ын дэргэдэх байгаль орчны хороо, Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлж улмаар ИТХ-д оруулж шийдвэрлүүлэн ИТХ-ын тогтоол гаргаж баталгаажуулна. ОНТХ-д авахаар

санал болгож буй газар нэг сумын нутагт байвал тухай сумын ИТХ, хоёр болон түүнээс дээш сумын нутагт байвал сумдын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын тогтоолоор баталгаажна.

4. Кадастрын мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулах: Газар нутгийг ОНТХ-д авах сум, аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоол гарсны дараа ажлын 10 хоногт багтаан Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (АМГТ)-т тогтоолыг хүргүүлж газрын кадастрын мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулна.

ОНТХ-д газруудыг тодорхой хугацаагаар авах бөгөөд хамгаалалтад авсан хугацаанд хамгаалсан зорилго биелээгүй бол ангилал дээшлүүлж улсын тусгай хамгаалалтад авах, хугацааг сунгах, эсвэл чөлөөлөх боломжтой. Үүнд хамгийн багадаа 5 жилээс доошгүй, уртдаа 30 жил хүртэл хугацаагаар авч болно. Аймаг, сумын ИТХ-ын тогтоолын хугацаа дуусгавар болсноор тус газар нутаг шууд чөлөөлөгдөнө. ОНТХГ-ыг цаашид үргэлжлүүлэн хамгаалалтад байлгах шаардлагатай бол тогтоолын хүчинтэй хугацаа дуусгавар болохоос 6 сарын өмнө үндэслэлийг боловсруулж холбогдох аймаг, сумын удирдлага, нутгийн иргэдэд танилцуулна. Улмаар ИТХ-аар хэлэлцүүлэн тогтоолыг гаргаж ОНТХГ-ын хамгаалалтад байх хүчинтэй хугацаа дуусгавар болохоос ажлын 10 хоногийн өмнө АМГТГ-т уламжлан хугацааг сунгуулна.

ОНТХГ-ын хамгаалалтын дэглэм

ОНТХГ-т нутгийн иргэд байгаль орчноо хамгаалах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр нөөцөө зохистой ашиглах, нутгийн иргэдийн байгаль хамгаалалд оролцох оролцоог дэмжих дараах үйл ажиллагааг явуулж болно.

- Нутгийн иргэд бэлчээрийн даацад нийцүүлэн уламжлалт мал аж ахуй эрхлэх.
- Уламжлалт мал аж ахуйгаа дэмжих хадлан бэлтгэх, отор нүүдэл хийх, уст цэг байгуулах, булаг шанд задгайлах зэрэг бүхий л үйл ажиллагааг явуулах.
- Газар, ус, ой, ойн дагалт баялаг, ургамал, амьтныг өсгөн үржүүлэх, зохистой ашиглах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх.

- Байгалийн аялал жуулчлалыг тогтсон замналын дагуу явуулах, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх
 - Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, цас борооны, үерийн ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, ойжуулах, ургамалжуулах.
 - Байгалийн хэв шинж, унаган төрх, ургамал амьтны байршилд сөрөг нөлөөгүй хэлбэрээр аялал жуулчлалын отог, судалгааны цэг байгуулах
- ОНТХГ-т хориглох үйл ажиллагаа**
- Орон нутгийн ТХГН-т дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
- Орон нутгийн тусгай хамгаалалттай газарт ашигт малтмал, газрын тос, занар, байгалийн хий, цацраг идэвхт бодис хайх, ашиглах, олборлох;
 - Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээ нэмэгдэхийн хирээр улсын хэмжээнд орон нутгийн хамгалалталтад авах хэрэгцээ нь байгалийн бүс, бүслүүр, түүх өв соёлын дурсгалыг хамгаалах, бэлчээр, усыг хамгаалах шаарлагатай нийцэж буй эсэхийг тодорхойлох хэрэгцээ бий болсон.
 - ОНХГ-ын хамгааллын тогтвортой байдлыг хангахын тулд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийн цаашдын тогтвортой байдлыг хангахын тулд талуудын оролцоог нэмэгдүүлэх, эрх, үүргийг тодорхой болгох зорилгоор ОНТХГ-ыг ТХГН-ийн тухай хуулинд үүрэг, зорилго, ач холбогдол, статусыг тодорхой болгон тусгахын зэрэгцээ хамгаалалтын журмыг шинэчлэх баталгаажуулах цаг нэгэнт болжээ.



ХОЙД МОГОЙН ГОЛ – ТЭЭЛИЙН ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ нь Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын Цэнхэр, Булган сумын хэсгийн орчны бүсэд хэсэгчлэн хамаарах 137,018.2 га талбай бүхий Могойн гол, Жаргалантын голуудын хоорондох өргөн хөндий, Урд Тамирын гол руу тохойрон орсон үзэсгэлэнт сайхан газар билээ. Хангайн нурууны төв хэсгийн салбар уулс Шар булуу (2464 м), Гялаан уул (2402.0 м), Гуранзан уул (2185.0 м) зэрэг 1500-2500 м өндөр уулсын дунд оршиж, эдгээр нуруудаас хойд, урд Могойн гол, дунд, нарийн Тээлийн гол, Гялааны гол зэрэг олон гол горхи Тамирын голд цутгадаг.

Хангайн нуруу нь манай орны ой, тайга, говь, цөлийн аль алины тархалтын хүрээг хязгаарладаг байгалийн их мужийг үүсгэхээс гадна Хангайн нурууны ой нь гол мөрний ус, чийгийн горимыг тогтвортой барих, зохицуулах, хуваарилах, цэвдэг хамгаалах өндөр ач холбогдолтой. Тус нуруунаас эх авсан Орхон голын томоохон цутгалан Урд Тамирын голын адаг хэсгийг хамарч буй ус намгархаг газар, татмын ландшафт, олон салаа арлууд нь Хойд мөсөн далайн ай савын онцлог хэв шинжийг төлөөлдөг ба Монгол орны шувуудын амьдрах орчин, нүүдлийн шувуудын зусдаг газар юм.

Биологийн олон янз байдал, ландшафтын өвөрмөц хэв шинж хосолсон татмын ой болон гол руугаа түрж орсон ойт хээр бүхий энэ нутгийн экосистемийг хамгаалах шаардлага Архангай аймгийн төвөөс ердөө 10-100 км зайд байдгаас урган гарч ирсэн байдаг. Улсын баруун хязгаарыг нийслэлтэй холбосон магистраль зам мөн аймгийн төвийг дайран өнгөрдөг. Үүнээс үүдэн хулгайн мод бэлтгэл, ан агнуур, бэлчээрийн талхидал эрчимжиж

экосистем доройтож эхэлсэн нь орон нутгийн хамгаалалтад авах үндэслэл болжээ.

Архангай аймгийн Булган сумын ИТХ 2017 оны 5-р сарын 1-ний өдрийн 17 тоот тогтоолоор тус газрыг орон нутгийн хамгаалалтад авч, мөн сарын 19-нд Ашигт малтмал, газрын тосны газрын 7/3538 тоот тогтоолоор улсын кадастрт бүртгүүлсэн.

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг (ЛАСН) нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ)-ын Засгийн газрын “Дарвины санаачилга” сангийн санхүүжилтээр **“Ойт хээрийн экосистем болон ховордож буй зүйлүүдийг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь”** төслийг 2018 оноос хэрэгжүүлж тус ОНТХГ-ын менежментийн загварыг буй болголоо. Төслийн хүрээнд нутгийн малчдын “Булган сумын Нөхөрлөлүүдийн холбоо” гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага (ГҮТББ) байгуулахад техникийн туслалцаа үзүүлж, өнөөгийн байдлаар 162 өрхийн 292 малчныг эгнээндээ нэгтгэсэн 10 гишүүн нөхөрлөлтэй болоод байна.

Тус ГҮТББ-ын удирдлагын бүтэц нь 10 нөхөрлөлийн төлөөлөл орсон Удирдах зөвлөл, гүйцэтгэх үүрэг бүхий холбооны Гүйцэтгэх захирал, нөхөрлөлийн 10 ахлагч, 17 Идэвхтэн байгаль хамгаалагч (ИБХ) нар, 7 гишүүнтэй Хяналтын зөвлөлөөс бүрдэнэ. Холбоо нь Хойд Могойн гол – Тээлийн ОНТХГ-ын байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх үндсэн зорилготой. Энэхүү ОНТХГ-ын менежментийн загварын тухай дэлгэрэнгүй танилцуулгыг БХОУХ-ны менежментийн хүрээг ашиглан энэ бүлэгт тайлбарлах болно.

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ЭКОСИСТЕМИЙН ҮНЭТ ЗҮЙЛС


Зэрлэг амьтан

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ нь халиун буга, баданга хүдэр, шонхор, ёл зэрэг Монгол орны улаан номд бүртгэгдсэн ховор амьтдын үндсэн тархац нутагт хамаарах бөгөөд сүүлийн жилүүдэд тоо толгой нь цөөрч “Устаж болзошгүй” ангилалд бүртгэгдсэн байна. Хангайн нурууны томоохон тууртан амьтдын идээшил нутаг, өсөж үржих тааламжтай орчин болохын сацуу ховор амьтдын шилжилт, хөдөлгөөн бүхий гол коридор болдог. Энд ойролцоогоор 6 багт хамаарах 40 гаран зүйл хөхтөн, агнуурын холбогдолтой 60 гаруй зүйл шувуу (А.Болд нар, 1976), 4 баг 18 овог 27 төрөлд багтах 30 орчим зүйл шавж тархан амьдарна. Тус ОНТХГ-ын хойд хэсгээр урсах Урд Тамирын голын ус намгархаг газар нь нүүдлийн шувуудын дайран өнгөрөх, зусаж өндөглөх чухал ач холбогдолтой газар болдог.

Хангайн нуруу орчимд нийт 7 овог, 11 төрөл, 15 зүйл загас, 1 баг, 2 овог, 2 төрөл, 2 зүйлийн хоёр нутагтан, 2 салбар баг, 2 овог, 2 төрөл, 2 зүйлийн мөлхөгч, 14 баг, 28 овог, 89 төрөл, 159 зүйлийн шувууд, 7 баг, 15 овог, 28 төрөл, 32 зүйлийн хөхтөн амьтад тохиолдоно (С. Гомбобаатар нар, 2021).

Ойн болон уулын хээрийн экосистемд чухал үүрэг гүйцэтгэдэг хамгааллын үнэт зүйл бол олон зүйл амьтдын оршин амьдрах нөхцөлийг хангадаг нэн ховор Баданга хүдэр, Монгол тарвага, Идлэг шонхор, Талын бүргэд юм. Эдгээр нь ЛАСН-ийн зорилтот зүйлүүд бөгөөд тэдгээрийн статус, экосистемийн ач холбогдол, тулгамдаж буй аюул занал, ховордлын шалтгаан, экологи-эдийн засгийн үнэлгээний мэдээлэл болон ЛАСН-ээс 2019-2020 онд ИБХ нартай хамтран хийсэн биологийн мониторингийн үр дүнг доор тоймлон үзүүлээ.

Зураг-7. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын нөхөрлөлүүдийн байршил



МОНГОЛ ТАРВАГА



Баг: Мэрэгчид (*Rodentia*)
Овог: Хэрэм (*Sciuridae*)
Латин нэр: *Marmota sibirica*
Англи нэр: Siberian Marmot
Ховордлын зэрэг: ОУБХХ-ны Улаан дансны шалгуураар Олон улсад "Анхааралд өртөхөөргүй", Монгол Улсад "Устаж болзошгүй" зэрэглэлд багтана.

Экосистемийн ач холбогдол

Монгол тарвага чийгийн агууламж ихтэй 80 гаруй зүйл ургамлын боловсорч гүйцээгүй үр, шинэхэн навч, нахиа, цэцэг зэрэг түргэн боловсордог, шингэц сайтай хэсгийг сорчлон иддэг онцлогтой. Монгол тарвага идэвх хөдөлгөөний ид үедээ ч мал, зэрлэг амьтны бэлчээрийн өвс ургамлыг булаах, хороох сөрөг нөлөөгүй. Газрын өнгөн давхрааг сийрэгжүүлэн хольж хөрсний бүрдэл бүтцийг сайжруулж, ургамлан нөмрөгт эерэг нөлөө үзүүлдэг төдийгүй бүх мах идэшт хөхтөн амьтад, шувуудын идэш тэжээл болдог ач холбогдолтой. Тарваганы ялгадас, сэг зэм болон ноохойн тогооноос нүхний гадна зөөн гаргасан ургамлын үлдэгдэл нь хөрс бордоно, хөрсний өнгөн хэсгийг малтах, органик бодисоор хөрсийг баяжуулах замаар ургамлын ургацад эерэг нөлөөтэй.

Ховордлын шалтгаан

Олон жил дараалан бүлийн хэвийн үржил, нөхөн төлжилтийг тооцолгүй эрчимтэй агнасан, тархац нутгийн зарим хэсэгт газар хагалж тариалан эрхэлсэн, тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сийрэгжүүлэх агналт, устгал их хэмжээгээр хийсэн, дэлхэц нутгийн ихэнх хэсэгт ган болж, тарга тэвээрэг муу авч өвөлжихөд шаардлагатай энергийн нөөц өөхөн давхаргыг хуримтлуулж чадахгүй өвөлдөө ичээ нүхэнд үхэх зэргээр тоо толгой буурч, тархац нутаг тасархайтан хумигдсан.

Экологи-эдийн засгийн үнэлгээ

Монгол тарваганы эр нь 170,000 төгрөг, эм нь 200,000 төгрөг, үйлдвэрлэл, ахуйн, соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад эр, эм тарвага


34,000 төгрөгийн хураамж төлнө.

ЛАСН-ийн судалгаа


Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т анх суурь судалгааны эх хэрэглэхүүн цуглуулах үед тус нөхөрлөлийн нутаг дэвсгэр тарвагагүй болсон учир Цэцэрлэг сумын Хорголжингийн талаас Өндөр хөтөл нөхөрлөл 6-7 толгой, Тэх харайх 20, Арцат 2 бодгаль тарвагыг сэргээн нутагшуулж, тоо толгойн суурь мэдээлэлгүй байсан. 2019 онд 6 сорилын талбай сонгон авч 6 нөхөрлөлийн хариуцсан талбай буюу Тэх харайх нөхөрлөлийн Баруун хажуу, Хамар даваа, Жарантай нөхөрлөлийн Шар хөндийн шивнэх, Даваан жалга, Тэмээн чулуу нөхөрлөлийн Өндөр өвөр, Дулаан гуу, Арцат нөхөрлөлийн Бэлчир, Баянбулаг нөхөрлөлийн Цэргийн зураа, Могойхон нөхөрлөлийн нутагт тооллого судалгаа хийж нийт **251** толгой тарвага тэмдэглэсэн. Үүнээс бие гүйцсэн тарвага 56, хотил 71, мөндөл 82 байсан бол 42 бодгалийн насыг тодорхойлох боломжгүй байв. Тэх харайх нөхөрлөл тарваганы нягтшил хамгийн ихтэй 0.7 км2 талбайд нэг бүлд ноогдох тарваганы тоо 12.3 байсан бол Тэмээн чулуу нөхөрлөл хамгийн бага 0.4 км2 талбайд 2,7 тарвага ноогдох нягтшилтай байв.

2020 онд 8 нөхөрлөл болон Тусгал багийн 18 цэгт давтан тоолоход нийт **342** бодгаль 67 (20%) эр бодгаль, 41 (12%) эм бодгалийг ялган тодорхойлж 234 буюу 68%-ийн хүйсээр ялгах боломжгүй холоос тандан тоолов. Нийт популяцийн 70 бодгаль (20%) нь мөндөл, 36 (11%) залуу, 71 (21%) бие гүйцсэн, насыг тодорхойлох боломжгүй 165 (48%) байв. 2019 оноос 36% өссөн үзүүлэлттэй, мөндөл болон залуу бодгаль их байв.

Зураг-8. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын тарваганы цэгэн судалгааны байршил



Зураг-9. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын тарваганы тоо толгой (нөхөрлөлөөр)



БАДАНГА ХҮДЭР



Баг: Туруутан (*Artiodactyla*)

Овог: Буга (*Moschidae*)

Латин нэр: *Moschus moschiferus*

Англи нэр: Siberian Musk Deer

Ховордлын зэрэг: ОУБХХ-ны Улаан дансны шалгуураар Олон улсад “Эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй”, Монгол Улсад “Нэн ховор” зэрэглэлд багтана. CITES II хавсралтад бүртгэгдсэн

Экосистемийн ач холбогдол

Хүдрийн амьдрах уулархаг тайгат нутагт хэд хэдэн зүйлийн мэрэгчид, ургамлын үр жимс, ой модонд нөлөө бүхий олон зүйлийн шавж идэшлэдэг шувууд хөршлөн амьдрах ба эдгээртэй идэж тэжээл, байршил нутгаар өөр хоорондоо ямарч тохиолдолд өрсөлддөггүй байна. Хүдэр нь гадны аюул занал ирэх үед исгэрэх дуу чимээ гарган бусад амьтанд сэрэмжлүүлэг дохио өгдөг ойн цагдаа юм.

Ховордлын шалтгаан

Эрэгчин хүдрийн заарыг авах болон махыг нь ашиглахын тулд хараа хяналтгүй их хэмжээгээр агнаж байгаа (Clark et al., 2006), мөн амьдрах орчны хуваагдлын улмаас тоо толгой эрс (Цэнджав, Бүжинханд, 2000) ховордсон гэж үздэг. Байгальд чоно, шилүүс, нохой зээх, баавгайд бариулдаг. 1990-2001 онд хууль бусаар болон тусгай зориулалтаар 25000 толгой бие гүйцсэн гирээг агнасан (Homes, 2004) мэдээ байдаг. Мөн хүдрийн тархац нутаг, амьдрах орчны хуваагдал, тасархайтал нь түүний ховордлын бас нэг шалтгаан болдог (Цэнджав, Бүжин, 2000) гэжээ.

Экологи-эдийн засгийн үнэлгээ

Баданга хүдрийн эр нь 3,000,000 төгрөг, эм нь 3,500,000 төгрөг, зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихыг зөвшөөрөх ба 600,000 төгрөг, эм нь 700,000 төгрөгийн хураамжтай байдаг.

ЛАСН-ийн судалгаа

“Хойд Могойн гол-Тээл” ОНТХГ-т 2019 онд Арцатын даваа, Их нуур, Их тээл,

Хошготын рашаан, Бургастын ам, Ар байцаар явж хүдрийн ул мөрд үндэслэн байршлыг тогтоох, нөөцийн үнэлгээ хийх судалгааны талбай сонгох суурь судалгааг хийж гүйцэтгэсэн. 2020 онд дээрхи суурь судлагаа болон орон нутгийн иргэдийн мэдээлэлд тулгуурлан Хойд могойн гол-тээлийн Тэх харайх, Арцат, Бяцхан чулуут, Их ар, Тэмээн чулуу, Могойхон нөхөрлөл орчмын ойт нутагт баданга хүдэр тогтмол, харин Жарантай, Наранбулаг, Өндөр хөтөл, Буурал хангай, Жирх нөхөрлөлийн нутаг орчимд хүдрийн байршил тогтвортой биш, цөөн тоогоор, улирлын байдлаар үзэгддэг гэдгийг тогтоолоо. Хээрийн хайгуул судалгааны талбайг 2017 онд шинэчлэн тогтоосон байгаль хамгаалагчдын мониторинг судалгааны замналууд, мөн хамгаалалтын захиргааны санал дээр үндэслэн сонгосон. Судалгааны талбай нь 75-1000 км² байхад тохиромжтой (Мэдээлэл цуглуулах ба дүгнэх арга зүйн курс, 2003) гэж үздэг бөгөөд бид судалгаа хийгдэх талбайн гадаргын онцлог, хэмжээ, амьтны тархац зэргийг харгалзан үзэж “Хойд могойн гол-тээл” ОНТХГ-ыг 3 хэсэг талбайд ой бүхий бусад газар нутагт түгээмэл хэрэглэдэг хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, арга зүйн дагуу цэгэн, зурвас замлал, ул мөр болон аман асуулгын аргаар баданга хүдрийн судалгааны эх хэрэглэхүүнийг цуглуулсан.

“Хойд Могойн гол-Тээл” ОНТХГ-ын нөхөрлөлүүдийн ойт нутагт баданга хүдрийн тархац популяцийн үнэлгээний ажлын хүрээнд 155.23 км² нутагт 1000 га-д 1.62 бодгаль ноогдох нягтшилтайгаар баданга хүдэр тархан байрших боломжтойг тогтоосон.

ИДЛЭГ ШОНХОР



Баг: Шонхор (*Falconiformes*)

Овог: Шонхор (*Falconidae*)

Латин нэр: *Falco cherrug*

Англи нэр: Saker falcon

Ховордлын зэрэг: ОУБХХ-ны Улаан дансны шалгуураар Олон улсад “Устаж болзошгүй”, Монгол Улсад “Эмзэг” зэрэглэлд багтана. CITES-ийн конвенцийн II хавсралт, Зэрлэг амьтны нүүдлийн зүйлийн (CMS) тухай конвенцийн I, II хавсралтад тус тус бүртгэгджээ.

Экосистемийн ач холбогдол

Шонхор шувууд өвсөн тэжээлт мэрэгчид, жижиг шувууд, шавьж зэргээр хооллодог ба ингэснээрээ байгаль дээр тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг. Идлэг шонхор экосистемийн бодис, энергийн эргэлтийн пирамидын хувьд оройд нь байдаг тул экосистемийн чанарыг илэрхийлэгч байдаг. Идлэг шонхор нь зөвхөн шувуу, хөхтөн амьтдын халуун махаар хооллох ба бусдын барьсан олзыг булааж, сэг зэмээр хооллохгүй хүчирхэг шувуу юм. Манай орны идлэг шонхорын үржлийн хосуудын идэш тэжээлд үлийн цагаан оготно 75-80 хувийг эзэлдэг нь энэхүү мэрэгчдийн тоо толгойг зохицуулдгийг илтгэнэ.

Ховордлын шалтгаан

Хууль бус болон тусгай зөвшөөрлийн дагуу гадаадад худалдана. Өндөр хүчдэлийн шугамд цохиулах болон мөргөж эндэнэ. Арабын шонхор баригч хүмүүсийн суллан тавьж, улмаар хээр зөнд нь орхисон урхитай тагтааг барьж, улмаар урхинд орооцолдож эндэнэ. Хууль бусаар энэ зүйл шонхорыг агнаж чихмэл бэлтгэх, сарвуу, толгойг нь хэрэглэх зорилгоор дотоодод худалдана. Үлийн цагаан оготны эсрэг хэрэглэсэн хорд хорддог. Замын хажууд буй залуу шувууг өдрийн цагаар хурдтай өнгөрч буй машин дайрч тохиолдлын байдлаар хөнөөнө. Идлэг шонхор шувууны ханиадаар

өвчилдөг болох нь бүртгэгдсэн (Gombobaatar et al., 2011). Хууль бусаар худалдах болон тэжээх, сонирхох, шонхорчлох зорилгоор барьж гэмтээнэ, хөнөөнө. Гэрэл зураг хамт даруулах, видео бичлэг хийлгэж ашиг олох зорилгоор барина.

Экологи-эдийн засгийн үнэлгээ

Идлэг шонхорын экологи эдийн засгийн үнэлгээ нь 16,000,000 төгрөг, зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихыг зөвшөөрдөг ба 3,200,000 төгрөгийн хураамжтай байдаг.

ЛАСН-ийн судалгаа

“Хойд Могойн гол-Тээл” ОНТХГ-ын ойт хээр, уулархаг хээр, хад, хадан цохиотой голын хөндий, уулын энгэр, бусад амьдрах орчныг хамруулж идлэг шонхорын амьдрах орчны тохиромжтой хэмжээг (934.5 км²) үнэлж, популяцийн хэмжээг тооцоолов. Мөн үржлийн болон өвлийн улиралд шувууны мониторинг судалгааг гүйцэтгэсэн. Судалгааны ажлын хүрээнд 346 км² талбайд 2019 оны зун 14 бодгаль, 2020 оны зун 17 бодгаль бүртгэгдсэн ба 934.5 км² талбайд 2019 онд 37.8 бодгаль, 2020 онд 45.9 бодгаль байна гэж тооцоолсон. Идлэг шонхорын популяцийн хэмжээг хоёр жилийн үр дүнтэй харьцуулахад эхний жилээс дараагийн жил 21.4%-иар өссөн байна.

ТАЛЫН БҮРГЭД



Баг:	Харцага (<i>Accipitriformes</i>)
Овог:	Харцага (<i>Accipitridae</i>)
Латин нэр:	<i>Aquila nipalensis</i>
Англи нэр:	Steppe eagle
Ховордлын зэрэг:	ОУБХХ-ны Улаан дансны шалгуураар Олон улсад "Устаж байгаа", Монгол Улсад "Анхааралд өртөхөөргүй" зэрэглэлд багтана. CITES-ийн конвенцийн II хавсралт, Зэрлэг амьтны нүүдлийн зүйлийн (CMS) тухай конвенцийн I, II хавсралтад тус тус бүртгэгджээ.

Экосистемийн ач холбогдол

Тарважи бүргэд өвсөн тэжээлт мэрэгчид, жижиг шувууд, шавж зэргээр хооллодог ба ингэснээрээ байгаль дээр тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг. Мөн экосистемийн бодис, энергийн эргэлтийн пирамидын хувьд оройд нь байдаг тул экосистемийн чанарыг илэрхийлэгч болж, зэг зэмээр хооллон байгальд цэвэрлэгчийн үүрэг гүйцэтгэнэ.

Ховордлын шалтгаан

Чихмэл хийх, эсвэл хөл, хумс, толгой, өд зэргээр бэлэг дурсгалын эд зүйл хийх зорилгоор хууль бусаар буудаж хорооно. Гэрэл зураг, видео бичлэг хийх зориулалтаар зөвшөөрөлгүй барьж ашиглана. Хавар мал төллөх үеэр ишиг, хурга шүүрдэг гэж болгоомжилж буудан хөнөөдөг. Өндөр хүчдэлийн шугам мөргөж, цохиулж энддэг. Үлийн цагаан оготныг устгах зорилгоор цацсан бромадиолон зэрэг хортонд дам байдлаар хордоно. Идэш тэжээл бологч үлийн цагаан оготно, чичүүл зэрэг тал хээрийн мэрэгчид ховордох нь энэ зүйл бүргэдийн үржлийн амжилт буурах шалтгаануудын нэг болно.

Экологи-эдийн засгийн үнэлгээ

Тарважи бүргэдийн экологи — эдийн засгийн үнэлгээ 253,000 төгрөг, зөвхөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихыг зөвшөөрдөг ба 50,600 төгрөгийн хураамжтай байдаг.

ЛАСН-ийн судалгаа

Тарважи бүргэдийн амьдрах орчин идлэг шонхортой ихээхэн төсөөтэй. Тиймээс бид амьдрах орчны тохиромжтой хэмжээг ашиглан популяцийн хэмжээг мөн ижил аргаар тооцоолсон болно. Судалгааны ажлын хүрээнд 346 км² талбайд 2019 оны зун 21 бодгаль, 2020 оны зун 29 бодгаль бүртгэгдсэн ба 934.5 км² талбайд 2019 онд 56.7 бодгаль, 2020 онд 78.3 бодгаль байна гэж тооцоолсон. Түлхүүр зүйлийн популяцийн хэмжээг хоёр жилийн үр дүнтэй харьцуулахад эхний жилээс дараагийн жил 38.1%-иар өссөн үзүүлэлттэй байв.

БЭЛЧЭЭРИЙН ЭКОСИСТЕМ

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын бэлчээрт нийт 33 овог, 111 төрөл, 191 зүйлийн ургамал ургаж байгаа бөгөөд ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд шивэрсэн, оймын хүрээний ургамалгүй, шивлээн хүрээний 1, нүцгэн үртэний хүрээний 1, далд үртэний хүрээний 189 зүйл (үүнээс нэг талтан 37 зүйл, хос талтан 98 зүйл) ургамал байна. Эдгээрээс 25 зүйл нэг наст өвслөг ургамал (нийт зүйлийн 13.1%), 159 зүйл олон наст өвслөг ургамал (83.2%), 4 зүйл сөөг сөөгөнцөр ургамал (2.1%), 3 зүйл модлог ургамал (1.6%) ургаж байгаагийн дотор 167 зүйл бэлчээрийн (87.4%), 99 зүйл эмийн ашигт (51.8%), 42 зүйл хөл газрын ургамал (22.0%) байна (П.Ариунсүрэн, 2021).

ОНТХГ нь чийглэгдүү сэрүүн мужид хамаардаг бөгөөд нийт талбайн 62 хувьд өндөр уулын жижиг дэгнүүлт үетэн-бушилзат, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-бушилзат, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-агьт, үетэн-алаг өвст, ботууль-алаг өвст, ерхөг-хялгана-алаг өвс-агьт, ерхөг-хялгана-алаг өвс-агь-цагаан шарилжит, уул хоорондын хөндийн нугын бушилз-улалж-үетэн-алаг өвст, үетэн-улалж-алаг өвст, үетэн- алаг өвст, үетэн-агь-алаг өвст, улалж-үетэн-шарилж-хог ургамалтай бэлчээр, голын татмын нугын улалж-үетэн-алаг өвст, бургастай-улалж-үетэн, улалж-алаг өвст, улалж-үетэн-алаг өвст, үетэн-цахилдаг-алаг өвст гэсэн 5 ангийн 21 төрлийн бэлчээрийн ургамалжилтын хэв шинж байна (Зураг-10).

Хөрсний хувьд Аллювийн нугат намгийн ширэгт глейт хөрс, Аллювын ширэгт хөрс, нугат намгийн бүдүүн ялзмагт глейт хөрс, уулын нугат хээрийн хүрэн хөрс, уулын нугын бүдүүн ялзмагт глейрхэг хөрс, уулын


нугын бүдүүн язмагт бараан хөрс, уулын сул хөгжилтэй хөрс, уулын хүрэн шороон хөрс, хүрэн шороон хөрс гэсэн 9-н хэв шинжийн хөрс тархсан. Үүнээс уулын сул хөгжилтэй хөрс 36 хувийг, нугат намгийн бүдүүн ялзмагт глейт хөрс 21 хувийг эзэлж зонхилон тархсан байна.

Бэлчээрийн ургамлын химийн найрлага, шингэц, шимт чанарын хувьд уураг, эслэг, шингэц, шимт чанарын үзүүлэлт сайтай, ялангуяа, уулын хээр болон өндөр уул, уулс хоорондын бэлчээр нь уургийн агууламж өндөртэй, шингэц, шимт чанараараа сайн байна. (П.Ариунсүрэн, 2021)

ОЙН ЭКОСИСТЕМ

ОНТХГ-ын ой нь Хангайн ой-ургамалжилтын мужийн зүүн өмнөд Хангайн хошуунд хамаарагдана. Монгол орны төвийн хэсэгт байрших өндөр уулс, тайга, ойт хээр, уулын хээр, хээр зэрэг байгалийн олон бүс бүслүүр бүхий баруун хойноос зүүн урагш чиглэж тогтсон ойролцоогоор 750 км үргэлжилсэн өргөн уудам нутаг бол өндөр уулын, ойт хээрийн экосистемийн гол төлөөлөл юм. ОНТХГ-н нийт талбайн 38 хувь нь ойгоор бүрхэгдсэн бөгөөд ойн сангийн 96 хувийг улалж үетэн алаг өвст хэв шинжийн шинэсэн ой, үлдсэн 4 хувийг холимог ой эзэлж байна. Эндэхийн ой нь уур амьсгалыг зөөлрүүлэх, ус чийгийн горимыг зохицуулах, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, элсний нүүлт хөдөлгөөнийг тогтоон барих, хүн амьтан, ургамал бичил биетний амьдрах тааламжтай орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг хамгаалах, биологийн олон янз байдлыг хангах, Тамирын голын урсац бүрэлдэх эх болдгоороо экологийн өндөр ач холбогдолтой.

Зураг-10. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын ургамалжлын зураг



ОНТХГ-ЫН ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЛАСН Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын экосистем, биологийн төрөл зүйлийн хэд хэдэн суурь судалгааг гүйцэтгэсэн. Үүнд жил бүрийн зэрлэг амьтны мониторинг, бэлчээрийн судалгаа, ойн хэсэгчилсэн судалгааг Монгол Улсын их сургууль (МУИС), Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС), ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэнгийн судлаачидтай хамтран хийсэн. Эдгээр судалгааг хийхдээ Нөхөрлөлийн ИБХ-ыг байнга оролцуулж сургалт, дадлагын хэлбэрээр хийж байсан бөгөөд нөхөрлөл бүр дээр нийт гишүүдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулсан.


Эдгээр судалгааны үр дүнг ашиглан нөхөрлөлийн болон Холбооны байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө гаргаж ажилласан. Тус төлөвлөгөөнд тусгасны дагуу ИБХ бүр ОНТХГ-ын хилийн цэс дотор хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчны эргүүл хяналтын SMART аргачлалаар эргүүл хяналтыг сард хоёр удаа хийж хэвшсэн. Холбооны 17 ИБХ нар шугаман болон цэгэн

тооллогын арга зүйн сургалт авч, хээрийн судалгааны багаж тоног төхөөрөмж ашиглаж сурсан. 2019-2020 онд нийт 85 удаагийн SMART эргүүл хяналт хийж хулгайн мод бэлтгэл, хулгайн ан, байгаль орчны бусад хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хууль сахиулах байгууллагад мэдээлэх ажлыг хийсэн.

Эргүүл хяналтаас гадна ОНТХГ-ын малчдын дунд байгаль орчны сургалт тогтмол явуулж, тэдний мэдлэг мэдээллийг сайжруулан байгаль хамгааллын ажилд татан оролцуулах замаар тэдний хандлага, үйлдлийг өөрчлөх ажлыг эрчимтэй хийсэн.

Эдгээр ажлын үр дүнг 2021 оны эхээр Хараат бус судалгааны хүрээлэн (ХБСХ *англ.* IRIM)-судалсан бөгөөд үүнд оролцсон 150 малчны 91 хувь нь сүүлийн 3 жилд зэрлэг амьтны тоо толгой ихэссэн буюу хэвэндээ байгаа гэжээ. Мөн хугацаанд хууль бус агнуур буурсан гэж тэдний 59 хувь, хууль бус мод бэлтгэлийн талаар сонсоогүй гэж 80 хувь нь хэлсэн байна.

Зураг-11. ОНТХГ-ын малчдын сүүлийн 3 жилд хийсэн нөхөн сэргээлтийн ажил



ЛАСН-ийн дэмжлэгээр болон өөрсдийн нөөцийг дайчлан малчид бэлчээр, ой, усны нөөцийг нөхөн сэргээх, зэрлэг амьтныг хамгаалах төрөл бүрийн ажил хийжээ (Зураг-11).

НУТГИЙН ИРГЭДИЙН АМЬЖИРГАА САЙН САЙХНЫГ ДЭМЖИХ

Хүний амьдралын чанар байгалийн өгөөж хишиг буянаас шууд хамааралтайг бидний өвөг дээдэс эрт дээр үеэс гүнзгий ойлгож, байгалиа хайрлаж гамнасан ёс заншил, дэг жаягтай байсныг эхний бүлэгт өгүүлсэн билээ. Тэгвэл 21 дүгээр зууны эхэнд дэлхийн эрдэмтэд хүний амьдралын сайн сайхан нь байгаль, экосистемийн үйлчилгээнээс ямар хамааралтайг нарийвчлан тодорхойлсон байдаг (МЕА, 2005). Сайхан аз жаргалтай амьдрал гэдэг бол аюулгүй байдал,

амьдралаа тэтгэх материаллаг үндэс, эрүүл мэнд, нийгмийн харилцаа гэсэн дөрвөн үндсэн зүйлээс хамаарч өөрийн үнэт зүйлсийн төлөө амьдарч, хүсэл мөрөөдлөө биелүүлэх сонголтоо хийх эрх чөлөөтэй байхыг хэлдэг ажээ (Зураг-12). Хүний аз жаргалтай амьдралыг бүтээхэд байгалиас дэмжих үйлчилгээ үзүүлж шаардлагатай нөөцөөр хангах, амьдрах орчныг зохицуулах болон зан заншил соёлоороо өөрийгөө тодорхойлох боломж бүрдүүлж тэтгэж байдаг.


Зураг-12. Экосистемийн үйлчилгээ хүний сайн сайхан амьдралд нөлөөлөх нь



Иймд Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын экосистемийг, түүний ховор зүйлүүдийг хамгаалах зорилго нь нутгийн малчин өрхийн амьжиргааг дэмжих зорилготой салшгүй уялдаатай юм. ЛАСН-ийн малчдын амьдрал амьжиргаанд дэм болох ажлууд нь тэднийг шинэ зүйл сурч мэдэх, мэдээлэл авах, өрхийн бизнес эрхлэх, түүндээ шаардлагатай санхүүгийн үйлчилгээ авах боломжоор хангахад чиглэсэн. Үүний үр дүнд 2018 оны суурь үзүүлэлттэй харьцуулахад олон хэмжээст ядуурлын индикатор (ОХЯИ) 0,115-аас 0,084 болон буурч, эрч нь 0,39-өөс

0,37 болж багассан төдийгүй эмзэг ядмаг хүмүүсийн эзлэх хувь 30%-аас 23% болжээ (ХБСХ, 2021). Мөн судалгаанд оролцсон малчдын 68 хувь нь хоёр ба түүнээс дээш орлогын эх үүсвэртэй болж, өрхийн дундаж орлого 74 хувь нэмэгджээ. Ингэснээр олсон орлогын хүрэлцээ сайжирсан байна. Тухайлбал, суурь онтой харьцуулбал, орлого нь өдөр тутмын хэрэгцээнд хүрэлцдэг, түүн дээр нэмээд хувцас хэрэглэл (58%), зарим үнэтэй зүйлс авч чаддаг (1%), тэр ч байтугай хуримтлал үүсгэдэг (11%) гэж хэлсэн малчдын хувь 57%-аас 71% болж өсжээ (Зураг-13).

Зураг-13. Нөхөрлөлийн гишүүн өрхийн орлогын хүрэлцээний үнэлгээ



Амьжиргаа дэмжих үйл ажиллагааны талаар болон тэдгээрээс гарсан үр дүнг Хараат бус судалгааны хүрээлэнгийн хөндлөнгийн үнэлгээний мэдээлсэн байдлаар хүргэж байна.

МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ

Нөхөрлөлийн гишүүд биологийн олон янз байдлын судалгаа, ойн судалгаа, бэлчээрийн судалгаа, жижиг бизнесийн боломжийн судалгаа зэргийг эрдэмтэдтэй хамт хийлцэж, судалгааны хялбарчилсан арга зүйд суралцахаас гадна хамгааллын, нөхөн сэргээлтийн, жижиг бизнес, аялал жуулчлалын хөтөч хийх, гэр буудал ажиллуулах зэрэг чухал ур чадварыг мэргэжлийн багш нараар заалгасан байна. Өнгөрсөн гурван жилд нийт 200 гаруй удаагийн сургалт, уулзалт, үйл ажиллагаанд давхардсан тоогоор

6,400 хүн оролцсон байна. Ялангуяа, нөхөрлөлийн энгийн гишүүдийг бодвол ИБХ нар экосистемийн болон биологийн олон янз байдлын мониторинг хийх сургалтад олон удаа давтан оролцож жил бүр судалгааны ажилд тогтмол оролцож байлаа (Зураг-14).


Энэ бүх хүчин чармайлтын үр дүнд малчдын хандлагад эерэг өөрчлөлт гарч өмнө нь мод бэлтгэл ан агнуурт өөрсдөө оролцдог байсан бол одоо нутаг усаа хайрлан өөрт буй нөөц бололцоог дайчлан хамгаалах, сэргээх бодолтой болсон байна (Зураг-15).

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ


Олон улсын CARE байгууллагын “Дундын хуримтлалын бүлэг” бичил санхүүгийн аргачлалыг ЛАСН өөрийн хөтөлбөр бүхий орнуудад хэрэгжүүлдэг бөгөөд Монголд Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т мөн нэвтрүүлсэн. Аргачлал нь арилжааны банкнуудаас санхүүгийн үйлчилгээ авах боломжгүй, тэдний шаардлагыг хангахгүй байгаа, голдуу алс хязгаар нутагт суудаг хүмүүсийн санхүүгийн үйлчилгээнд хамрагдах

арга зам юм. Нөхөрлөлийн гишүүд дундын сан байгуулж түүнд сар бүр хуримтлал үүсгэн хадгаламжтай болох, хамтын шийдвэрээр түүнийгээ үр ашигтай зарцуулж, гишүүддээ барьцаагүй бага хүүтэй зээл олгодог. Мөн нийгмийн сан үүсгэж түүгээрээ олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулахаас гадна санхүүгийн мэдлэгээ дээшлүүлэх, санхүүгийн сахилга батад суралцах зэрэг олон ач холбогдолтой байдаг.

Зураг-14. Малчид байгаль хамгааллын сургалтад хамрагдсан байдлын үнэлгээ




Зураг-15. Байгаль хамгааллын ажлын ач холбогдлыг малчид үнэлсэн байдал (ХБСХ)



Нөхөрлөлийн холбооны 9 нөхөрлөл Дундын хуримтлалын бүлэг үүсгэн хуримтлалын сантай болсон бөгөөд нийт 272 гишүүдээс 224 гишүүн буюу 82,3% нь хамрагдсан байна. Сүүлийн хоёр жилд хуримтлалын нийт санд 80 орчим сая төгрөг цугласан бөгөөд гишүүн өрхүүд хуримтлалтай болж эхэлсэн байна. Судалгаанд орсон малчдын 91 хувь барьцаагүй бага хүүтэй

зээлийг авч чадах болсон, 88 хувь нь амьжиргаанд нэмэртэй байсан, 53 хувь энэ эх үүсвэрээс орлого олсон гэж, 82 хувь нь санхүүгийн мэдлэгтэй, сахилга баттай болсон, 89 хувь ийм үйл ажиллагааны үр дүнд гишүүдийн хамтын ажиллагаа сайжирсан хэмээн хуримтлалын сангийн ач холбогдлыг үнэлжээ (Зураг-16).


Зураг-16. Хуримтлалын сантай болсны ач холбогдлыг малчид үнэлсэн нь



АМЬЖИРГАА БИЗНЕС

Бизнесийн зөвлөх бүх нөхөрлөлд очиж оролцооны аргаар хэлэлцүүлэг хийн тухайн нөхөрлөлийн байршил, газарзүйн онцлог, гишүүдийн ур чадвар зэрэг хүчин зүйлээс хамааран ямар бизнес хийх боломжтойг СВОТ дүн шинжилгээ хийж тогтоосон.

Зураг-17. ОНТХГ-ын малчин өрхийн сарын орлогод гарсан өөрчлөлт (орлогын бүлгээр)




Үүнд үндэслэн бизнесийн төлөвлөгөө гаргаж тухайн бизнес хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн төрөл, үнэ зэргийг тодорхойлж худалдан авсан. Эдгээрт цагаан идээ боловсруулах, блок цохих, модны үрсэлгээ, нарийн ногоо тариалах, аялал жуулчлал эрхлэх, тэжээлийн ургамал тарих зэрэг бизнес багтаж байна. ЛАСН-ээс нэг нөхөрлөлд дунджаар 6 сая төгрөг, нийтдээ 59,4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтаар дэмжсэний үр дүнд

2020 оны 10 дугаар сарын байдлаар тэд 396 сая төгрөгийн борлуулалт хийж чадсан.

Нөхөрлөлийн бизнест дэмжлэг үзүүлж Улаанбаатар болон Архангай аймгийн төвд болсон үзэсгэлэн худалдаанд малчдыг оролцуулах, холбогдох сургалтаар хангах, видео шторк, брошюр, онлайн сурталчилгааны материал бэлдэж сурталчлах, цагаан идээ хүнсний супер маркетэд нийлүүлэх гэрээ хийхэд зуучлах, ойн цэвэрлэгээний тээврийг санхүүжүүлсэн байна.

Зураг-18. ОНТХГ-ын малчин өрхийн сарын орлогод гарсан өөрчлөлт (төгрөгөөр)



ЛАСН-ийн дэмжлэгийн үр дүнд суурь үзүүлэлттэй харьцуулахад гишүүн өрхийн дунд сарын 500,000 төгрөгөөс дээш орлоготой айлуудын хувь нэмэгджээ (Зураг-17). Мөн судалгаанд орсон малчдын өрхийн дундаж болон медиан орлого суурь үзүүлэлтээс нэмэгджээ (Зураг-18).

Дээр дурдсан байгаль хамгааллын болоод малчдын амьжиргааг дэмжихэд гарсан ахиц дэвшилд ОНТХГ-ын засаглалын зохион байгуулалт, үйл явц гол үүрэгтэй байсан юм.

ХОЙД МОГОЙН ГОЛ – ТЭЭЛИЙН ОНТХГ-ЫН ЗАСАГЛАЛ БА ОРОЛЦОГЧ ТАЛУУД

БХОУХ-оос гаргасан ТХГН-ийн засаглалын хэлбэрийн тодорхойлолтын дагуу харахад Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ нь **хамтын засаглалын** хэлбэртэй бөгөөд ийнхүү тодорхойлсныг доор сийрүүлэн тайлбарлана.

Өмнөх бүлгийн ОНТХГ-ын эрх зүйн орчны хэсэгт тайлбарласанчлан Үндсэн хуулийн 6.2, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 1.3, 29 дүгээр зүйлийн 1.2, мөн “Газрын тухай” хуулийн 10 дугаар зүйл, “ТХГН-ийн үндэсний хөтөлбөр”, “Ойн тухай” хуулийн 4.4.2, Байгаль орчны сайдын 2000 оны “Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай” журмын дагуу Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-н менежментийн үндсэн эрх мэдэл Архангай аймгийн Булган

сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал (ИТХ) ба Засаг даргад байна.

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 32-р зүйлийн 2-т “*Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно*” гэсэн болон “Ойн тухайн” хуулийн 4.4.2-т “*сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн сангийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаа, нөхцөл, болзолтойгоор*

гэрээний дагуу ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад" өгч болно гэсэн заалтын дагуу 2018 онд байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдтэй Булган сумын Засаг дарга Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын **менежментийн гэрээ** байгуулж байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрх, үүрэг хариуцлагыг хүлээлгэсэн. Улмаар 2018 онд Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын 2018-2023 оны **менежментийн төлөвлөгөөг** баталсан. Нөхөрлөлийн холбоо болон нөхөрлөлүүд гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ОНТХГ-ын төлөвлөгөөг хэрэгжүүлж гүйцэтгэлийг багийн болон сумын удирдлагад тайлагнадаг.

ОНТХГ-ын засаглалд **оролцогч талууд** нь аймгийн ИТХ, Байгаль орчин аялал жуулчлалын газар (БОАЖГ), Булган сумын ИТХ, Засаг дарга, сум дундын Ойн анги, Цагдаагийн газар, Экологийн цагдаа гэсэн төрийн байгууллагууд, харин төрийн бус оролцогч талууд нь ОНТХГ-ын 10 нөхөрлөл, тэдгээрийг нэгтгэсэн Булган сумын Нөхөрлөлийн холбоо, аймгийн Бэлчээр ашиглагчдын холбоо, ЛАСН болно. Эдгээрээс сумын ИТХ, Засаг дарга, нутгийн иргэдийн нөхөрлөл, нөхөрлөлийн холбоо нь засаглалын үйл явцад давуу эрхтэй тал (Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 48-р зүйл) бол бусад байгууллагууд нь оролцогч тал юм. Эдгээр талуудын ОНТХГ-ын менежментийн эрх үүрэг хариуцлага дараах байдлаар хуваарилагдсан болно.

Аймгийн БОАЖГ нь байгаль орчныг хамгаалах, тусгай хамгаалалттай газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, энэ чиглэлийн төрийн бодлого хөтөлбөрийг аймагтаа хэрэгжүүлэх, ОНТХГ-ын менежментийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үүрэг хариуцлагын хүрээнд нөхөрлөлүүд болон ЛАСН-тэй нягт хамтран ажиллаж менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлагын, хүний нөөцийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилладаг.

Булган сумын ИТХ нь Хойд Могойн гол-Тээл орчмын нутгийг ОНТХГ-т авах шийдвэр гаргаж нөхөрлөлд таван жилийн хугацаагаар гэрээгээр эзэмшүүлсэн. ОНХГ-н

менежментийг хэрэгжүүлэх төсвийг дараа жилийн орон нутгийн төсөвт суулган баталж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй хэдий ч хэрэгжилт сул байгаа. Жишээлбэл: байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18-р зүйлийн 1 дэх хэсэгт *"байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг түүний дотор ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 85% байх"*-аар тогтоосон байдаг. Нөгөө талаас 2020 онд Булган сум ойн нөөц ашигласны төлбөрийн орлого гэхэд зөвхөн самрын нөөц ашигласны төлбөрөөс 336 сая төгрөг олсон боловч 15 хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг сайжруулах, ИБХ-ыг урамшуулах арга хэмжээнд зарцуулахаар баталсан.

Булган сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сумандаа хангуулах, нөхөрлөлүүдтэй гэрээ хийх, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, ОНХГ-н менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах, хэрэгжилтийг хангуулах үүргийн дагуу Булган сумын ИТХ-ийн шийдвэрийг үндэслэн ойн нөхөрлөлүүдтэй ОНТХГ-ын менежментийн гэрээ байгуулан ажилласан. Сумын байгаль хамгаалагч, бэлчээрийн мэргэжилтэн, газрын даамал нь нөхөрлөлүүдийн чадавхжуулах сургалтад оролцож, зөвлөмж өгч ажилладаг.

Сум дундын Ойн анги нь ойн менежмент хийхэд чадавхжуулах, ойн цэвэрлэгээний ажлын талбай тусгаарлалт хийх, хүлээж авах, нөхөрлөлд мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгөх үүргийн дагуу жил бүр ОНТХГ-ын нөхөрлөлүүдэд ойн хортон шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх сургалт хийж, ойн цэвэрлэгээний ажилд болон ойн менежментийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгч нягт хамтран ажилладаг.


Аймгийн Цагдаагийн газар нь Хотонт, Эрдэнэмандал, Тариат сумдад сум дундын 133 ажилтан бүхий 3 тасагтай бөгөөд Булган суманд 2 цагдаа ажилладаг. 2020 онд тус

сумын Цагдаагийн тасагт экологийн нэг цагдаа томилогдон очсон. Иргэдэд хууль эрх зүйн мэдээлэл олгох, байгаль орчны эсрэг зөрчлийн мэдээллийг иргэдийн мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх зэрэг үүргийн хүрээнд ОНТХГ-ын ИБХ-дад хууль эрх зүйн мэдлэг олгох 3 удаагийн сургалт хийж хамтран ажилласан.

ЛАСН нь Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ийн менежментийг сайжруулах замаар ойт хээрийн экосистем түүний ховордсон зүйлийг хамгаалах төсөл боловсруулж ИБУИНВУ-ын

Засгийн газрын санхүүжилт татаж, төслийг бусад талуудтай хамтран хэрэгжүүлсэн. ЛАСН нь донорын өмнө хүлээсэн хариуцлагын дагуу төслийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах, донорт тайлагнах ажлыг гүйцэтгэсэн. ЛАСН нь ОНТХГ-ын талуудыг үндэсний болон олон улсын мэргэжилтэн эрдэмтэдтэй холбож шинжлэх ухаан судалгаанд үндэслэсэн хамгааллын үйл ажиллагаа явуулахад гол үүрэг гүйцэтгэж засаглалын бүхий л зарчмыг хэрэгжүүлэхийг эрмэлзэн ажилласан.

Зураг-19. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын засаглалд оролцогч талууд, хамтын ажиллагаа



Энэ бүгдээс үзвэл Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т менежментийн эрх мэдэл, хариуцлага нь Архангай аймгийн болон Булган сумын төрийн байгууллагууд, нөхөрлөлүүд, тэдгээрийн холбоо, ЛАСН зэрэг төрийн бус байгууллагын дунд хуваагдаж тэдгээрийн төлөөлөл бүхий бүтэц тогтолцоогоор олон ургалч байдлаар шийдвэр гаргаж ажилладаг (Зураг-19). Талуудын хамтын шийдвэр нь ОНТХГ-ын

менежментийн төлөвлөгөө, нөхөрлөлийн төлөвлөгөө зэрэг арга хэрэгслээр албажиж баталгааждаг, төлөвлөлт ба хэрэгжилтийг нөхөрлөлийн болон бүх гишүүдийн хурлаар хэлэлцдэг. Иймээс ОНТХГ-ын засаглалын хэлбэрийг хамтын засаглал хэмээн тодорхойлсон болно. Хамтын засаглалыг хэрэгжүүлэхэд менежментийн төрөл бүрийн арга хэрэгсэл ашигласан бөгөөд энэ талаарх мэдээллийг дараагийн хэсэгт тусгасан болно.

ХОЙД МОГОЙН ГОЛ – ТЭЭЛИЙН ОНТХГ-ЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭРЭГСЭЛ

Номын нэгдүгээр бүлэгт ТХГН-ийн менежментэд олон түвшний зүйл бүрийн арга хэрэгсэл ашиглаж баймааж үр дүнд хүрч хамгааллын зорилго биелдэг тухай дурдсан. Тэгвэл Хойд Могойн гол-Тээлийн


ОНТХГ-ын менежмент хийж буй институцийн бүтэц, үндсэн дүрэм, янз бүрийн төлөвлөгөө, хурлууд, эрдэмтэд экспертүүдийн зөвлөгөө авах зэрэг хэлбэрээр олон арга хэрэгсэл ашигласан нь дараах болно.

Булган сумын нөхөрлөлүүдийн холбоо

ОНТХГ-т ландшафтын түвшний менежмент хийж төрийн бус талуудын оролцоог зангидаж буй институц нь Булган сумын нөхөрлөлүүдийн холбоо юм. Холбоо нь 10 нөхөрлөл, орон тооны Гүйцэтгэх захиралтай,

Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн тэргүүн, болон хяналтын зөвлөлтэй, дээд удирдлага нь холбооны бүх гишүүдийн хурал гэсэн бүтэцтэй Зураг-20.

Зураг-20. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын Нөхөрлөлийн холбооны бүтэц

**Булган сумын Нөхөрлөлийн холбооны**

Бүх гишүүдийн хурал: Нөхөрлөлийн холбооны удирдах дээд байгууллага нь холбооны бүх гишүүдийн хурал юм. Хурал жилд нэг удаа хуралддаг ч гишүүдээс ирсэн санал болон Удирдах зөвлөл (УЗ), Хяналтын зөвлөл (ХЗ)-ийн санаачилгаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Бүх гишүүдийн хурал нь дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, холбооны урт хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах, хүлээн авах, УЗ-ийн гишүүдийг сонгох, сонгогдсоныг баталгаажуулах, үүрэгт ажлаас чөлөөлөх, УЗ-ын дарга буюу холбооны тэргүүнийг чөлөөлөх, дараагийн сонгогдсон тэргүүний бүрэн эрхийг батлах, Нөхөрлөлийн холбоог татан буулгах асуудлыг шийдвэрлэх эрх үүрэгтэй. Шийдвэр нь олонхын саналаар батлагдаж хурлын тэмдэглэлд орно. Хурлын тэмдэглэлийг нөхөрлөл бүрээс сонгосон

УЗ-ийн гишүүн уншиж, гарын үсгээ зурж баталгаажуулна. Хурлын шийдвэрийг бүгд дагаж мөрдөнө. Хуралд Гүйцэтгэх захирал үйл ажиллагааны тайланг бүх гишүүдэд танилцуулж, хэлэлцүүлэх, Нөхөрлөлийн холбооны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталдаг. Бүх гишүүдийн анхны хурлыг 2019 оны гурав дугаар сарын 26-нд хийж энэхүү бүтцийг баталсан.

Нөхөрлөлийн холбооны Удирдах зөвлөл: Нөхөрлөлийн холбооны УЗ нь дарга ба нөхөрлөл бүрийг төлөөлсөн 10 гишүүнтэй. УЗ-ын даргыг Бүх гишүүдийн анхны хурлаар олонхын саналаар сонгосон. УЗ нь нөхөрлөлийн холбооны үйл ажиллагааг чиглүүлэх, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бүх гишүүдийн хурлаас баталсныг албажуулж батлах, гишүүн нөхөрлөлүүдээс дэвшүүлсэн холбооны түвшний асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх үүрэгтэй. Удирдах зөвлөлийн хурлыг улирал

бүр хийж, нарийн тэмдэглэл хөтлөх бөгөөд гишүүд уншиж танилцаад гарын үсгээ зурж баталгаажуулна. УЗ-ын даргын боломж болон цар тахлын асуудлаас УЗ-ын хурлыг тогтмол хийж хараахан чадаагүй ч чухал шийдвэрүүд гаргах шаардлагатай үед цаг алдалгүй ажиллаж чадсан.

Нөхөрлөлийн холбооны Хяналтын

зөвлөл: Нөхөрлөлийн холбооны ХЗ нь Бүх гишүүдийн хурал (БГХ)-аас нууц санал хураалтаар сонгогдсон 7 гишүүнтэй. ХЗ-ийн дотоод хурлаас ХЗ-ийн даргаа сонгоно. ХЗ нь холбооны үйл ажиллагаа холбооны дүрэм болон БГХ-аас шийдвэргаргасны дагуу явагдаж буй эсэхэд гишүүдийн өмнөөс хяналт тавина. Мөн УЗ, УЗ-ын дарга, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа, шийдвэр нь гишүүдийн эрх ашигт нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах, дотоод бичиг хэргийн хөтлөлт, хөрөнгийн бүртгэл, зарцуулалт, ашиглалт, санхүүгийн байдлыг шалгах, шалгасан ажлын дүн болон зөрчлийн талаар баримтжуулж бүх гишүүдийн хуралд танилцуулах, шийдвэрлүүлэх эрх мэдэл, үүрэгтэй. ХЗ нь хуралдаж, хурлын тэмдэглэл хөтөлж гарын үсэг зуран гаргасан шийдвэрээ баталгаажуулах учиртай. Холбооны ХЗ нь эмэгтэй гишүүдээс бүрдсэн, өнгөрсөн хугацаанд төдийлөн идэвхтэй ажиллаж чадаагүй, цаашид чадавхжуулах шаардлага байгаа.

Гүйцэтгэх захирал: Нөхөрлөлийн холбооны Гүйцэтгэх захирлыг ЛАСН-ээс зарласан нээлттэй сонгон шалгаруулалтаар өрсөлдүүлж сонгосон бөгөөд бүх гишүүдийн хурлаар баталгаажуулсан. Цаашид УЗ-өөс Гүйцэтгэх захирлын ажилд үнэлэлт дүгнэлт өгч, гэрээг сунгах, шинээр авах бол ийм өрсөлдөөнтэй байдлаар шалгаруулах нь Холбооны гишүүдийн эрх ашигт илүү нийцнэ. Шалгаруулалтад УЗ-ын гишүүд оролцож, нээлттэй санал хураалтаар Гүйцэтгэх захирлыг сонгож УЗ-ын дарга томилгоог албажуулна. Гүйцэтгэх захирал БГХ, УЗ-өөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг орон тооны албан тушаал юм. Нөхөрлөлийн холбоог чадавхжуулах зорилгын хүрээнд ЛАСН-ээс уг ажлын байрыг санхүүжүүлсэн бөгөөд цаашид Булган сумын ЗДТГ, Нөхөрлөлийн холбоо уг албан тушаалыг санхүүжүүлэх юм.

Нөхөрлөлийн холбооны гишүүн

нөхөрлөл: ОНТХГ-т амьдарч буй малчид 10 нөхөрлөл болж Холбоонд нэгдсэн нь тэнд амьдардаг нийт малчин өрхийн 80 хувийг эзэлж байна. ОНТХГ-ын нийт талбай ч эдгээр 10 нөхөрлөлийн нутаг бөгөөд хариуцсан нутгийн байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх үүрэг хүлээдэг. Нөхөрлөл бүр 1-2 ИБХ-тай, тэд нөхөрлөлийн хариуцсан нутаг дэвсгэрт тогтмол эргүүл хийж, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхээс гадна биологийн олон янз байдлын, бэлчээрийн, ойн үнэлгээ мониторингийн ажилд оролцдог гол хүмүүс юм. Нөхөрлөл бүрийн танилцуулгыг хойно оруулсан болно.

ОНТХГ-н менежментийн төлөвлөгөө

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг 2018 онд Архангай аймгийн ЗДТГ, аймгийн БОАЖГ, Булган сумын ИТХ, Хангайн нурууны УТХГ-ын Хамгаалалтын захиргаа, мэргэжлийн зөвлөх болон нутгийн иргэдийн санаачилгаар байгуулсан “Могойхон” ойн нөхөрлөл, “Монгол хийморь” ТББ-ын төлөөлөл оролцсон хэлэлцүүлгийн дүнд боловсруулжээ. Менежментийн төлөвлөгөөнд Хойд Могойн гол-Тээл орчмыг хамгаалалтад авах үндэслэл, нутгийн иргэдийн санал санаачилга, байгалийн нөхцөл, биологийн олон янз байдал, нийгэм эдийн засгийн байдал, хамгаалах зүйлсийн нөхцөл байдлын суурь мэдээлэл орсон. Тус төлөвлөгөө нь ОНТХГ-ын эрхэм зорилго, хамгааллын стратеги, хүрэх зорилтууд, үйл ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, хэрэгжүүлэх арга зам, хяналт мониторингийн хэлбэрийг тодорхойлсон баримт бичиг юм.

Булган сумын нөхөрлөлүүдийн холбооны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөний зорилго зорилтуудад нийцүүлэн боловсруулсан. Гишүүн нөхөрлөл тус бүрийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж олонхын саналаар баталсан төлөвлөгөөг нэгтгэн гаргадаг. Төлөвлөгөөнд нөхөрлөлүүдийн гэрээгээр хариуцсан нутаг дэвсгэрт байгаль хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ерөнхий зорилгын хүрээнд байгаль орчинд тулгамдаад байгаа

асуудлуудыг шийдвэрлэх, SMART байгаль орчны эргүүл мониторинг тогтмол хийж хууль бус агнуур, модны хулгайг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нутгийн иргэдийн эв

санаа, хамтаараа хөгжих, бэлчээрийн болон ойн менежментийг оновчтой хэрэгжүүлэн гишүүдийнхээ амьжиргааг нэмэгдүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг тусган баталдаг.

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАМТЫН МЕНЕЖМЕНТИЙН НӨХӨРЛӨЛ

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын менежментийн гол субъект нь байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл гэдгийг дээр нэгэнт дурдсан. Энэ хэсэгт нөхөрлөл бүрийг танилцуулахаас гадна нөхөрлөлийн дотоод засаглалын асуудлыг тодорхойлж тус институцийн дотоод ардчилал, ил тод байдал, шударга ёс, хүний эрхийг хүндэтгэх зэрэг үндсэн зарчмууд ямар

арга хэрэгслээр хэрэгждэгийг үзүүлэхийг зорилоо.

Нөхөрлөл бүр байгаль хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах зорилгоо тодорхойлсон нөхөрлөлийн дүрэмтэй, зорилгодоо хүрэхэд гишүүдийг зохион байгуулж хариуцлагажуулах институцийн бүтэцтэй (Зураг-21), менежментийн төлөвлөгөөтэй байдаг.

Зураг-21. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын БНХМ-ийн нөхөрлөлийн бүтэц



Нөхөрлөлийн дүрэм: Байгаль орчин хамгаалах хуулийн 50-р зүйлийн 10-т заасны дагуу нөхөрлөлийн дүрмээ боловсруулсан. Нөхөрлөлийн гишүүд бүх гишүүдийн хурлаараа дүрмийг хэлэлцэн баталдаг, нөхөрлөлийн хувьд үндсэн хууль юм. Дүрэм нь нөхөрлөлийн үйл ажиллагаа, холбогдох харилцааг зохицуулах зорилготой. Дүрмээр нөхөрлөлийн зорилго, үйл ажиллагааны чиглэл, гишүүнчлэл, удирдлагын бүтэц, үүрэг, хяналтын тогтолцоо, хөрөнгө санхүү гэсэн 12 бүлэг 64 зүйлтэй. Дүрмийг батлах өөрчлөх хурлын ирц 80-с дээш байж, гишүүд гарын үсэг зурснаар Нөхөрлөлийн дүрэм баталгааждаг.

Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал: Нөхөрлөлийн удирдах дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал (БГХ) юм. Хурлыг сард нэг удаа зарлан, нөхөрлөлийн ахлагч удирдан хийлгэдэг. Нөхөрлөлийн гишүүдийн 80-аас доошгүй хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болох ба хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж хурлын дарга, тэмдэглэл хөтөлсөн хүн гарын үсэг зурж албажуулна. Хурлын шийдвэр нь олонхын саналаар гарах бөгөөд шийдвэрийг бүх гишүүд дагаж мөрдөнө.



Нөхөрлөлийн нэр	АРЦАТ
Нутаг	Тусгал баг, Бугат (20185.2 га)
Байгуулсан огноо	2018.12.12
Нөхөрлөлийн ахлагч	Н.Баярболд
Гишүүдийн тоо:	8 өрх, 15 гишүүн (эрэгтэй 7, эмэгтэй 8)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	Б.Энх-Амгалан, Ж.Бат-Очир
Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
Хамгааллын зүйл:	Монгол тарвага, Баданга хүдэр, Идлэг шонхор, Ойн сан, Бэлчээр
Ололт амжилт	Хүдрийн хууль бус ан ихтэй байсныг эргүүл хяналтаар зогсоосон. Биологийн төрөл зүйлийн тооллого судалгааны олон аргачлалд суралцаж, зэрлэг амьтдын талаарх мэдлэгээ дээшлүүлсэн.

БГХ-ын шийдвэрлэх асуудалд нөхөрлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах, "Байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө"-г хэлэлцэн батлах, хэрэгжилтэд дүгнэлт гаргах, бэлчээрийн даацад тохирох малын тооны дээд хэмжээг батлах, жилд ашиглах дагалт баялгийн хэмжээ, арчилгаа цэвэрлэгээ хийх ойн талбайн хэмжээг тогтоох, бизнес төлөвлөгөө зэрэг ажлын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийн явц, тайланг хэлэлцэх, Дундын сангийн орлого, зардлын төлөвлөгөө/төсөв, гүйцэтгэл, тайланг хэлэлцэх, Дундын сангийн 50%-иас дээш дүн бүхий гэрээ хэлцэл хийх, төсвийг батлах, гүйцэтгэлд дүгнэлт гаргах ХЗ-ийн тайланг хэлэлцэх, гишүүнийг урамшуулах, хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлэх, нөхөрлөлийн бүтэц, орон тоо, зардал, ахлагчийн урамшууллыг тогтоох, УЗ, ХЗ-ийн гишүүд, ахлагчийг томилох, чөлөөлөх, өөрчлөх, хариуцан хамгаалж буй нутаг дэвсгэрт нөхөрлөлийн гишүүн бус өрх айл, мал сүрэг шинээр орж нутаглах эсэх асуудлыг хэлэлцэх, ойн нөхөрлөлийн гэрээгээр эзэмшиж буй ойн санд тухайн нөхөрлөлөөс

бусад гаднын болон мэргэжлийн байгууллага үйл ажиллагаа явуулахыг хүссэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, нөхөрлөлд шинээр гишүүн элсүүлэх, гишүүнээс хасах асуудлыг шийдвэрлэх, ОНТХГ-ын нөхөрлөлийн холбооны удирдлагад төлөөллийг томилох/сонгох, нөхөрлөлийг өөрчлөн байгуулах, татан буулгах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр дүрэмд тусгасан байдаг.



Нөхөрлөлийн нэр	БАЯНБУЛАГ
Нутаг	Баянбулаг баг, Баянбулаг (10227.7 га)
Байгуулсан огноо	2018.11. 14
Нөхөрлөлийн ахлагч	П.Болд-Эрдэнэ
Гишүүдийн тоо:	16 өрх, 28 гишүүнтэй (эрэгтэй 12, эмэгтэй 16)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	Г.Идэрбаатар, Б.Алтан-дөш

Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
--------------------	--

Хамгааллын зүйл: Бүргэд, Шонхор, Тарвага, Бэлчээр

Ололт амжилт	Тариалангийн тоног төхөөрөмж авч 30 га-гаас ногоон тэжээл, тариа, 150 машин тэжээл авч гишүүдийнхээ өрхийн орлогыг нэмэгдүүлсэн. Ургамлын гарц муутай, хадлан тааруу үед хадлангийн талбайгаа хашиж хэрэгцээт хадлангаа авч, амьжиргаанд дэмжлэг болсон. Бэлчээрийг улирлаар сэлгэн нүүж сэргээв.
--------------	---

Нөхөрлөлийн Удирдах зөвлөл: УЗ нь 3-5 гишүүнтэй байх ба тэднийг БГХ-аас нууц санал хураалтаар 2 жилийн хугацаатай сонгоно. БГХ болон нөхөрлөлийн ахлагчийн бүрэн эрхэд хамаарахаас бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх, Дундын сангийн нийт дүнгийн 50%-иас доош дүн бүхий гэрээ хэлцэл, зардлын төсвийг хэлэлцэж шийдвэрлэх, БГХ-ыг зарлах, нөхөрлөлийн ахлагчийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах, хариуцлага тооцох, ИБХ-ийг томилох, ажил үүргийн хуваарийг батлах, үйл

ажиллагаанд хяналт тавих эрхтэй байдаг. УЗ нь БГХ-д хуралд тайлагнах, БГХ-ын шийдвэр, жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, бусад төлөвлөгөөт ажлууд болон цаг үеийн шаардлагатай асуудлуудыг хэлэлцэж, нөхөрлөлийн ахлагчид дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэгтэй. Мөн нөхөрлөлийн тайланг сумын ИТХ, багийн ИНХ, Нөхөрлөлийн холбооны УЗ, оролцогч талууд, олон нийтэд тавих, мэдээлэл хийх, гишүүдийн эрхийг хангах, санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нөхөрлөлийн гишүүдийг сургалт, арга хэмжээнд жигд ижил тэгш хамруулах үүрэгтэй.



Нөхөрлөлийн нэр	БУУРАЛХАНГАЙ
Нутаг	Баянбулаг баг, Нарийн тээл (12011.8 га)
Байгуулсан огноо	2018.12.14
Нөхөрлөлийн ахлагч	Ч. Жавзан
Гишүүдийн тоо:	15 өрх, 28 гишүүнтэй (эрэгтэй 13, эмэгтэй 7)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	Ж.Батсайхан, С.Дэлгэржаргал
Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
Хамгааллын зүйл:	Монгол тарвага, Талын бүргэд, Ойн сан, Бэлчээр
Ололт амжилт	Байгаль орчны эргүүл хяналтыг СМАРТ системээр хийж хулгайн мод бэлтгэл, хулгайн ан, байгаль орчны бусад хууль бус үйл ажиллагааг таслан зогсоход гол анхаарал хандуулж ажилласан. Үр дүн: Хулгайн мод бэлтгэлийг бүрэн зогсоосон.

Нөхөрлөлийн Хяналтын зөвлөл: ХЗ нь 3 гишүүнтэй, тэднийг нөхөрлөлийн БГХ-аас нууц санал хураалтаар 2 жилийн хугацаатай сонгодог. ХЗ нь УЗ ба нөхөрлөлийн ахлагчийн шийдвэр, үйл ажиллагаа нь нөхөрлөлийн дүрэм, төлөвлөгөөний дагуу байгаа эсэх болон гишүүдийн эрх ашигт нийцэж буй эсэхэд хяналт тавих, нөхөрлөлийн бичиг хэргийн хөтлөлтийг шалгах, хөрөнгийн бүртгэл,

зарцуулалт, ашиглалт, санхүүгийн байдлыг хянах, шалгасан ажлын дүн, зөрчлийн талаар БГХ-д танилцуулж шийдвэрлүүлэх, гишүүдийн эрхийн хэрэгжилт, санал гомдлыг хэрхэн барагдуулсныг хянах эрх, үүрэгтэй.



Нөхөрлөлийн нэр	БЯЦХАНЧУЛУУ
Нутаг	Тусгал баг, Жаргалант (16392.8 га)
Байгуулсан огноо	2019.10.10
Нөхөрлөлийн ахлагч	Г.Буяннэмэх
Гишүүдийн тоо:	9 өрхийн 16 гишүүн (эрэгтэй 8, эмэгтэй 8)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	С.Мягмарсүрэн, Ч.Сумъяабаатар
Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
Хамгааллын зүйл:	Ойн сан, Бэлчээр
Ололт амжилт	Жил бүр ой цэвэрлэж, ойг байгалийн аясаар сэргэн ургахад дэмжлэг үзүүлэн ажиллав. Хоёр га талбайд ойжуулалт хийж, ойн цэвэрлэгээ хийх арга зүйд суралцав.

Нөхөрлөлийн ахлагч: Нөхөрлөлийн БГХ-аас олонхын саналаар нөхөрлөлийн ахлагчийг сонгоно. Ахлагч нь БНМ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад нөхөрлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, удирдах, гишүүдэд дүрмийн дагуу шаардлага тавих, үүрэг даалгавар өгөх, биелэлтэд нь хяналт тавих, батлагдсан төсвийг эрхийн хүрээнд захиран зарцуулах, УЗ-өөс олгосон эрхийн хүрээнд холбогдох талууд, нөхөрлөлийн зөвлөх, ИБХ-тай гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, УЗ-ийн хуралд санал оруулах, гишүүдийг идэвхжүүлэх, мэдээллээр хангах, сургалт арга хэмжээнд ижил тэгш жигд хамруулах, нөхөрлөлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг үүрэгтэй. Мөн нөхөрлөлийн ахлагч гүйцэтгэлд үндэслэн урамшуулал авах, БГХ-д нэг саналын эрхтэй.



Нөхөрлөлийн нэр	ЖАРАНТАЙ
Нутаг	Тусгал баг (4506.3 га)
Байгуулсан огноо	2019.10.06
Нөхөрлөлийн ахлагч	Ц. Жаргалсайхан
Гишүүдийн тоо:	15 өрх, 21 гишүүнтэй (эрэгтэй 12, эмэгтэй 9)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	Ш.Ганболд, П.Алтаншагай
Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
Хамгааллын зүйл:	Монгол тарвага, Идлэг шонхор, Бэлчээр
Ололт амжилт	Бэлчээрийн төлөв байдлын судалгааг 3 цэгт хийсэн. Бэлчээр хүчтэй доройтож буй үр дүн гарсан тул зун намрын, өвөл хаврын бэлчээрийг бүхлээр 2 жил өнжөөсөн. Үр дүн: Бэлчээр сайжирсан.

Дундын хуримтлалын бүлгийн ахлагч:

Нөхөрлөлийн Дундын хуримтлалын бүлгийн ахлагч нь сар бүр мэдээллийг нөхөрлөлийн дэвтэрт тэмдэглэж гишүүдэд мэдээлэх, сарын тайланд тусгах, шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтанд мэдээлэх, төсөв хянах, нөхөрлөлийн хурлын шийдвэрийн дагуу төсвийг зарцуулах үүрэгтэй. Мөн нөхөрлөлийн бизнес, санхүүгийн үйл ажиллагааг гүйцэтгэх, баримтжуулах, санхүүгийн бичиг баримт бүрдүүлэх, аливаа тайланг нөхөрлөлийн ахлагчид бэлдэж өгөх, нөхөрлөлийн дотоод ажил, бичиг хэргийн хөтлөлтийг хийх, нягтлах, үр дүнг бүх гишүүдийн хуралд танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулах үүрэгтэй.



Нөхөрлөлийн нэр	МОГОЙХОН
Нутаг	Баянбулаг баг, Захирагч (9404,4 га)
Байгуулсан огноо	2018.12.14
Нөхөрлөлийн ахлагч	Н.Даваахүү
Гишүүдийн тоо:	8 өрх, 14 гишүүнтэй (эрэгтэй 8, эмэгтэй 6)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	Б.Даянбаатар, Ч.Галбадрах
Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
Хамгааллын зүйл:	Монгол тарвага, Баданга хүдэр, Талын бүргэд, Идлэг шонхор, Ойн сан, Бэлчээр
Ололт амжилт	Нөхөрлөл байгуулснаас хойш хулгайн ан гараагүй нь нөхөрлөлийн гол үр дүн болсон.

Нөхөрлөлийн гишүүний андгай:

Нутгийн иргэн нөхөрлөлийн зорилгыг хүлээн зөвшөөрч Хойд Могойн гол—Тээлийн ОНТХГ-ын байгаль хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах үйл ажиллагаанд хамтран оролцохыг хүсэж байгаагаа илэрхийлэн нөхөрлөлд орж өөрийн чадах хэмжээгээр хүчин зүтгэж байгаль орчны аливаа зөрчил гаргахгүй гэдгээ илэрхийлэн нөхөрлөлийн гишүүдийн өмнө андгай өргөж, Андгай бичигт гарын үсэг зурдаг.



Нөхөрлөлийн нэр	НАРАНБУЛАГ
Нутаг	Тусгал баг, Өвөр тээл (5470,0 га)
Байгуулсан огноо	2019.10.10
Нөхөрлөлийн ахлагч	Б.Болдбаатар
Гишүүдийн тоо	9 өрх, 16 гишүүн (эрэгтэй 8, эмэгтэй 8)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	Ц.Алтаншагай
Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
Хамгааллын зүйл:	Идлэг шонхор, Талын бүргэд, Бэлчээр
Ололт амжилт:	Нөхөрлөлийн малчид бэлчээрийг бүхэлд нь өнжөөснөөр, бэлчээр мэдэгдэхүйц сэргэсэн. Хоёр булгийн эхийг хашин хамгаалж, голын эрэг дагуух хогийг жил бүр цэвэрлэснээр нутгийн иргэд хог хаяхгүй болсон. Цэвэрхэн газарт хүн хогоо хаяадаггүй болохыг ойлгосон.

Нөхөрлөлийн гишүүдийн хамтран ажиллах гэрээ: Энэхүү гэрээ нь Монгол Улсын Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах хуулийн 3-р зүйлийн 8-д заасныг үндэслэл болгон хүн бүр хамтран ажиллах зорилго, эрх үүрэг, оролцоо, хариуцлагаа харилцан тохиролцож гишүүд хоорондоо байгуулж буй гэрээ юм. Байгаль орчныг хамгаалах хуулийн 50-р зүйлийн 4-ийн 4-д заасны дагуу энэ гэрээ нь Засаг дарга нөхөрлөлтэй гэрээ байгуулах нэг үндэслэл болдог.



Нөхөрлөлийн нэр	ӨНДӨРХӨТӨЛ
Нутаг	Зуун мод баг, Өндөр хөтөл (2018,8 га)
Байгуулсан огноо	2018.12.12
Нөхөрлөлийн ахлагч	Д.Баттөр
Гишүүдийн тоо:	6 өрх, 12 гишүүнтэй (эрэгтэй 6, эмэгтэй 6)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	Д.Ганчинжалбуу
Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
Хамгааллын зүйл:	Ойн сан, Бэлчээр, Талын бүргэд
Ололт амжилт	Байгаль хамгаалах, ой цэвэрлэх, түймрээс сэргийлэх мэдлэгтэй болсон. Бэлчээрийн даацыг тохируулахаар ажиллаж байна.

Нөхөрлөлийн бизнес төлөвлөгөө: Гишүүдийн амьжиргааг сайжруулах, орлого нэмэгдүүлэх зорилгоор бизнесийн мэргэжлийн зөвлөхийн туслалцаатайгаар нөхөрлөл бүрийн бизнесийн боломж, гишүүдийн ур чадварыг үнэлэн, бизнесийн төлөвлөгөөг оролцооны аргаар хэлэлцэн гаргасан. Сүү цагаан идээ борлуулах, ногоон тэжээл тариалах, блок хийх зэрэг нийт 9 бизнес төлөвлөгөөг 9-н нөхөрлөл боловсруулж хэрэгжүүлснээр ойролцоогоор 396 сая төгрөгийн ашиг олсон байна. Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ЛАСН-ээс тоног төхөөрөмжийн болоод маркетингийн дэмжлэг үзүүлсэн.



Нөхөрлөлийн нэр	ТЭМЭЭНЧУЛУУ
Нутаг	Тусгал баг, Жаргалант (21084,5 га)
Байгуулсан огноо	2018.12.06
Нөхөрлөлийн ахлагч	Ж.Бямбаа
Гишүүдийн тоо:	51 өрх, 79 гишүүнтэй (эрэгтэй 51, эмэгтэй 28)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	Я.Нямбаатар, А.Чулуунпүрэв
Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
Хамгааллын зүйл:	Баданга хүдэр, Ойн сан, Бэлчээр
Ололт амжилт	Мод бэлтгэх эрхийн бичиггүй мод бэлтгэдэг байсан бол одоо бүгд хуулийн дагуу гоожин бичүүлдэг. Нөхөрлөлийн талбайд тусгаарлалт хийж, гишүүд хариуцан авсан ойгоо цэвэрлэсний дүнд, ой байгалийн аясаараа сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлэв.

Нөхөрлөлийн Дундын сан, сангийн хурал: Энэ хурал нь өөр хоорондоо хол зайтай нутагладаг учраас мэдээлэл өгөх хурал зохион байгуулахад гишүүдийн ирцийг сайжруулах нэг арга хэрэгсэл юм. Гишүүдэд бичил зээлийн үйлчилгээнд хамрагдах боломжийг олгох зорилготой хуримтлалын санг байгуулж бүлгийн мөнгөн хуримтлалыг үүсгэн, дүрэм журмаа зөвшилцөж баталсан. Тэдгээрийн хүрээнд бичил зээлийн үйлчилгээг гишүүдэд хүргэдэг. Гишүүн бүр тодорхой хэмжээний санхүүгийн хариуцлага хүлээдэг учраас оролцоо сайжирч 2020 оны 12 сарын байдлаар 80 гаруй сая төгрөгийн хуримтлал бүрдүүлсэн байна.

Эдгээр арга хэрэгслүүд нь нөхөрлөлийн дотоод засаглал, байгаль хамгааллын үйл ажиллагааг зохистой хэрэгжүүлэхэд чиглэсэн нутгийн иргэдийн институцийн мөн чанартай бол энэ бүх тогтолцоо, засаглалын үйл явцыг жигдрүүлэхэд ЛАСН-ээс нэлээн хэдэн арга хэрэгслийн ашигласан бөгөөд эдгээр туршлага нь өөр газар ижил төстэй чадавхжуулах ажлыг хийхэд чухал мэдээлэл болох нь дамжиггүй.



Нөхөрлөлийн нэр	ТЭХ ХАРАЙХ
Нутаг	Тусгал баг, Хошигт (6794.9 га)
Байгуулсан огноо	2018.12.12
Нөхөрлөлийн ахлагч	Ц.Нэргүй
Гишүүдийн тоо:	16 өрх, 31 гишүүнтэй (эрэгтэй 16, эмэгтэй 15)
Идэвхтэн байгаль хамгаалагч:	Д.Отгонбаяр, Д.Наранбаатар
Хуримтлалын бүлэг:	Хуримтлалын сан болон нийгмийн сантай.
Хамгааллын зүйл:	Монгол тарвага, Идлэг шонхор, Талын бүргэд, Хүдэр, Загас, Бэлчээр
Ололт амжилт	Нөхөрлөлийн талбайд хулгайн ан ихтэй байсан. Эргүүл хяналтыг тогтмол зохион байгуулснаар хууль бус агнуур зогссон.

ОНТХГ-н менежментийг хэрэгжүүлэх санхүүжилт. Гурван жилийн хугацаанд ОНТХГ-ын Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гишүүн нөхөрлөлүүд дундын сангаасаа 52 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бол ЛАСН-аас тоног төхөөрөмжийн зардалд 65 сая, гишүүдийн сургалт, үйл ажиллагаанд 204 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж нөхөрлөлүүдийг чадавхжуулсан байна.

2012 онд батлагдсан “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулиар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого орон нутгийн төсөвт төвлөрдөг болсон бөгөөд ойн нөөц ашигласны орлогын 85%, газрын нөөц ашигласны 30%, ус, рашаан ашигласны 35%, ан амьтны нөөц ашигласны 50%, байгалийн ургамлын нөөц ашигласны 15-аас доошгүй хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар заасныг орон нутагт хэрэгжүүлж, ЛАСН-ээс үзүүлж байсан санхүүжилтийн тодорхой хувийг сум, аймгийн төсвөөс нөхөж нэгэнт буй болсон байгаль хамгааллын үр дүнг хадгалах, үргэлжлүүлэх шаардлагатай байгаа юм.

Нөхөрлөлийн гишүүдийн боловсролын хөтөлбөр. ОНТХГ-ын менежмент хийх чадавх буй болгох зорилгоор ойн түймэр, хортноос урьдчилан сэргийлэх, бэлчээр хамгаалах, зэрлэг амьтны тооллого судалгаа хийх, СМАРТ ашиглан эргүүл хийх, гишүүн өрхийн бизнесийн ур чадварыг сайжруулах чиглэлээр 200 гаруй удаагийн сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Боловсролын үйлчилгээ авах боломжгүй нүүдэлчин малчдад шинэ мэдээлэл мэдлэг түгээх нь хөрөнгө шаардсан ажил ч зохистой зөв хэлбэрээр хийж чадвал малчид эерэг бүтээлч хандлагатай болж, хамт олонч, ажил хэрэгч шинж чанар төлөвшин бидний зорилго нэгт хамтран зүтгэгч болдог нь урамтай.

Мэргэжлийн зөвлөл, эксперт техникийн хороод. ОНТХГ-ын биологийн олон янз байдлын мониторинг, ойн судалгаа, бэлчээрийн төлөв байдлын судалгаа зэргийг МУИС, ХААИС, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын багаар хийлгэж тэдний зөвлөмжийн дагуу нөөцийн менежментийн үйл ажиллагаа явуулсан. Мөн нөхөрлөлийн үйл ажиллагаанд Архангай аймгийн БОАЖГ, сумын ЗДТГ, сум дундын Ойн анги зэрэг орон нутгийн байгууллагуудын мэргэжилтнүүд хамтран оролцсон. Тухайлбал, ойн цэвэрлэгээний талбай тусгаарлах ажлыг Архангай аймгийн сум дундын Ойн анги, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад Экологийн цагдаа, бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэхэд Архангай аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо, нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжихэд Булган сумын ЗДТГ-н мэргэжилтнүүд идэвхтэй оролцсон.

Хүний нөөцийн болон цаг хугацааны хөрөнгө оруулалт. Нөхөрлөлийн үйл ажиллагаанд оролцож буй аймгийн БОАЖГ, сумын ЗДТГ-ын ажилтнууд, сум дундын Ойн ангийн мэргэжилтнүүд нь байгууллагын ажил үүргийн дагуу оролцдог бол өөрийн санаачилга, сэтгэлийн дуудлагаар сайн дураараа оролцдог хүмүүс бол ИБХ нар юм. ЛАСН-ээс СМАРТ эргүүл тогтмол хийж, хэрэг зөрчил илрүүлсэн зэрэг гүйцэтгэлд үндэслэн жилд нэг удаа ИБХ нарт урамшуулал олгож ажилласан. ИБХ нь нөхөрлөлийн нутагт байгаль орчны эргүүл хяналт хийх, зэрлэг амьтны ажиглалт, мониторинг хийх, байгаль

орчны эсрэг хууль бус үйлдлийг мэдээлэх, таслан зогсоох, нөхөрлөлийн гишүүдэд мэдээлэл хийх, цагдаагийн болон бусад байгаль орчны талуудтай хамтран ажиллах, гишүүдийг байгаль хамгааллын ажилд татан оролцуулах дайчлах, үйл ажиллагаа санаачлан БГХ-д оруулах эрх үүрэгтэй. Нөхөрлөлийн

холбоонд үнэмлэх бүхий 17 идэвхтэн байгаль хамгаалагч ажиллаж байгаль орчны улсын байцаагч, экологийн цагдаатай хамтран нийт 283 удаагийн байгаль орчны эргүүл хяналт хийж, хулгайн мод бэлтгэл, ан, бусад хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, урьдчилан сэргийлж чадсан.

ОНТХГ-ЫН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

ОНТХГ-ын менежментэд дээрх олон зүйлийн арга хэрэгслийг ашигласнаар байгаль хамгааллын үндсэн зорилгыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүний эрхийг хангах гол зарчмыг тойрсон сайн засаглалыг тодорхой хэмжээнд нутагшуулсан хэмээн үзэж буй юм.

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т амьдарч буй малчин хүн нөхөрлөлд сайн дураар элсэн орж түүний үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах, гарч буй шийдвэрт санал өгөх, шүүмжлэх зэрэг эрх нь нөхөрлөлийн холбооны болон нөхөрлөлийн дүрэмд тусгагдан орсон бөгөөд эдгээр нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу байдаг нь **олон ургалч, хууль ёсны байх** зарчим хэрэгжиж буй явдал юм. Ийнхүү ОНТХГ-т буй иргэд эвлэлдэн нэгдэж нөхөрлөл болсноор ОНТХГ-ын менежментийг хэрэгжүүлэх эрхийг гэрээгээр авсан нь нөөцөд хамгийн ойр институцид давуу эрх олгож **газар дээр нь эрх мэдэл өгөх** зарчим хэрэгжиж байгаагийн илрэл юм.

Нөхөрлөлийн гишүүд БГХ дээр болон УЗ, ХЗ-өөр дамжуулан асуудлаа шийдүүлэх, хуримтлалын бүлгийн ашгийг зохистой шударгаар хүртэх, бусдын эрхийг зөрчсөн бол хохиролгүй болгох, эрх мэдлээ ашиглан давуу эрх эдлэхгүй байх зэрэг гишүүний эрх үүрэг хариуцлага нь бүх дүрэм, төлөвлөгөөнд тусгалаа олж хэрэгждэг нь **шударга байх** зарчмыг биелүүлж байгаа юм.

ОНТХГ-ын менежментийг хэрэгжүүлэхдээ Булган сумын албан ёсны харьяалал бүхий ОНТХГ-т олон жил нутаглан амьдарч буй, нөхөрлөлд хараахан орж амжаагүй иргэн болон нөхөрлөлийн гишүүдийн эрхийг **хохироохгүй байхыг** эрмэлздэг. Харин сумын харьяат биш боловч ОНТХГ-ын нөөцийг ашиглах сонирхолтой бусад иргэд, байгууллагууд (аймгийн төвийн болон Баянхонгор аймгийн харьяат г.м.)

нөхөрлөлүүдтэй албан ёсоор харилцан зөвшилцсөний үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг.

ОНТХГ нь 2023 он хүртэл урт хугацааны менежментийн төлөвлөгөөтэй, түүнд нийцсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, нөхөрлөлийн түвшний төлөвлөгөө зэргийг хэрэгжүүлж байгаль хамгааллын алсын хараа, зорилгодоо хүрэхийн төлөө ажиллаж буй нь **удирдан чиглүүлэх** зарчмыг хэрэгжүүлж байгаа юм.

Эдгээр менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ шаардлагатай бүхий л судалгаа, мониторинг хийж, нөхөрлөл бүрийн нөөц бололцоонд түшиглэн хүн хүчээ дайчилж, шаардлагатай бол гаднын эх үүсвэрээс дэмжлэг олох зэргээр ажилласнаар хамгааллын болон амьжиргааны хувьд тодорхой үр дүнд хүрч **сайн гүйцэтгэлийн** зарчмыг хэрэгжүүлж хэвшсэн. Сумын Засаг дарга нөхөрлөлтэй байгуулсан гэрээ, нөхөрлөлийн гишүүдийн хамтран ажиллах гэрээ, гишүүний андгай зэрэг нь бүгд хариуцлагатай байдлыг зүгшрүүлэх арга хэрэгсэл бөгөөд гүйцэтгэлд хяналт тавих ИБХ, нөхөрлөлийн ахлагч, ХЗ, УЗ зэрэг нөхөрлөлийн удирдлага, хяналтын тогтолцоог нөхөрлөлийн дүрэмд тодорхойлж өгснөөр **хариуцлагатай байх** зарчим хэрэгждэг.

Нөхөрлөлийн дүрэмд *“нөхөрлөлийн удирдах дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал”* хэмээн тодорхойлсноор олонхын саналаар шийдвэр гардаг, удирдлагаа томилдог, чөлөөлдөг, нөхөрлөлийн санхүү, орлого, зардал, дундын өмч хөрөнгө, түүний ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал, гэрээ хэлэлцээр, гишүүдийн урамшуулал, хариуцлага тооцох зэрэг гишүүн бүрд амин чухал асуудлуудыг ил тод хэлэлцдэг, мэдээлдэг, шийдвэрээ өөрсдөө гаргадаг болсноор ил тод байх зарчмыг биелүүлж байна.



ОНТХГ-ын менежментэд нутгийн иргэд оролцсоноор нь хүний эрх, тэр дундаа уугуул нутгийн иргэдийн жам ёсны эрх болох үе уламжлан амьдарч ирсэн нутагтаа эзэн байх эрхээ эдэлж, байгалийн нөөцөө зүй зохистой ашиглах улмаар үр удамдаа унаган төрхөөр нь үлдээх үүрэг хүлээх боломжтой болж байгаа **хүний эрхийг дээдлэх** зарчмын бодит биелэл юм.

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын засаглалын байдлын бүрэн тодорхойлж дүн шинжилгээ хийсний эцэст тус газар нь төрийн болон төрийн бус төлөөлөл бүхий хамтын засаглалын хэлбэртэй, оролцогч тал бүр

хуулийн дагуух эрх мэдэл, үүрэг хариуцлагын хүрээнд ОНТХГ-ын менежментэд оролцдог нь харагдаж байна.

Засаглалын хоёр дах хэмжээс болох засаглалын чанарын хувьд сайн засаглалын гол зарчмуудыг дотоод дүрэм журамдаа тусгаж, тэдгээрийг олон зүйлийн арга хэрэгслээр мөрдөн ажилладаг, эдгээр нь зөв зохистой байгаа нь ХБСХ-ээс хийсэн хөндлөнгийн үнэлгээний үр дүнгээс харагдлаа. Гагцхүү засаглалын эдгээр ололт амжилтыг орон нутгийн төрийн удирдлагын бүтэц, үүрэг хариуцлагын тогтолцоонд суулгаж нутагшуулах нь чухал болж байна.

ДҮГНЭЛТ, СУРГАМЖ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү номын нэгдүгээр бүлэгт дэлхийн шилдэг эрдэмтэн мэргэжилтнүүдийн зөвлөмжийг үндэслэн БХОУХ-ноос тодорхойлсон ТХГН-ийн үндсэн ухагдахуун, ойлголтуудыг хөрвүүлж тайлбарласан билээ. Эдгээр нь орчин үеийн ТХГН-ийн системд менежментийн стандарт, иш загвар болдог гэж үзвэл манай орны системд нутагшуулж хэвшүүлэх олон зүйлс байгааг харж болно. Юуны өмнө ТХГН хэмээх ойлголтыг үг үгээр нь нарийвчлан тодорхойлсон нь (Хүснэгт-1) хүмүүсийн зөрүүтэй ойлголт, байр суурийг нэгтгэсэн бөгөөд ийм сайн тодорхойлолт манай холбогдох баримт бичигт хараахан ороогүй байна. БХОУХ-ны ТХГН-ийн зургаан ангиллын тухай бид дуулсан ч онгон зэрлэг байдал, хүний үйл ажиллагаанд өртсөн зэрэглэлээс нь (Зураг-1) хамааран хамгаалах газрыг менежментийн зорилгоор нь ийнхүү хуваадаг тухай ойлголт бага байжээ. Ийнхүү ангилснаар төлөв байдал нь янз бүрийн түвшинд байгаа их хэмжээний газрыг хамгаалалтад авч болох боломжийг нээж өгч байгаа нь зөвхөн онгон зэрлэг хөндөгдөөгүй газрыг хамгаалдаг гэсэн ташаа ойлголтыг үгүйсгэж байгаа юм.

Нөгөө талаас ТХГН нь байгалийг хүнээс хамгаалах бус хүн төрөлхтний сайн сайхны төлөө, хойч үеийнхээ төлөө хамгаалж буй гэдгийг ТХГН-ийн засаглалын зарчмуудаас, ялангуяа, тэдгээрийн “зүрх” болсон хүний эрхийг дээдлэх зарчмаас харж болно. Энэхүү зарчмаас үүдэн хамгааллын талаарх шийдвэр гаргах гол эрх мэдэл, хүчин чадал, хариуцлага ямар субъектэд байгаагаас хамааран төрийн, хамтын, хувийн, нутгийн

иргэдийн засаглалын хэлбэртэй байдаг. Үүний цаана байгаль хамгаалах сонирхолтой, түүнд хөрөнгө оруулалт хийхэд бэлэн аль ч хэвшлийн хариуцлагатай этгээдэд эрхийг олгох зорилго байна. Ингэснээр ямар ч өөрчлөлтөд орсон газрыг хариуцлагатай, менежмент хийх хүчин чадалтай этгээд хийж болдог болсноор хамгаалагдах газрын хэмжээ, төрөл зүйл олширч байгальдаа ч хүндээ ч ашигтай үр дүн гарах ажээ. Үүнийг хялбархан харж болох хэрэгсэл бол ТХГН-ийн менежментийн болоод ангиллын олон янз байдлыг харуулдаг матриц (Хүснэгт-5) юм.

ТХГН-ийн засаглалд хамаатай талуудыг давуу эрхтэй ба оролцогч тал хэмээн салгаж авч үзэж байгаа нь мөн л хүний эрхийн тулгуур зарчмыг хэрэгжүүлж байгаагийн нэг илрэл бөгөөд байгалийн нөөцөөс ашиг олох өрсөлдөөн явагдаж буй өнөөгийн неолиберал дэлхийд нутаг усандаа хэдэн үеэрээ тогтвортой ашиглалт хийсээр ирсэн нутгийн иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг хамгаалахад чиглэж буй юм. Ийм орон нутгийн бичил орчинд буй талуудаас эхлээд даян дэлхийн олон улсыг нэгтгэсэн оролцогчдыг хамруулан байгалийн тусгай хамгаалал явуулахад засаглалын олон түвшин байгаа, харин тэдгээрийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах механизм нь чухал байдаг. Үүнээс үүдэн “төвлөрлийг сааруулах”, “эрх мэдлээ шилжүүлэх”, “газар дээр нь эрх мэдлийг өгөх” зэрэг хэлбэрээр дээд түвшний шийдвэрийг нөөцөд ойр байгаа талд шилжүүлэх үйл явц газар авч байгаа нь тухайн нутагт байгаа хүмүүст ашигтай юм.

ТХГН-ийн засаглалд олон түвшний олон талууд оролцож, үндсэн зарчмуудаа мөрдөж ажиллах замаар үндсэн зорилго болох биологийн олон янз байдал, соёлын үнэт зүйлсийг хамгаалах нь ихээхэн ярвигтай асуудал билээ. Чухамдаа ТХГН-ийн менежментийн зорилгыг хэрэгжүүлэхийн сацуу засаглалын чанарыг сайн байлгах нь мэдлэг, ур чадварыг сорьсон зүйл учраас менежментийн зохих хүчин чадалтай байж олон зүйлийн арга хэрэгслийг ашиглахыг шаарддаг. Бид эдгээр хүчин чадал бүрэн хэмжээнд байж, арга хэрэгсэл олон байх тусмаа хамгааллын ажил амжилттай байх магадлал их тухай өгүүлсэн.

Номын хоёрдугаар бүлэгт ТХГН-ийн энэхүү үзэл баримтлалын хүрээг ашиглан манай улсад байдал ямар түвшинд байгааг нягтлан үзэхийг хичээлээ. ТХГН-ийн эрх зүйн орчны хувьд шинэчлэл өөрчлөлт зайлшгүй шаардлагатай, сүүлийн үед олон улсын ТХГН-ийн системд гарч буй онол практикийн шинэ ухагдахуун ойлголтыг тусгах хэрэгцээ гарч байгааг хүлээн зөвшөөрч холбогдох ажлууд хийгдэж байна. Ялангуяа, ТХГН-ийн менежментийн харилцаа нь ихэвчлэн нийтээр мөрдөх хэм хэмжээний хүрээнд зохицуулагдаж тэдгээрт ашиглалтын асуудал зонхилж байгаа нь харагдлаа.

ТХГН-ийн ангиллын хувьд манай улс энэхүү арга хэрэгслийг бүрэн дүүрэн ашиглаж хараахан чадахгүй байгаа бөгөөд ялангуяа, нэлээд өөрчлөлтөд орсон газар дээр эрчимтэй менежмент хийх шаардлагатай **V** ангилал, нутгийн иргэдийн байгалийн нөөцөө хамгаалах, зохистой ашиглах эрхийг өгдөг **VI** ангилал байхгүй байна. Нөгөө талаас, ТХГН-ийг тодорхойлогч мөн чанар болох *"удирдлага, зохион байгуулалттай байх"* гэдэг шалгуур үзүүлэлтийг хангадаггүй байгалийн нөөц газар, дурсгалт газрын менежментийг хийх засаглалын шинэ хэлбэр гаргаж эрх зүйн баримт бичигт оруулах нь зөв алхам юм. Одоогийн ТХГН-ийн ангиллуудын менежментийн зорилго, хоорондоо ялгарах онцлог зэрэг нь ихээхэн ерөнхий, цаашид нарийвчлан, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох шаардлага буй (Хүснэгт-6) бөгөөд ингэснээр шинээр авч буй газрын хамгаалалтад авах үндэслэл боловсруулах, одоо хамгаалалтад буй газруудын менежментийн арга хэлбэрийг сайжруулахад чухал.

Засаглалын хэлбэрийн хувьд манай улсад төрийн засаглал зонхилж цөөн тооны хамтын менежментийн засаглалын хэлбэр байна. Иймээс ТХГН-ийн удирдлага нь төрийн нөөц, санхүүжилтээс хэт хараат болсноос зарим (БНГ, ДГ) ТХГН нь түүнийг тодорхойлох шинж чанар, шалгуур үзүүлэлтдээ нийцэхгүй байдалтай, бусад хэлбэрийн засаглал хууль эрх зүйн баримт бичигт тусгалаа олж зөвшөөрөгдөөгүй байна.

Засаглалын зарчмын талд манай тулгуур эрх зүйн баримт бичгүүдэд хүний эрхийг дээдлэх зарчмыг тодорхой тунхагласан хэдий ч ТХГН-ийн холбогдолтой эрх зүйн актуудад тусгалаа олсон нь багахан, эсвэл ихээхэн ерөнхий байдалтай байна. Мөн хүний эрхийг тойрсон бусад зарчмууд манай ТХГН-ийн баримт бичигт төдийлөн сайн ороогүйгээс аливаа менежментийн үйл ажиллагаанд мөрдөгдөлгүй засаглалын чанарт сөргөөр нөлөөлж улмаар ТХГН-ийн менежментийн зорилгоо хэрэгжүүлэхэд чөдөр тушаа болж байгаа нь илэрхий.

Манай улсын ТХГН-ийн хамгийн түгээмэл хэлбэр нь ОНТХГ хэдий ч өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын журмаар үйл ажиллагаа нь зохицуулагдаж, ТХГН-ийн хуулийн албан ёсны ангилалд ороогүй байна. ОНТХГ нь тухайн орон нутгийн засаг захиргаа хамгааллын төсөв, менежментээ шийдэж чадвал байгалийн нөөцөө зохистой ашиглахыг хүссэн нутгийн иргэдийн санаачилгыг дэмжин БНХМН байгуулж гэрээгээр ажиллах замаар тэднийг нутаг ус, бэлчээрээс нь салгаж холдуулахгүй давуу талтай учраас ийнхүү түгээмэл байгаа юм. Гагцхүү нутгийн иргэд болон орон нутгийн засаг захиргаанд засаглалаа чанартай сайн явуулах хүчин чадал, арга хэрэгсэл дутаж байгаагаас амжилттай менежмент хийж хамгааллын зорилгоо биелүүлж чадаж байгаа нь хуруу дарам цөөн байна.

Иймд ЛАСН-ийн дэмжлэгтэй Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т загвар менежмент буй болгож номын гуравдугаар бүлэгт тайлбар, дүн шинжилгээ хийсэн билээ. Тус ОНТХГ нь хамгааллын үнэт зүйлсийн суурь түвшнийг зохих хэмжээнд тодорхойлж тогтмол хяналт мониторинг хийдгийн ачаар зүйлийн тоо толгой, төлөв байдалд гарч буй өөрчлөлтийг тогтоож чадаж байгаа ба үр дүн сайтай өссөн үзүүлэлттэй байгааг бид харсан. Ялангуяа,

СМАРТ эргүүл хэмээх мэргэжлийн байгаль хамгаалагч нарын ашигладаг аргаар малчид ажиллаж туршсан нь дэлхийд сонирхолтой тохиолдол болж байгаа билээ.

Байгаль хамгааллын жинхэнэ утга учир нь хүний амьдралын сайн сайхныг хангах, байгалиас хүн авдаг экосистемийн үр өгөөжийг урт хугацаанд үргэлжлүүлэх зорилго учраас ОНТХГ-т амьдарч буй малчдын амьжиргааг байгаль хамгаалах зорилготой уялдуулах нь менежментийн гол стратеги юм. ОНТХГ-ын менежментэд малчдыг татан оролцуулах гол үндэс бол тэдний нутаг усаа хайрлах, хүндэтгэх, сүсэглэх үнэт зүйл бөгөөд үүнийг төрөл бүрийн мэдээлэл сургалт өгөх, санхүү эдийн засгаар дэмжих, бизнес эрхлэх боломж олгох хэлбэрээр амьдралын чанараа сайжруулах ашиг сонирхолтой нь холбож ажиллавал илүү үр дүнтэй байна.

ОНТХГ-ын менежментийг албан институцийн хэлбэрт оруулж холбооны (federal) бүтэцтэй болгон хамгааллын үйл ажиллагаа явуулж буй арга хэрэгслүүд нь ч ийм шатлалаар байсан нь угтаа нүүдэлчдийн уламжлалт аравт, зуут, мянгатын зохион байгуулалттай ижил, томрохын хэрээр хамрах цар хүрээ тэлж ландшафтын түвшний менежмент хийх боломжтой болж байгаа юм. Ийнхүү институцийн зарчмаар ажилласнаар дүрэмд захирагдах, ардчилсан шийдвэр гаргаж сурах, үүнийг хэрэгжүүлэх гол хэлбэр болох хурал, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох, эрх үүргээ ухамсарлаж, бусдын эрх үүргийг мөн хүндэтгэх гэхчлэн олон шинэ зүйлд суралцсан байна. ОНТХГ-ын засаглалд оролцогч талууд хамтран ажиллаж тус тусын үүрэг хариуцлагын дагуу менежментийн үйл ажиллагаа явуулж зүгширч эхэлсэн нь эерэг үр дүн боллоо. Түүнчлэн менежментийн олон арга хэрэгслийг янз бүрийн түвшинд ашигласан нь хамгааллын (амьтдын тоо толгой өсөж, хууль бус үйл ажиллагаа зөрчил буурсан) болон амьжиргааны (ядуурал буурч, орлогын эх үүсвэр нэмэгдэж, дундаж орлого өссөн) бодит үр дүнд хүрсэн чухал хүчин зүйл юм.

Эдгээр эерэг үр дүнд хүрэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл бол сайн засаглал юм. Малчдын хувьд сайн засаглалын хэлбэр болох хуралдах, хэлэлцэх, бичиг баримт хөтөлж шийдвэрээ баталгаажуулах, үйл ажиллагаа төлөвлөх гэх мэтийн тэдний хувьд шинэ, итгэлтэй хийж чадахгүй эдгээрт түүртэх нь зүй

ёсны асуудал ч энэ цаг хугацааны бэрхшээл юм. Ерөнхийдөө манайд боловсролын түвшин боломжийн сайн байдгаас малчдын байгууллагад дээрх үүрэг хариуцлага хүлээх хүн олддог бөгөөд бас ур чадварын хувьд холимог хүмүүсийн нэгдэл үүсгэх нь ийм давуу сайн талтай байдаг.

Засаглалын тулгуур зарчим нь хүний эрхийг хүндэтгэх учраас ОНТХГ-ын менежментийн эдгээр зарчмыг үйл ажиллагаа бүрд мөрдөж зохистой чиглүүлж чадвал хүний язгуур эрх ашигт нийцсэн байдгаас хэрэгжүүлэхэд төдийлөн бэрхшээлтэй бус. Хамгийн ярвигтай зүйл бол ОНТХГ-т ямар нэг бизнесийн ашиг сонирхолтой улс төрийн, бизнесийн эрх мэдэлтэй этгээд оролцох явдал бөгөөд энэ нь нутгийн иргэдийг хуваан талцуулах, ТХГН-ийн засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд томоохон саад тотгор болдог.

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т менежмент хийсэн туршлагаас үзэхэд ОНТХГ нь манайд хамгийн түгээмэл иргэдийн дуртай ТХГН-ийн менежментийн хэлбэр бөгөөд цаашид үүнийг БХОУХ-ны VI ангиллаар хуульчилж ТХГН-ийн системд хамруулан манай улсад өргөн тархсан БНХМН-ийн холбогдох эрх зүйн статусыг тодорхой болгох цаг нь болсон байна.

Үүнтэй уялдуулан тэдний үйл ажиллагаа, менежмент явуулах санхүүжилтийг тодорхой зааж орон нутгаас шийдвэрлэж буйг хянаж хэрэгжилтийг сайжруулах нь чухал. Тухайлбал, 2012 онд батлагдсан “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулиар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого орон нутгийн төсөвт төвлөрдөг болсон бөгөөд ойн нөөц ашигласны орлогын 85%, газрын нөөц ашигласны 30%, ус, рашаан ашигласны 35%, ан амьтны нөөц ашигласны 50%, байгалийн ургамлын нөөц ашигласны 15-аас доошгүй хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар заасан нь бодитой гарц бөгөөд гагцхүү хэрэгжилтийг хэвшүүлэх хэрэгтэй байна.

БНХМН-ийг санхүүжүүлэх өөр нэг эх үүсвэр бол “Малын тоо толгойн албан татварын тухай” хууль, “Төсвийн тухай” хууль бөгөөд үүний дагуу багийн иргэдийн хурлын саналыг үндэслэн төсөв, зарцуулалтыг БНХМН-үүдтэй зөвшилцөж, тэдний саналд үндэслэн төлөвлөж болно.

БНХМН-ийг санхүүжүүлэх зардалд тэдний хийж буй биологийн төрөл зүйлийн мониторинг, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилготой эргүүл хяналтын зардал болон идэвхтэн байгаль хамгаалагчдыг урамшуулал багтах ёстой юм.

Нөгөөтэйгүүр эргүүл хяналтын бүс нутгийн улсын хэмжээнд хийх, дата мэдээлэл цуглуулах, гүйцэтгэлийг хянахад дэлхийд нэвтэрч буй СМАРТ хяналтын системийг нэвтрүүлэх, ТХГН-ийн системийг хамруулан ашиглаж сурах явдал тулгамдаж байна.

АШИГЛАСАН БҮТЭЭЛ

1. Borrini-Feyerabend, G., et al. (2013). *Governance of Protected Areas: From understanding to action* (Vol. Best Practice Protected Area Guidelines Series No. 20). Gland, Switzerland: IUCN.
2. Djossa, C. (2018). These are the World's first National parks Retrieved March 3 2021, from <https://www.nationalgeographic.com/travel/national-parks/article/worlds-first-protected-lands-conservation-yellowstone>
3. Dudley, N. (2008). Guidelines for Applying Protected Area Management Categories. In S. Stolton, P. Shadie & N. Dudley (Eds.), (2013) *IUCN WCPA Best Practice Guidance on Recognising Protected Areas and Assigning Management Categories and Governance Types* (Best Practice Protected Area Guidelines Series No. 21 ed., pp. x + 86). Gland, Switzerland: IUCN.
4. Hannam, I. (2009). Final report on the Assessment of environmental laws of Mongolia. Ulaanbaatar: Strengthening environmental governance in Mongolia project MON/07/104.
5. MEA. (2005). Ecosystems and Human Well-being: Synthesis J. Sarukh6n & A. Whyte (Eds.),
6. Reading, R., et al. (2016). From "paper park" to model protected area: the transformation of Ikh Nart nature reserve, Mongolia. *Parks*, 22(2), 41-54. doi: 10.2305/IUCN.CH.2016.PARKS-22-2RR.en
7. UNDP. (2018). Terminal Evaluation Report: Mongolia's Network of Managed Resource Network Areas.
8. UNEP-WCMC. (2021). Protected Area Profile for Mongolia from the World Database of Protected Areas Available at: www.protectedplanet.net
9. UNEP-WCMC, I. a. N. (2021). Protected Planet Live Report 2021. from UNEP-WCMC, IUCN and NGS Available at: www.protectedplanet.net
10. БОАЖЯ. (2018). *Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018*. Улаанбаатар.
11. БОАЖЯ. (2020). Газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл боловсруулах аргачилсан заавар, маягт. Улаанбаатар: Дэлхийн байгаль хамгаалах сан.
12. БОАЖЯ. (2021a). Байгаль орчны мэдээллийн сан: Орон нутгийн ТХГН-ийн мэдээллийн сан. вэбсайт: eic.mn
13. БОАЖЯ. (2021b). *Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын тайлан*. Улаанбаатар.
14. Д.Мягмарсүрэн, et al. (2012). *Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгууд*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
15. П.Ариунсүрэн. (2021). Хойд Могойн гол-Тээлийн Орон нутгийн тусгийн хамгаалалттай газрын бэлчээрийн үнэлгээний тайлан (pp. 35). Улаанбаатар.
16. С. Гомбобаатар, П. Д. (2021). *Хангайн уулархаг нутгийн нугаламт амьтад: хөтөч*. Улаанбаатар: Адмон.
17. ХБСХ. (2021). Ойт хээрийн экосистем, түүний ховордсон зүйлүүдийг нутгийн иргэдтэй хамгаалах нь төслийн эцсийн үнэлгээ: Судалгааны тайлан. Улаанбаатар: Хараат бус судалгааны хүрээлэн.
18. Ч.Буянбадрах. (2019). *Монгол орны лавлах*. Улаанбаатар: Адмон.
19. Я.Адъяа. (2007). *Байгаль орчин 20 жил*. Улаанбаатар: Адмон.
20. А.Болд, С.Дуламцэрэн, Д.Цэнджав. 1976. Хангайн уулархаг районы агнуурын амьтныг зөв зохистой ашиглах асуудалд. Ерөнхий ба Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл, 10:56-72.
21. Б.Оюунгэрэл. 2017. Хойд Могойн гол, Тээл орчмын нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэл, Улаанбаатар
22. Д.Цэнджав, Ч.Бүжинханд. 2000. Баданга хүдрийн одоо ба ирээдүй (*Moschus moschiferus* L., 1758) Жинст харгана хэвлэлийн компани, Улаанбаатар.
23. Э.Кларк, Ж. Мөнхбат. 2006. Монгол орны хөхтөн амьтны Улаан данс.

ХАВСРАЛТ

Хавсралт-1. ТХГН-ийн холбогдолтой хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд

Баталсан огноо	Хууль тогтоомж
1994.11.25	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай
1995.03.30	Байгаль орчныг хамгаалах тухай
1997.10.23	Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай
1997.04.24	Газрын төлбөрийн тухай
2000.05.05	Аялал жуулчлалын тухай
2002.06.27	Газрын тухай
2012.05.17	Ойн тухай
2012.05.17	Усны тухай
2012.05.17	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай
2012.05.17	Амьтны тухай
2015.12.03	Эрүүгийн тухай
2017.05.11	Зөрчлийн тухай
2017.05.12	Хог хаягдлын тухай
Бодлогын баримт бичгүүд	
УИХ-н тогтоол	
1997.12.26	Төрөөс экологийн талаар баримтлах бодлого
1998.04.09	Тусгай хамгаалалттай газрын үндэсний хөтөлбөр
2010.05.20	"Ус" үндэсний хөтөлбөр
2011.01.06	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр
2014.06.13	Ногоон хөгжлийн бодлого
2015.05.14	Төрөөс ойн талаар баримтлах бодлого
2016.02.05	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
2020.05.13	Алсын хараа -2050 урт хугацааны бодлого
Засгийн газрын тогтоол	
2010.04.14	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр
2011.04.09	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр
2011.09.21	Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр
2014.02.07	Ойн цэвэрлэгээ үндэсний хөтөлбөр
2015.08.04	Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
2015.08.04	Монгол орны биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр

Хавсралт-2. Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын нөхөрлөлүүд, түншүүдийн туршлага судалсан байгууллага

№	Туршлага судалсан байгууллагууд
1	Увс аймаг, УНАСГТХГ-ын хамгаалалтын захиргааны мэдээллийн төв
2	Увс аймгийн Түргэн сумын "Хавцлын буурал" Хадгаламж зээлийн хоршоо
3	Увс аймгийн Түргэн сумын "Баян Эрдэнэ Рашаант Хайрхан" Хоршооны Арьс, шир боловсруулах үйлдвэр
4	Увс аймгийн Гулзат ОНТХГ, Бөхмөрөн сумын Гулзат-1, Гулзат-2, Сагил сумын Цагаан шувуут, Саальт хүрэн, Аргалт хариг, Үүрэг нуур, Их наяд нөхөрлөлүүд, "Гулзатын санаачлага" ТББ
5	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, "Малчны хөгжил" Хадгаламж зээлийн хоршоо
6	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын "Малчдын холбоо" ТББ, М6 хөтөлбөр, "Цэнгэл буян" ТББ
7	"Малчны хөгжил" Маркетингийн хоршооны махны үйлдвэр, ноосны анхан шатны боловсруулалтын агуулах
8	Баян-Өлгий аймгийн "Жасыл алхап" Хоршооны Гүн Цагаан идээний цех
9	Ховд аймгийн Дөргөн сумын БНХМ-ийн Бумбатын хишиг, Ноёлогч, Мөнгөн ембүү, Баянбүдүүн, Дарви сумын Сутайн баялаг-мөрөн, Баянхөхвөр, Баян бумбатаа, Тунгалаг урт нөхөрлөлүүд
10	Ховд аймгийн Чандмань сум, БНХМ-н нөхөрлөлүүдийн "Дөргөн хатан" жуулчны эко бааз

ХОЙД МОГОЙН ГОЛ-ТЭЭЛИЙН ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАРТ СААТАН МОРИЛНО УУ.



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.
Утас: 319658, 70140459
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn